

**ПАРЛАМЕНТ ДАХЬ ЦӨӨНХИЙН БҮЛЭГ БУЮУ СӨРӨГ ХҮЧИН:  
ОНОЛ АРГА ЗҮЙ, ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА МОНГОЛ УЛСЫН  
БОЛОН ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

(Харьцуулсан судалгаа)

*Ц.Норовдондог (Ph.D.), Э.Дашзэвэг, Г.Билгээ, Д.Халиун,  
Ц.Ариунаа, Э.Билгүүн, И.Жаргалзаяабямба, Р.Нургүл,  
П.Уранчимэг, Т.Эрдэнэчимэг, Х.Очир*

**АГУУЛГА**

УДИРТГАЛ

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

СУДАЛГААНЫ ХЭСЭГ

НЭГ. АРДЧИЛСАН ПАРЛАМЕНТ ДАХЬ ЦӨӨНХИЙН БҮЛЭГ БУЮУ СӨРӨГ  
ХҮЧИН: ОНОЛ АРГА ЗҮЙ, ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА

- 1.1.Нэр томъёоны тодорхойлолт
- 1.2.Сөрөг хүчин буюу хууль тогтоох цөөнхийг хүлээн зөвшөөрөх асуудал
- 1.3.Сөрөг хүчний тэргүүний парламент дахь байр суурь
- 1.4.Сөрөг хүчний тэргүүнийг томилох асуудал
- 1.5.Сөрөг хүчний эрх, үүрэг
  - 1.5.1.Засгийн газарт хяналт тавих
  - 1.5.2.Төрийн байгууллагуудын томилгоотой холбоотой эрх
  - 1.5.3.Сөрөг хүчний тэргүүний бусад эрх, үүрэг
- 1.6.Цөөнхийн хориг тавих болон зөвшилцөх эрх

ХОЁР. ПАРЛАМЕНТ ДАХЬ ЦӨӨНХИЙН БҮЛЭГ БУЮУ СӨРӨГ ХҮЧНИЙ  
ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

- 2.1.Австрали Улс
- 2.2.Герман Улс
- 2.3.Нидерланд Улс
- 2.4.Өмнөд Солонгос Улс
- 2.5.Финланд Улс
- 2.6.Франц Улс

## ГУРАВ. УИХ ДАХЬ ОЛОН НАМЫН ОРОЛЦОО БА УИХ ДАХЬ ЦӨӨНХИЙН БҮЛЭГ БУЮУ СӨРӨГ ХҮЧНИЙ ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

3.1.УИХ дахь олон намын оролцоо (1990-2020 он)

3.2.УИХ дахь цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийн талаарх эрх зүйн  
орчин

### АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

ХАВСРАЛТ. УИХ-ын тухай хуулиудад намын бүлэг, цөөнхтэй холбоотой  
үндсэн зохицуулалт тусгагдаж ирсэн талаарх харьцуулалт

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

## УДИРТГАЛ

Улсын Их Хурлын 2019 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Их Хурлын 2019-2024 оны стратеги төлөвлөгөө”-ний 1.1.3-т “Улсын Их Хурал нь цөөнхийг хүндэтгэж, түүний үйл ажиллагаанд хуулийн хүрээнд дэмжлэг үзүүлж, Улсын Их Хурлын гишүүд, ажлын албаны ажилтнуудын ажиллах нөхцөл, боломжийг сайжруулах талаар анхаарч ажиллах” гэж, 5.1.2-т “Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагааг шинжлэх ухааны үндэслэл бүхий нотолгоонд суурилсан судалгаа, мэдээлэл, лавлагаагаар хангаж дэмжлэг үзүүлэх судалгаа, шинжилгээний хүрээлэн байгуулах асуудлыг шийдвэрлэх” гэж заасан.

Мөн Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн даргын 2020 оны 295 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын 2019-2024 оны стратеги төлөвлөгөө”-ний 3.6.1-т “Улсын Их Хурал шийдвэрээ шинжлэх ухааны үндэслэлтэй, дүн шинжилгээ бүхий судалгаа шинжилгээ, баримт нотолгоонд тулгуурлан гаргахад дэмжлэг үзүүлэх үр нөлөөтэй механизм бүрдүүлэх” гэж заасан.

Дээрх стратеги төлөвлөгөөний зорилтуудыг хэрэгжүүлэх болон Монгол Улсын Их Хурлын багц хуулийн төслүүдийг боловсруулж, хэлэлцүүлэх үйл явцад судалгаа, мэдээллийн дэмжлэг үзүүлэх зорилгоор Парламентын судалгаа, сургалтын хүрээлэнд “Парламент дахь цөөнхийн бүлэг буюу сөрөг хүчин: онол арга зүй, олон улсын чиг хандлага, Монгол Улсын болон гадаадын зарим улсын эрх зүйн зохицуулалт” сэдэвт төлөвлөгөөт судалгааны ажлыг гүйцэтгэв.

### **Судалгааны зорилго**

- 1) парламент дахь цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийн эрх зүйн байдал, эрх, үүрэг, үйл ажиллагааны онол арга зүйн үндэс, олон улсын жишиг, сайн туршлага, эрх зүйн зохицуулалтын суурь зарчмуудыг судлах;
- 2) гадаадын зарим улсын парламент дахь цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийн үйл ажиллагаа, түүний эрх зүйн зохицуулалтын талаарх туршлагыг харьцуулан судлах;
- 3) Монгол Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийн үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын өөрчлөлт шинэчлэлтийн товчоон болон өнөөгийн нөхцөл байдлыг судлах.

### **Судалгааны хамрах хүрээ**

Энэхүү судалгаанд ардчилсан парламент дахь цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийн үйл ажиллагааны онол, арга зүйн үндэслэл, эрх, үүрэг, олон

улсын жишиг болон сайн туршлагыг Олон Улсын Парламентын Холбоо (IPU), Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн (International IDEA)-ээс гаргасан зөвлөмж, судалгааны тайлан, дүгнэлт, мөн Монгол Улсын болон дор дурдсан (Австрали, Герман, Нидерланд, Өмнөд Солонгос, Финланд, Франц) улс орнуудын парламент дахь цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийн үйл ажиллагааны эрх зүйн орчны хүрээнд харьцуулан судалсан болно.

### **Судалгааны бүтэц**

Судалгаа нь хураангуй болон үндсэн хэсэгтэй. Судалгааны үндсэн хэсэг нь гурван бүлэгтэй:

- *нэгдүгээр бүлэгт*, ардчилсан парламентад цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийн үүрэг роль: цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийн статус, эрх, үүрэг, үйл ажиллагааны онол, арга зүйн үндэслэл, олон улсын жишиг, сайн туршлага, эрх зүйн зохицуулалтын суурь зарчмууд;
- *хоёрдугаар бүлэгт*, гадаадын зарим улсын парламент дахь цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийн үйл ажиллагаа, түүний эрх зүйн зохицуулалтын талаарх туршлага;
- *гуравдугаар бүлэгт*, Монгол Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийн эрх, үүрэг, үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтын өөрчлөлт шинэчлэлтийн товчоон болон өнөөгийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг тус тус судалсан болно.

**Түлхүүр үг:** парламент, парламентын бүлэг, парламент дахь сөрөг хүчин, сөрөг хүчний нам, сөрөг хүчний тэргүүн, хууль тогтоох цөөнх, парламент дахь цөөнх.

**Key words:** parliament, parliamentary group, opposition in parliament, opposition party, leader of the opposition, legislative minorities, minorities in parliament.

УИХ.МН  
СУДАЛГААНЫ САН

## СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

### ***Ардчилсан парламент дахь цөөнхийн бүлэг буюу сөрөг хүчин: онол арга зүй, олон улсын чиг хандлагын талаар***

Орчин үед ардчилал гэдгийг зөвхөн олонхын засаглал төдий биш, өргөн хүрээндээ хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалыг хүний үндсэн эрх, хууль дээдлэх ёс, төрийн эрх мэдлийн хяналт-тэнцэл, шударгаар захирах ёс, иргэдийн оролцоо, нээлттэй хэлэлцүүлэг зэрэг арга хэрэгслүүдтэй хосолсон улс төрийн тогтолцоо хэмээн тодорхойлж байна. Тиймээс ардчилсан улсууд парламент дахь сөрөг хүчин, эсхүл цөөнхийн эрх, үүрэг, хариуцлагыг албан ёсоор үндсэн хууль болон бусад хуулиараа хүлээн зөвшөөрч баталгаажуулсан байдаг. Хэлбэрийн хувьд зарим улсын үндсэн хуульд сөрөг хүчин, эсхүл цөөнх, тэдгээрийн эрх, үүргийн талаар зөвхөн ерөнхий байдлаар тусгаж ихэнх нарийвчилсан зохицуулалтыг парламентын болон дэгийн хууль тогтоомжийн хүрээнд тодорхойлж байна. Энэтхэг зэрэг цөөн улсууд үндсэн хуулиараа нарийвчлан зохицуулсан байдаг.

“Сөрөг хүчин”, “парламент дахь цөөнх”-ийн тухай ойлголт, тэдгээртэй холбоотой зохицуулалтууд нь засаглалын хэлбэр, төрийн байгууламж, эрх зүйн бүл зэргээс хамаарч зарим тохиолдолд ижил төстэй, зарим тохиолдолд өөр өөр утга агуулгаар томъёологдсон байх төдийгүй үндсэн зохицуулалтуудын хувьд ч харилцан ялгаатай талуудтай байна. Иймд парламент дахь цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийн эрх зүйн орчныг дараах байдлаар ангилж үзэж болохоор байна. Үүнд:

#### ***Эрх зүйн бүлээс хамаарч:***

- *Вестминстерийн загвар бүхий ардчилсан парламент (Далайн буюу Англо-Америкийн эрх зүйн бүл) дахь цөөнхийн бүлэг (сөрөг хүчин):* Парламент дахь сөрөг хүчний тэргүүнийг албан ёсоор хүлээн зөвшөөрч, парламентын дотор болон гадна тодорхой эрх дарх олгодог. Сөрөг хүчний тэргүү нь өөрийн “Сүүдрийн Засгийн газар” байгуулж, харгалзах сайд нарыг сөрөг хүчний гишүүдээс томилон ажиллуулдаг. Өөрөөр хэлбэл, сөрөг хүчнийг алтернатив засгийн газар буюу хүлээгдэж буй засгийн газрын түвшинд авч үздэг бөгөөд өнөөдрийн сөрөг хүчний тэргүүн, хэрэв дараагийн сонгуульд нам нь ялбал, маргаашийн ерөнхий сайд болох магадлалтай гэсэн үг;
- *олон намын төлөөлөлтэй ардчилсан парламент (Эх газрын буюу Ром-Германы эрх бүл) дахь цөөнхийн бүлэг (сөрөг хүчин):* Парламент дахь цөөнхийн буюу сөрөг хүчний бүлгүүд

гэдэг ойлголтыг авч үздэг. Сөрөг хүчний үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд цөөнхийн хойшлуулах журам, үндсэн хуулийн шүүхэд хандах, парламентын мөрдөн шалгах хороо байгуулах, улс төрийн намуудыг пропорционал харьцаагаар парламент доторх болон гаднах томилгоонд оролцуулах эрхийг хангах гэх мэт арга хэлбэрүүдийг ашигладаг.

### ***Засаглалын хэлбэр, төрийн байгууламжаас хамаарч:***

- *нэг танхимтай парламентын тогтолцооны цөөнхийн бүлэг (сөрөг хүчин);*
- *хоёр танхимтай парламентын тогтолцооны цөөнхийн бүлэг (сөрөг хүчин):* хоёр танхимтай парламентад сөрөг хүчний тэргүүн нь ихэвчлэн доод танхимын гишүүн байдаг;
- *дэд түвшний засаглалтай (subnational governments) буюу холбооны улсын тогтолцооны цөөнхийн бүлэг (сөрөг хүчин):* сөрөг хүчин янз бүрийн түвшинд зэрэгцэн оршдог;
- *ерөнхийлөгчийн засаглалтай болон холимог тогтолцооны цөөнхийн бүлэг (сөрөг хүчин):* засгийн эрх баригч буюу ерөнхийлөгчийн сонгогдсон нам парламентад олонхыг бүрдүүлээгүй байж болно. Тиймээс ерөнхийлөгчийн засаглалд сөрөг хүчний тэргүүн нь хууль тогтоох цөөнхөөс биш, олонхоос ч сонгогдож болдог. Өөрөөр хэлбэл, парламентын олонх нь сөрөг хүчний үүрэг гүйцэтгэнэ гэсэн үг юм.

Олон улсын практикт сөрөг хүчин, эсхүл хууль тогтоох цөөнхийг албан ёсоор хүлээн зөвшөөрч баталгаажуулах нь төрийн эрх мэдлийг хуваалцаж байгаа хэрэг биш харин юуны түрүүнд улс төрийн яриа хэлэлцээ хийх, мэтгэлцээн өрнүүлэх, хяналт, хариуцлагыг дээшлүүлэх, харилцан буулт хийж зөвшилцөх явдлыг дэмжих зорилготой хэмээн үзэж байна.

Сөрөг хүчин (цөөнхийн хүчин) нийтлэг байдлаар дараах эрх, үүрэг хэрэгжүүлдэг. Үүнд:

- **хяналт шалгалт явуулах чиглэлээр:**
  - асуулга, асуулт тавих;
  - засгийн газарт итгэл үзүүлэх эсэх асуудлыг парламентаар хэлэлцүүлэх;
  - парламентын хороодын бүрэлдэхүүнд орж ажиллах;
  - комисс, мөрдөн шалгах түр хороодын бүрэлдэхүүнд орж ажиллах;
  - сөрөг хүчний өдрүүд зохион байгуулах.
- **төрийн томилгоонд оролцох чиглэлээр:**
  - шүүх засаглал болон 4 дэх засаглалтай холбоотой томилгоо;

- ерөнхийлөгчийг томилох (парламентын засаглалтай улсын хувьд);
- сөрөг хүчний сенаторуудыг томилох.
- хориг тавих эрхээ хэрэгжүүлэх болон зөвшилцөх чиглэлээр:
  - хэт олонх буюу цөөнхийн хоригийн зарчим;
  - цөөнх нь хуулийн хэрэгжилтийг хойшлуулах механизм;
  - цөөнхийн хүсэлтээр санал асуулга явуулах;
  - цөөнхийн үндсэн хуулийн шүүхэд хандах эрх зэрэг эрх, үүргийг тус тус хэрэгжүүлдэг. Эдгээр эрх, үүргийн талаарх тодорхой мэдээллийг судалгааны дэлгэрэнгүй хэсгээс үзнэ үү.

### ***Судалгаанд авагдсан орнуудын туршлага***

Энэхүү судалгаанд парламент дахь цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийн эрх зүйн бүл, дээр дурдсан засаглалын хэлбэр, төрийн байгууламжийн ангиллуудыг харгалзан төлөөллийг хангах үүднээс Австрали, Герман, Нидерланд, Өмнөд Солонгос, Финланд, Франц зэрэг улсуудыг сонгон авч хамруулсан болно.

Судалгаанд хамрагдсан улсуудын зарим онцлох асуудал, зохицуулалтуудыг тоймлон дурдвал:

**Австрали Улсын** парламентын тогтолцоо Вестминстерийн загварт суурилдаг тул Төлөөлөгчдийн Танхимд суудалтай хоёр дахь том нам, эвсэл албан ёсны сөрөг хүчин (opposition) болдог бөгөөд сөрөг хүчний тэргүүний эрх, үүрэг, статусыг чухалчилж үздэг. Сөрөг хүчний тэргүүн сүүдрийн Засгийн газрыг байгуулж тэргүүлэн сөрөг хүчний гишүүдээс сүүдрийн сайд нарыг томилон ажиллуулдаг.

**Герман Улсын** Бундестагийг сонгуулийн холимог тогтолцоогоор бүрдүүлдэг. Сонгогч бүр тойрогт нэр дэвшигчид болон намд санал өгөх эрхтэй. Сонгуулийн мажоритар системийн дагуу сонгуулийн тойрог бүрд анхны санал хураалтаас хамгийн их санал авсан нэр дэвшигчийг сонгогдсон гэж үзнэ. Парламентын үлдсэн суудлыг пропорционал төлөөллөөр хуваарилна. Пропорционал санал хураалтаар 5 хувиас доошгүй санал авсан, эсхүл мажоритар тогтолцооны дагуу гурваас доошгүй парламентын суудал авсан нам пропорционал төлөөллийн тогтолцооны дагуу парламентад суудал авах эрхтэй. Герман Улсын сонгуулийн систем нь аль нэг нам дангаараа засгийн газар байгуулахад ихээхэн хүндрэлтэй байдаг тул олон жижиг намууд нийлж олонхыг бүрдүүлэхээс урьдчилан сэргийлэх зорилготой “таван хувийн хориг” (the five percent hurdle) гэж нэрлэгддэг босготой байна. Энэ нь Бундестагт таваас доош хувийн төлөөлөлтэй нам намын бүлэг байгуулах боломжгүй ба бусад намтай эвсэх боломжгүй гэсэн үг юм.

**Нидерланд Улсын** Парламентын доод танхим буюу Төлөөлөгчдийн Танхим (Tweede Kamer) 150 гишүүнтэй. Тус танхимын гишүүдийг бүх ард түмнээс сонгуулийн пропорционал тогтолцоогоор шууд сонгодог. Нэг нам, эвслийн жагсаалтаас сонгогдсон гишүүдийг парламент дахь нэг бүлэг гэж үздэг бөгөөд нэг гишүүн сонгогдсон байсан ч тухайн гишүүнийг дангаараа парламент дахь бүлэг гэж тооцдог байна.

**Өмнөд Солонгос Улс** нь ерөнхийлөгчийн засаглалтай, нэг танхимтай парламенттай. Парламент буюу Үндэсний Ассамблейн нэг намын 20-оос дээш гишүүн, эсхүл өөр өөр намын мөн тооны гишүүд нэгдэн нийлж намын бүлэг байгуулж болдог бөгөөд бүлгийн гишүүд нам болон бүлгийн харьяаллаа солих, шилжих бүрэн чөлөөтэй байдаг ажээ. Үндэсний Ассамблей дахь бүлэг бүр өөрийн төлөөлөх этгээд (Representative Member)-ээ сонгох бөгөөд тухайн сонгогдсон гишүүн нь улс төрийн намын дарга буюу, эсхүл улс төрийн намын төлөөлөгчөөс ялгаатай юм. Бүлэг төлөөлөх этгээд нь шууд Төрийн байгуулалт (House Steering Committee)-ын болон Тагнуул (Intelligence Committee)-ын хорооны гишүүн болдог байна.

**Финланд Улс** парламентын засаглалтай. Парламент нэг танхимтай, 200 гишүүнтэй. Гишүүдийг олон мандат бүхий 12 тойргоос хувь тэнцүүлэх буюу нээлттэй нэрийн жагсаалт бүхий пропорционал тогтолцоогоор сонгодог. Парламентын бүлэг хамгийн багадаа 3 гишүүнтэйгээр байгуулагдах боломжтой боловч гишүүн бүр заавал бүлэгт харьяалагдах үүрэггүй байдаг. Намын бүлгийн гишүүдийн тоо нь зарим тохиолдолд чухал ач холбогдолтой байдаг. Тухайлбал, 20-оос доошгүй гишүүнтэй бүлэг л Засгийн газар, сайдуудын эрхлэх асуудлын хүрээнд тэдгээрт асуулт, асуулга тавих эрхтэй байдаг.

**Франц Улс** нь хагас ерөнхийлөгчийн засаглалтай, 2 танхим бүхий парламенттай. Доод танхим буюу Үндэсний Ассамблей нь 577 депутаттай. Бүрэн эрхийн хугацаа нь 5 жил байх бөгөөд бүх нийтийн, шууд, нууц санал хураалтаар сонгогддог. Нэг мандаттай тойргийн зарчмаар санал хураалтын хоёр шаттай мажоритар системээр сонгодог. Парламент дахь сөрөг хүчин (opposition groups) болон цөөнхийн бүлгийн (minority groups) албан ёсны статусыг Үндсэн хуулиараа баталгаажуулан хуульчилсан байдаг бөгөөд парламент дахь сөрөг хүчин болон цөөнхийн бүлгийн асуудлыг ялгаж заагласан. Парламент дахь бүлгүүдээс өөрсдийгөө “сөрөг хүчин”-ээр зарлаж улс төрийн мэдэгдэл гарган Улсын Ерөнхийлөгчид уламжилснаар тухайн бүлгийг албан ёсны сөрөг хүчин гэж үздэг. Энэхүү мэдэгдлийг хэдийд ч гаргаж болохоос гадна мөн эгүүлэн татаж болдог. Харин парламент дахь хамгийн олон гишүүнтэй бүлгээс бусад өөрсдийгөө сөрөг хүчнийх гэж зарлаагүй бүлгийг цөөнхийн бүлэг гэж үздэг. Цөөнх болон сөрөг хүчний бүлгийн статус ерөнхийдөө ойролцоо боловч сөрөг



хүчинд парламентын хяналтыг хэрэгжүүлэхэд оролцох эрх илүү олгогдсон байдаг ажээ.

Эдгээр улсуудын албан ёсны цөөнхийн бүлэг (сөрөг хүч)-ийн гишүүдийн тооны доод хязгаарыг авч үзэхэд харилцан адилгүй янз бүр байна. Жишээлбэл: огт тоо заагаагүй (Австрали), 1 (Нидерланд), 3 (Финланд), 8 (Монгол), 15 (Франц), 20 (Өмнөд Солонгос), нийт суудлын 5 хувь буюу 37 (Герман) зэрэг байна. Түүнчлэн парламентын цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийн гишүүдийн намын харьяалал, шилжих хөдөлгөөний хувьд ч харьцангуй чөлөөтэй (БНСУ, Финланд), эсхүл хатуу хязгаарлалттай (Герман, Нидерланд) зохицуулалттай байна. Судалгаанд хамрагдсан улсуудын харьцуулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хүснэгт 1-ээс үзнэ үү.

Монгол Улс парламентын засаглалтай, нэгдмэл төрийн байгууламжтай, үндэсний эрх зүйн тогтолцоо нь Ром-Германы бүлд харьяалагддаг учраас манай энэхүү өвөрмөц онцлогт илүү тохирсон эрх зүйн зохицуулалт бүхий улсууд нь Герман, Финланд байна.

### ***Монгол Улсын Их Хурлын цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийн талаар***

1990 оноос өмнөх үед Бүгд Найрамдах Монгол Ард Улс (БНМАУ)-ын Ардын Их Хурал (АИХ) нь тухайн үеийн Үндсэн хуулиар хууль тогтоох, төрийн эрх барих дээд байгууллага байсан боловч нэг нам, нэг үзэл суртлын авторитар тогтолцоотой байсан учраас парламентын бүлэг, цөөнхийн талаарх ойлголт байхгүй байсан.

Монгол Улсад 1990 оны 07 дугаар сард анх удаа олон намын оролцоотой анхны чөлөөт, ардчилсан сонгууль болж АИХ-ыг шинэчлэн байгуулж байсан. Энэхүү АИХ “БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хууль батлан гаргаж, хууль тогтоох, хянан шалгах, зохион байгуулах эрх бүхий төрийн эрх барих байнгын дээд байгууллага болох Улсын Бага Хурал (УБХ)-ыг байгуулсан. БНМАУ-ын АИХ-ын 430 депутатаас сонгогдсон 50 гишүүнтэй УБХ нь 1990-1992 онд бүрэн эрхээ хэрэгжүүлж, Монголын улс төр, эдийн засаг, нийгмийн байгууллыг шинэтгэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн. УБХ нь Монгол Улсын байнгын ажиллагаатай анхны парламент юм.

1992 оны ардчилсан, шинэ Үндсэн хуулийн дагуу нэг танхимтай парламентын тогтолцоонд шилжсэнээс хойш эдүгээ 8 дахь парламентын бүрэн эрхийн хугацаа хэрэгжиж байна. Энэ хугацаанд Монгол Улсын Их Хурлын тухай хууль (МУИХтХ) 1992, 1997, 2001, 2006, 2020 онуудад 5 удаа, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль (МУИХЧХДтХ) 1997, 2007, 2020 онуудад 3 удаа тус тус шинэчлэгдэн

батлагдаж байсан. Эдгээр хуулиудад Улсын Их Хурал (УИХ) дахь намын бүлэг, цөөнхтэй холбоотой гол ойлголт, нэр томьёонууд болон зохицуулалтууд агуулга, цар хүрээний хувьд өргөжин төгөлдөрших байдлаар тусгагдаж ирсэн байна.

Тухайлбал:

- **1992 оны МУИХтХ-д:** Намын бүлэг гэдгийг “Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудал бүхий нам бүлэг байгуулж болно.” гэж томьёолж, намын бүлгийн эрх, үүргийг тодорхойлсон, мөн “Улсын Их Хурлын дарга Байнгын хорооны бүрэлдэхүүний талаар намуудын бүлгийн ахлагч нартай зөвшилцсөнөөр Улсын Их Хурал өөрийн гишүүдээс сонгон Байнгын хороог байгуулна.” гэсэн зохицуулалт оруулсан;
- **1997 оны МУИХтХ-д:** Энэ хуульд анх УИХ дахь “Олонх”, “Цөөнх”-ийн ойлголт, тэдгээрийн харилцааг зохицуулж эхэлсэн. Түүнчлэн “Төсвийн зарлагын хяналтын болон Ёс зүйн дэд хороодын даргыг Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлэгт ордог Улсын Их Хурлын гишүүдээс сонгоно.” заалт оруулсан;
- **2001 оны МУИХтХ-д:** 2000 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр “...Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс Улсын Их Хурлын дэд даргыг сонгоно.” гэсэн зохицуулалт орсонтой холбоотойгоор энэхүү асуудлыг нарийвчлан тусгаж ирсэн;
- **2006 оны МУИХтХ-д:** УИХ-ын даргын дэргэдэх зөвлөл, бүлгийн ажлын албаны зохицуулалтыг дараах байдлаар тусгасан. Үүнд: “Нам, эвслийн бүлэг, Байнгын хороодын үйл ажиллагаа, Улсын Их Хурлын хяналт шалгалтын ажлыг уялдуулан зохицуулах, нам, эвслийн бүлэг, Байнгын хороодын санал болон хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хугацааг харгалзан ээлжит болон ээлжит бус чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал тогтоох, тухайн долоо хоногт чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлын тов, дарааллыг батлах, Улсын Их Хурлын төсөв болон Улсын Их Хурлын дотоод үйл ажиллагаатай холбогдолтой бусад асуудлыг зөвшилцөх чиг үүрэг бүхий Зөвлөл Улсын Их Хурлын даргын дэргэд ажиллана.”; “Бүлэг нь бодлогоо боловсруулах, зохион байгуулалтын туслалцаа авах чиг үүрэг бүхий ажлын албатай байна.”;
- **2020 оны МУИХтХ-д:** 2019 онд Үндсэн хуульд “Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна.” гэсэн нэмэлт орсон. Үүнтэй холбоотойгоор

2020 оны УИХтХ-д “...хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь Хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал цөөнхийн төлөөллийг оролцуулан Улсын Их Хурлын тогтоолоор хойшлуулахгүйгээр байгуулна.”

Ийнхүү парламент дахь цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-тэй холбоотой “намын бүлэг”, “намын бүлгийн эрх, үүрэг”, “цөөнх”, “нам, эвслийн бүлэг тус бүрээс УИХ-ын дэд даргыг сонгох”, “байнгын хорооны бүрэлдэхүүнийг нам, эвслийн бүлэгт хуваарилах”, “Төсвийн зарлагын хяналтын болон Ёс зүйн дэд хороодын даргыг цөөнхийн бүлгээс сонгох”, “Хянан шалгах түр хороо байгуулахдаа цөөнхийн төлөөллийг оролцуулан байгуулах”, “нам, эвслийн бүлэг ажлын албатай байх, “УИХ-ын даргын дэргэдэх Зөвлөлийн бүрэлдэхүүнд нам, эвслийн бүлгийн дарга орох” зэрэг ойлголт, зохицуулалтууд тухайн цаг үеийн шаардлага болон олон улсын нийтлэг жишгээс үүдэлтэйгээр тухай бүр МУИХтХ-даа тусгагдаж иржээ.

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

**Хүснэгт 1. Судалгаанд хамрагдсан улсуудын парламент дахь намын бүлэг, цөөнхийн зохицуулалтын харьцуулалт**

Улс, Парламент	Эрх зүйн орчин	Парламент дахь бүлэг	Бүлгийн зорилго	Бүлгийн удирдлага ба ажлын алба
<b>Австрали Улс</b> <b>(Төлөөлөгчдийн Танхим)</b>	-Үндсэн хууль; -Үндсэн хуулийн конвенц; -Төлөөлөгчдийн Танхимын практик; -Төлөөлөгчдийн Танхимын хуралдааны дэг.	Парламентад хамгийн олон суудал авсан улс төрийн нам олонхын бүлгийг байгуулж Засгийн газраа байгуулна. Харин парламентад суудалтай хоёр дахь том нам (намуудын эвсэл) сөрөг хүчний бүлэг байгуулна.	Бүлгийн зорилго нь хууль тогтоомжийн төсөл болон улс төрийн ач холбогдолтой асуудлыг хэлэлцэхэд туслалахад чиглэнэ.  Бүлэг нь тухайн улс төрийн намаас сонгогдсон гишүүд, сенаторуудаас бүрддэг ба төрийн бодлого, шийдвэрт нөлөөлөх эрх мэдэлтэй.	Сөрөг хүчний бүлгийн удирдагч нь төрийн өндөр албан тушаалтны жагсаалтын 10 дугаарт бичигддэг бөгөөд сөрөг хүчний үйл ажиллагааг удирдан чиглүүлдэг. Тэрээр сүүдрийн Засгийн газрыг тэргүүлэх, сөрөг хүчний гишүүдээс сүүдрийн Засгийн газрын сайд нарыг сонгох, бүлгийг хуралдуулж төрийн бодлого, хуулийн төслүүдийг санаачлан хэлэлцэх, урьдчилан мэдэгдэлгүйгээр Төлөөлөгчдийн Танхимын хуралдаанд асуулт асуух зэрэг эрх мэдэлтэй.
<b>Герман Улс</b> <b>(Бундестаг)</b>	- -Үндсэн хууль; - -Улс төрийн н;амын тухай хууль; - -Бундестагийн хуралдааны дэгийн тухай хууль; -Бундестагийн хянан шалгах түр хорооны эрх зүйн байдлын тухай хууль.	Бундестагийн нийт суудал (735)-ын хамгийн багадаа 5 хувиас доошгүй суудал (36-37 орчим) авсан улс төрийн нам бүлэг байгуулна. Мөн улс төрийн үзэл баримтлал, зорилгоороо нэгдмэл, аль ч мужид хоорондоо өрсөлддөггүй намын харьяалалтай гишүүд нийлж Бундестагт хамтарсан нэг намын бүлэг байгуулж болно.	Парламентын засаглалтай ардчилсан улсад намын бүлэг нь засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, бодлогын талаар мэтгэлцээн өрнүүлэх, Бундестагийн гишүүдийн өргөн барьсан хуулийн төслүүдэд санал өгөх зэрэг нь үндсэн зорилго болдог.	Бундестаг дахь намын бүлэг бүр гишүүдийнхээ дундаас бүлгийн даргыг сонгох бөгөөд намын бүлэг байгуулсан тухай, түүний албан ёсны нэр, намын бүлгийн даргын нэр, гишүүдийн нэрс зэргийг Бундестагийн ерөнхийлөгчид бичгээр мэдэгдэнэ.

<p><b>Нидерланд Улс</b> <b>(Төлөөлөгчдийн Танхим)</b></p>	<p>-Төлөөлөгчдийн Танхимын Дэгийн журам.</p>	<p>Пропорционал сонгуулийн системээр намын нэг жагсаалтаас сонгогдсон гишүүдийг парламент дахь нэг бүлэг гэж үзнэ. Жагсаалтаас нэг гишүүн сонгогдсон байсан ч тухайн гишүүнийг дангаараа Парламент дахь бүлэг гэж тооцдог.</p>	<p>Сөрөг хүчний намууд ихэвчлэн парламентын хороод дахь төлөөллөөрөө дамжуулан хууль тогтоомж, засгийн газрын бодлогын хэрэгжилтэд хяналт тавих үүрэг гүйцэтгэдэг. Түүнчлэн намын бүлгүүд хууль тогтоох үйл явцад хувь нэмрээ оруулж, Засгийн газарт хариуцлага тооцох, хяналт тавих боломжийг олгодог.</p>	<p>Парламентын бүлгийн дарга нар Тагнуул, Аюулгүй байдлын хорооны гишүүд байна. Парламент дахь бүлэг бүр гүйцэтгэх хорооныхоо бүрэлдэхүүний талаар Парламентын даргад мэдээлнэ. Намын бүлгүүд нарийн бичиг, шинжээч, хэвлэл мэдээллийн ажилтан гэх мэт бүлгийн ажилтнуудын цалинд зарцуулагддаг төсөвтэй байдаг.</p>
<p><b>Өмнөд Солонгос Улс</b> <b>(Үндэсний Ассамблей)</b></p>	<p>-Үндсэн хууль; -Үндэсний Ассамблейн тухай хууль (National Assembly Act); -Улс төрийн намын тухай хууль (Political Parties Act).</p>	<p>Үндэсний Ассамблейд 20-оос дээш гишүүнтэй улс төрийн нам бүлэг (negotiating party) байгуулна. Аль нэг бүлэгт харьяалалгүй 20 болон түүнээс дээш тооны гишүүд нэгдэн нийлж тусдаа бүлэг байгуулж болно.</p>	<p>Бүлгийн зохион байгуулалтын үндсэн зорилго нь улс төрийн нам, эвсэл, тэдгээрийн бүлгийн гишүүдийн дунд үр дүнтэй яриа хэлэлцээ хийх, мэдээлэл шуурхай түгээх, дамжуулах болон солилцох нээлттэй суваг бий болгох, ингэснээрээ парламентын хууль тогтоох үйл ажиллагааг илүү хялбар, үр дүнтэй болгоход чиглэгддэг.</p>	<p>Үндэсний Ассамблей дахь бүлэг бүр өөрийн төлөөлөх этгээдийг сонгох бөгөөд тухайн этгээд нь улс төрийн намын дарга буюу, эсхүл намын төлөөлөгчөөс ялгаатай. Бүлэг төлөөлөх этгээд шууд Төрийн байгуулалтын болон Тагнуулын хорооны гишүүн болдог. Бүлэгт дэмжлэг үзүүлэх зорилгоор бүлэг тус бүрд бодлого, судалгааны асуудал хариуцсан ажилтныг томилох ажиллуулдаг. Тус ажилтныг бүлэг төлөөлөх этгээдийн санал болгосноор Үндэсний Ассамблейн дарга томилж, чөлөөлнө.</p>

<b>Финланд Улс (Парламент)</b>	-Үндсэн хууль;  -Парламентын дэгийн тухай дүрэм.	Парламентын бүрэн эрхийн хугацаанд парламентын бүлэг хамгийн багадаа 3 гишүүнтэйгээр байгуулагдана.	Парламентын бүлэг нь практик түвшинд парламентын үйл ажиллагаанд хамгийн гол үүрэг гүйцэтгэдэг. Парламентаар хэлэлцэгдэж буй аливаа асуудлыг гишүүд бүлгийн хуралдаанаараа хэлэлцэж, тухайн асуудалд бүлэг ямар байр суурь баримтлахаа шийддэг.	Парламентын бүлгүүд нь дарга, дэд даргатай байх бөгөөд бүлгийн даргын үүрэг нь бүлгийнхээ байр суурийг парламентын бусад бүлгүүдээр хүлээн зөвшөөрүүлэх, харилцан зөвшилцөж, хамтран ажиллах явдал юм.
<b>Франц Улс (Үндэсний Ассамблей)</b>	-Үндсэн хууль;  -Үндэсний Ассамблейн Хуралдааны дэгийн тухай хууль.	Үндэсний Ассамблейн гишүүд өөрсдийн улс төрийн адил төстэй байдлыг харгалзан бүлэг байгуулж болно. Бүлэг байгуулахад хамгийн багадаа 15 гишүүнтэй байна.	Засгийн газарт сөрөг хүчний үзүүлэх нөлөө нь парламентын хяналтыг хэрэгжүүлэх оролцоогоор хангагддаг бөгөөд энэ нь эрх мэдлийг хуваарилах тогтолцооны хяналт, тэнцвэрийн механизм төдийгүй олонх, цөөнхийн хоорондын мэтгэлцээний арга хэлбэр болдог.	Бүлэг нь өөрсдийн томилсон дотоод алба, захиргааны хэрэг эрхлэх газартай байж болно. Тэдгээрийн дүрэм, байр, тоног төхөөрөмж, албан хаагчдынх нь Үндэсний Ассамблейд танхимд нэвтрэх асуудлыг бүлгийн дарга, Квесторын санал болгосны дагуу Үндэсний Ассамблейн Тамгын газар тогтооно.
<b>Монгол Улс (Улсын Их Хурал)</b>	-Монгол Улсын Үндсэн хууль;  -Монгол Улсын Их Хурлын тухай хууль;  - Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль.	Улсын Их Хурлын сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд наймаас доошгүй суудал авсан нам, эвсэл бүлэг байгуулж болно. Бүлэгт зөвхөн тухайн нам, эвслээс албан ёсоор нэр дэвшиж сонгогдсон гишүүд орно.	Нам, эвслийн бүлэг (цөөнх) нь Улсын Их Хурлын үйл ажиллагааны цөөнхийн саналыг хүндэтгэн асуудлыг олон талт үзэл бодлын үүднээс чөлөөтэй хэлэлцэж шийдвэрлэх зарчмыг хангуулах зорилготой.	Нам, эвслийн бүлэг даргаа дотроосоо сонгоно. Бүлгийн дарга нь Улсын Их Хурлын даргын дэргэдэх зөвлөлийн гишүүн байна. Бүлэгт бодлого боловсруулахад нь туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын алба байна. Бүлгийн ажлын албаны ажилтны тоо тухайн бүлгийн гишүүдийн тооны 1/2-тай тэнцүү байх бөгөөд хэрэв бүлгийн гишүүдийн тоо 23-аас доош бол 12 хүртэл байна.

## СУДАЛГААНЫ ХЭСЭГ

### **НЭГ. АРДЧИЛСАН ПАРЛАМЕНТ ДАХЬ ЦӨӨНХИЙН БҮЛЭГ БУЮУ СӨРӨГ ХҮЧИН: ОНОЛ АРГА ЗҮЙ, ОЛОН УЛСЫН ЧИГ ХАНДЛАГА<sup>211</sup>**

Орчин үед ардчиллыг зөвхөн олонхын засаглал төдий зүйл биш, хууль тогтоох (парламент) болон гүйцэтгэх засаглал (засгийн газар)-ыг үндсэн эрх, хууль дээдлэх ёс, хяналт, тэнцвэрт байдал, шударгаар захирах ёс, иргэдийн оролцоо, нээлттэй хэлэлцүүлгийн арга хэрэгсэлтэй хослуулсан улс төрийн тогтолцоо хэмээн тодорхойлж байна.

Ардчилсан нийгэмд сөрөг хүчний намуудын эвлэлдэн нэгдэх, цуглаан хийх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мөн шүүх болон төрийн албаны хараат бус байдлыг дэмжих гэх мэт үйл ажиллагаа явуулах эрхийг үндсэн хуулиар зөвшөөрч хамгаалсан байдаг. Энэ нь тэдэнд засгийн газрын үйл ажиллагаанд шүүмжлэлтэй хандахад тэгш эрх эдлэх, энэхүү хандлага нь гэмт хэрэгт тооцогдохгүй, дарамт шахалтад өртөхгүй бөгөөд хохирохгүй байх баталгаа болдог.

Тиймээс ихэнх улсууд үндсэн хуулиараа сөрөг хүчин, эсхүл хууль тогтоох цөөнхийн эрх мэдэл, үүрэг хариуцлагыг албан ёсоор хүлээн зөвшөөрсөн байдаг. Энэ нь улс төрийн олон ургалч үзлийн зарчмыг баримтлах (эрх мэдлийг аль нэг нам дангаар эзэмшиж болохгүй), ардчилсан яриа хэлэлцээ, мэтгэлцээн хийхийг тууштай дэмжих буюу өөрөөр хэлбэл шийдвэр гаргахдаа бусад намуудын дуу хоолойг сонсох боломжийг бүрдүүлэхэд чиглэгддэг.

Үндсэн хуульт ардчилсан улсуудын парламент дахь цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийг хүлээн зөвшөөрч, тэдний эрх, үүргийн талаарх асуудлыг үндсэн хууль болон бусад хуулийн хүрээнд авч үздэг.

#### **1.1.Нэр томьёоны тодорхойлолт**

Юуны түрүүнд “сөрөг хүчин” болон “парламент дахь цөөнх” (хууль тогтоох цөөнх) гэсэн нэр томьёоны талаар авч үзье. Эдгээр нь засаглалын хэлбэрээс хамаарч зарим тохиолдолд ижил, зарим тохиолдолд өөр тусдаа ойлголтууд байдаг.

Ихэнх тохиолдолд, ялангуяа парламентын засаглалын тогтолцоонд ижил ойлголтыг илэрхийлдэг. Учир нь энэ тогтолцооны хувьд ерөнхий сайд нь парламентад олонх болсон нам, эвслээс сонгогдох ба парламент дахь цөөнхийн нам, эвсэл нь засгийн газар буюу гүйцэтгэх засаглалыг

<sup>211</sup> Opposition and Legislative Minorities: Constitutional Roles, Rights and Recognition. International IDEA. <https://www.idea.int/sites/default/files/publications/opposition-and-legislative-minorities-constitutional-roles-rights-recognition.pdf>



шүүмжилж эсрэг байр суурь илэрхийлэгч болдог. Өөрөөр хэлбэл парламентад тодорхой тооны суудал авсан нам, эвслүүд албан ёсоор парламентын бүлэг байгуулах бөгөөд олонхыг бүрдүүлсэн нам, эвслийн бүлэг нь эрх баригч хүчин буюу олонх, бусад нам, эвслийн бүлэг нь сөрөг хүчин буюу цөөнх болдог байна.

Харин ерөнхийлөгч (хагас ерөнхийлөгч)-ийн засаглалын тогтолцоонд төрийн тэргүүн нь парламент дахь цөөнхийн нам, эвслээс нэр дэвшин томилогдсон, эсхүл сонгогдсон тохиолдолд парламент дахь бусад нам нь сөрөг хүчин болдог. Өөрөөр хэлбэл, парламент дахь цөөнх бус, харин олонх нь ерөнхийлөгчийн эсрэг байр сууриа илэрхийлж сөрөг хүчний үүрэг гүйцэтгэдэг. Тиймээс энэ тогтолцооны хувьд “хууль тогтоох цөөнх” гэдэг нэр томъёо тохирохгүй, харин “сөрөг хүчин” гэх нэр томъёог хэрэглэдэг. Өөрөөр хэлбэл, “хууль тогтоох цөөнх” (парламент дахь цөөнх) болон “сөрөг хүчин” гэсэн нэр томъёонууд өөр өөр ойлголтыг илэрхийлнэ.

Сөрөг хүчний тэргүүнийг албан ёсоор хүлээн зөвшөөрдөг улсуудад “сөрөг хүчин” гэж сөрөг хүчний тэргүүнийг сонгосон парламент дахь хамгийн том буюу гол сөрөг хүчний намыг хэлдэг бөгөөд түүнийг албан ёсоор сөрөг хүчинд тооцдог.

Мөн дээрх албан ёсны сөрөг хүчний намаас гадна “сөрөг хүчний нам”-д парламентад суудал авсан бөгөөд засгийн газрын эсрэг байр суурь илэрхийлдэг бусад намуудыг хамруулдаг.

Зарим тохиолдолд засгийн эрх баригч болон албан ёсны сөрөг хүчний намуудын дараа орох сөрөг хүчний хоёр дахь том намыг “гуравдагч сөрөг хүчний нам” гэж нэрлэдэг. Харин парламент дахь суудлын тоогоор эдгээрээс бага байх бусад сөрөг хүчний намуудыг “бага сөрөг хүчний нам” (minor opposition parties)-ууд гэж нэрлэх жишиг байдаг.

Түүнчлэн олон улсын туршлагаас үзэхэд, сөрөг хүчний нам гэсэн ойлголт хууль тогтоох байгууллага буюу парламентад төлөөлөлгүй намуудыг ч багтаах хандлага байдаг. (the extra-legislative opposition буюу хууль тогтоох эрхгүй сөрөг хүчин).

## **1.2.Сөрөг хүчин буюу хууль тогтоох цөөнхийг хүлээн зөвшөөрөх асуудал**

Ардчилсан улсуудад сөрөг хүчин, эсхүл хууль тогтоох цөөнхийг хүлээн зөвшөөрөх нь цөөнхийн эрх, үүрэг, үйл ажиллагааны талаарх ойлголт нь тухайн тогтолцооны онцлогоос хамаарч ялгаатай байдаг. Тухайлбал, парламентын болон ерөнхийлөгчийн засаглалд сөрөг хүчин, эсхүл хууль тогтоох цөөнхийн тэргүүн ижил байр суурьтай байдаггүй.



Хэдийгээр заримдаа өөр байх боловч, албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн сөрөг хүчний тэргүүний тухай ойлголт нь парламентын засаглал, мажоритар тогтолцоо, Их Британийн түүхэн уламжлалт улс төрийн тогтолцоотой нягт холбоотой гэж үздэг.

Бусад институцийн хувьд буюу ерөнхийлөгч (хагас ерөнхийлөгч)-ийн засаглал, пропорционал төлөөллийн тогтолцоо бүхий парламентын засаглалд хууль тогтоох цөөнхийг чадавхжуулах бусад арга хэрэгсэл ашиглах нь илүү түгээмэл байдаг. Гэхдээ ерөнхийлөгчийн тогтолцоотой цөөн тооны улсад сөрөг хүчний тэргүүнийг хүлээн зөвшөөрч, түүнд томоохон эрх мэдлийг олгодог байна.

Хэлбэрийн хувьд зарим улсын үндсэн хуульд сөрөг хүчин, эсхүл хууль тогтоох цөөнхийг хүлээн зөвшөөрөх болон тэдгээрийн эрх, үүргийн талаар зөвхөн ерөнхий байдлаар тусгаж, парламентын дэгийн болон бусад хууль тогтоомжийн хүрээнд нарийвчилсан асуудлыг тодорхойлдог бол зарим улсын үндсэн хуульд нарийвчлан заасан байдаг.

Ардчилсан улсуудад сөрөг хүчнийг хүлээн зөвшөөрөөд зогсохгүй улс төрийн тогтолцооны амин чухал элемент гэж үнэлдэг. Сөрөг хүчний намууд нь бодлогын хөтөлбөрт шинэ асуудлуудыг оруулах, олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх, засгийн газарт хариуцлага тооцох, сонгогчдод мэдээлэл өгөх, идэвхжүүлэх болон сонголтоо хийхэд чухал үүрэг гүйцэтгэдэг байна. Үр дүнтэй сөрөг хүчин нь засгийн газарт алдаа гаргахаас зайлсхийх, эсхүл алдаагаа хурдан засаж залруулахад тус дөхөм болдог бөгөөд ингэснээр засаглалын үр дүн сайжирна гэж үздэг.

Түүнчлэн олон улсын туршлагад, бодлого боловсруулах ажилд хувь нэмрээ оруулах чадамжтай хууль тогтоох цөөнх нь бодлогыг илүү хүртээмжтэй, илүү хариу үйлдэлтэй болгож чадна гэж үздэг. Учир нь чадварлаг бөгөөд эрх мэдэлтэй сөрөг хүчин, эсхүл хууль тогтоох цөөнхтэй байж ардчилсан зарчмаар хэлэлцүүлэг, мэтгэлцээн хийх боломж бүрддэг. Аливаа шийдвэрийг эрх баригч олонх гаргадаг боловч сөрөг хүчин, эсхүл хууль тогтоох цөөнхтэй байх нь тэднийг сонсох, олон нийтэд санал бодлоо илэрхийлэх, гаргасан шийдвэрийг нягтлах боломж өгдөг байна.

Олон улсын практикт сөрөг хүчин, эсхүл хууль тогтоох цөөнхийг албан ёсоор хүлээн зөвшөөрөх нь эрх мэдлийг хуваах явдал биш гэж үздэг бөгөөд энэ нь юуны түрүүнд улс төрийн яриа хэлэлцээ, мэтгэлцээн, хяналт, хариуцлага, харилцан буултыг дэмжих зорилготой байна.

### **1.3.Сөрөг хүчний тэргүүний парламент дахь байр суурь**

Олон улсын туршлагаас үзэхэд, сөрөг хүчний тэргүүнийг томилох процедур болон түүний парламент дахь байр суурь засаглалын хэлбэрээс хамаарч харилцан адилгүй байна.

*Вестминстерийн загвар бүхий ардчилсан парламентад*

Энэхүү тогтолцооны хувьд парламентын доод танхимд олонхын суудалтай нам, эвслийн тэргүүн гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлийг ерөнхий сайдаар ахлуулсан сайд нарын танхимд төвлөрүүлдэг. Тиймээс ерөнхий сайд бодлого боловсруулах, хэрэгжүүлэх бүх үйл ажиллагааг удирдаж байдаг. Ерөнхий сайд болон сайд нарын танхим нь засгийн газрын бодлого, үйл ажиллагааг парламентын доод танхимын өмнө хариуцдаг боловч албан үүргээ гүйцэтгэх хугацаанд доод танхимын олонхын дэмжлэгт найддаг байна.

Вестминстерийн загвар бүхий ардчилсан улсуудын үндсэн хуульд, ялангуяа 1950-аад оноос хойш батлагдсан үндсэн хуулиудад сөрөг хүчний тэргүүнийг хүлээн зөвшөөрч, түүний парламент доторх болон гаднах эрх мэдлийн талаар тусгасан байх нь түгээмэл ажиглагддаг. Мажоритар тогтолцоонд сөрөг хүчин шаардлагатай хяналт, тэнцвэрийг хангаж, ерөнхий сайдын удирдлагыг автократ болохоос сэргийлнэ гэж үздэг. Энэ тогтолцооны хувьд сөрөг хүчний гүйцэтгэдэг чухал үүрэг бол улс төрд эрх мэдлийг зохицуулах болон эрх мэдлийн төлөө өрсөлдөх гэсэн хоёрдмол үүрэг юм.

Сөрөг хүчин нь зохицуулагч хүчний хувьд засгийн газрын бодлогод нөлөөлж, засгийн газраас сөрөг хүчний ашиг сонирхлыг харгалзан үзэхийг шаардах эрхтэй бөгөөд энэ нь илүү сайн, илүү хүртээмжтэй, илүү өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн бодлогын шийдвэр гаргахад нөлөөлдөг байна.

Харин өрсөлдөгч хүчний хувьд сөрөг хүчин нь засгийн газарт хяналт тавьж, алдаа дутагдлыг нь олон нийтэд ил тод болгоход анхаарахын зэрэгцээ алдаа гаргасан тохиолдолд засгийн газарт хариуцлага хүлээлгэх боломжтой. Түүнээс гадна Вестминстерийн загвартай улсуудад сөрөг хүчнийг алтернатив засгийн газар, эсхүл хүлээгдэж буй засгийн газрын түвшинд авч үздэг. Өөрөөр хэлбэл, өнөөдрийн Сөрөг хүчний тэргүүн, хэрэв дараагийн сонгуульд нам нь ялбал, маргаашийн ерөнхий сайд болох магадлалтай гэсэн үг.

Ихэнх Вестминстерийн загвар бүхий ардчилсан улсад “сүүдрийн засгийн газар”-ыг байгуулдаг уламжлалтай. Ерөнхий сайдын зэрэгцээ Сөрөг хүчний тэргүүнтэй байхаас гадна сөрөг хүчин өөрийн бодлогоо Засгийн газрын тодорхой бүтэц, нэгжтэй уялдуулан илэрхийлэх үүрэг бүхий сөрөг хүчний парламентын гишүүдээс бүрдсэн хороо ажиллуулдаг байна. Тухайлбал, Засгийн газрын Гадаад хэргийн сайдтай зэрэгцээд Сөрөг хүчний гадаад хэргийн сайд ажилладаг. Канадад ийм үүрэг бүхий сөрөг

хүчний гишүүдийг “шүүмжлэгчид” гэж нэрлэдэг бөгөөд энэ нь тэдний үүргийн нэг хэсэг болох засгийн газрын үйл ажиллагааг шүүмжилж, хянах ажлыг удирдан чиглүүлдэг байна. Гэхдээ шүүмжлэх нь “Сүүдрийн засгийн газар”-ын цорын ганц үүрэг биш бөгөөд энэ нь сөрөг хүчинд хүлээгдэж буй засгийн газрын алтернатив үүргийг гүйцэтгэх боломжийг олгож байдаг.

Гэсэн хэдий ч дараагийн сонгуульд сөрөг хүчний тэргүүн ерөнхий сайдаар томилогдвол “Сүүдрийн засгийн газар”-ын гишүүдийг жинхэнэ Засгийн газрын бүрэлдэхүүнд томилох үүрэг хүлээдэггүй байна.

### *Олон нам бүхий ардчилсан парламентад*

Парламентын тогтолцоо, ялангуяа эх газрын Европын уламжлалт парламентын тогтолцоотой улсуудын хувьд парламент нь нийгмийн янз бүрийн бүлгүүдийн үзэл бодол, эрх ашгийг илэрхийлэгч олон намын төлөөллөөс бүрддэг. Ийм нөхцөлд ганц сөрөг хүчний тэргүүн гэхээс илүү сөрөг хүчний намуудын тэргүүнүүд гэж авч үздэг. Энэ тохиолдолд сөрөг хүчний намуудын тэргүүнүүд намынхаа илтгэгч, засгийн газрыг шүүмжлэгч, эвслийн хэлэлцээний төлөөлөгчийн хувьд янз бүрийн үүрэг гүйцэтгэж болох ч тэд Вестминстерийн загвар дахь сөрөг хүчний тэргүүнтэй ижил статустай байдаггүй, мөн дараагийн сонгуулиар ерөнхий сайд болох ч албагүй.

Энэ тогтолцооны хувьд сонгуулийн систем нь пропорционал, эсхүл мажоритар байж болно. Түүхийн хувьд авч үзвэл, энэ тогтолцоонд эерэг, сөрөг талын аль аль нь ажиглагддаг. Тухайлбал, Францын Гурав дахь Бүгд Найрамдах Улсын үед парламентыг бүрдүүлэхдээ сонгуулийн мажоритар системийг ашигласан. Тухайн үед олон намтай улс төр эмзэг, эвслийн Засгийн газартай байсан бөгөөд сөрөг хүчний тэргүүн нь тодорхойгүй байжээ. Үүний эсрэг жишээ нь, Шинэ Зеланд, Фижи зэрэг улсууд сонгуулийн пропорционал системтэй (одоо ч хэрэглэж байгаа) боловч хамгийн том сөрөг хүчний намын даргыг сөрөг хүчний тэргүүнээр томилж, ирээдүйд ерөнхий сайд болно гэсэн хүлээлт хадгалагдсаар байна.

Олон нам бүхий парламентын тогтолцоонд улс төрийн сөрөг хүчний эрх хэмжээг өөр арга хэлбэрээр зохицуулсан байдаг. Тухайлбал, цөөнхийн хойшлуулах журам, үндсэн хуулийн шүүхэд хандах, парламентын мөрдөн шалгах хороо байгуулах, улс төрийн намуудыг пропорционал харьцаагаар парламент доторх болон гаднах томилгоонд оролцуулах эрхийг хангах арга хэлбэрийг ашиглаж байна.

### *Ерөнхийлөгчийн болон засаглалын холимог тогтолцооны үед*

Ерөнхийлөгчийн засаглалтай буюу эсхүл холимог тогтолцоонд сөрөг хүчний тэргүүний эрх зүйн байдал, эрх, үүргийг парламентын

тогтолцооныхоос ялгах хоёр чухал шинж байдаг гэж үздэг. Нэгдүгээрт, засгийн эрх баригч буюу ерөнхийлөгчийн нам нь парламентад олонхыг бүрдүүлээгүй байж болно. Тиймээс ерөнхийлөгчийн засаглалд сөрөг хүчний тэргүүн нь хууль тогтоох цөөнхөөс биш, олонхоос ч сонгогдож болдог. Өөрөөр хэлбэл, парламентын олонх нь сөрөг хүчний үүрэг гүйцэтгэнэ гэсэн үг юм.

Хоёрдугаарт, сөрөг хүчний тэргүүн нь дараагийн сонгуулиар заавал ерөнхийлөгчид өрсөлдөх албагүй. Учир нь ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийг сонгон шалгаруулах тусгай журамтай байдаг тул нэр дэвших хүмүүс нь парламентын гишүүн бус этгээд ч байж болно.

Ийм тогтолцоотой зарим улсад үндсэн хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн сөрөг хүчний тэргүүн нь гүйцэтгэх засаглалыг тэргүүлдэг ерөнхийлөгч (шууд сонгогдсон)-тэй зэрэгцэн ажиллах тохиолдол бас байдаг. Үүнд, Буркина Фасо, Мадагаскар, Нигер, Сенегал, Сейшелийн арлууд, Шри-Ланка, Уганда, Замби, Зимбабве зэрэг улсууд багтана.

Ерөнхийлөгчийн засаглалтай зарим улсад парламент дахь цөөнхийн тэргүүний байр суурийг хуулийн хүрээнд албан ёсоор хүлээн зөвшөөрдөг. Тухайлбал, Кенийн Үндсэн хуулийн 108 дугаар зүйлд “Цөөнхийн намын дарга нь Үндэсний Ассамблейн хоёр дахь том нам, эвслийн удирдагч байна.” гэж заасан байдаг. Эндээс харахад, дээр өгүүлсэн сөрөг хүчний тэргүүнээс ялгаатай нь Үндэсний Ассамблейд авсан суудлын тооноос хамаарч байна.

#### **1.4.Сөрөг хүчний тэргүүнийг томилох асуудал**

Вестминстерийн загвар бүхий улсуудад (жишээ нь, Австрали, Канад, Энэтхэг, Малайз) сөрөг хүчний тэргүүн нь эртнээс уламжлан ирсэн улс төрийн албан тушаал бөгөөд хууль тогтоомж, эсхүл парламентын шийдвэрээр хүлээн зөвшөөрөгдсөн байдаг боловч түүний эрх, үүргийг парламентын эрх ямба, эсхүл уламжлалт ёс заншлын асуудал гэж үздэг байв. Харин 1950-аад оноос хойш батлагдсан шинэ үндсэн хуулиудад сөрөг хүчний тэргүүнийг албан ёсоор хүлээн зөвшөөрч, томилох журам, бүрэн эрхийн хугацаа, эрх, үүргийг заадаг болсон.

Сөрөг хүчин, эсхүл хууль тогтоох цөөнхийн тэргүүний талаар АНУ-ын адил хуучны үндсэн хуулиудад тусгаагүй байдаг бол Кени, Сенегал, Сейшелийн арлууд зэрэг улсуудын шинэчлэгдсэн үндсэн хуулиудад тусгасан байдаг.

Олон улсын туршлагаас үзэхэд, сөрөг хүчний тэргүүнийг томилох асуудал засаглалын хэлбэрээс хамаарч өөр өөр байна.

### *Парламентын засаглалтай улсуудад*

Парламентын засаглал бүхий ардчилсан улсуудад сөрөг хүчний тэргүүнийг сонгох журам янз бүр байдаг ч ерөнхийдөө парламентын доод танхим дахь хамгийн том сөрөг хүчний намыг тэргүүлдэг парламентын гишүүнийг томилдог зарчимтай. Тухайлбал, Мальтын Үндсэн хуулийн 90 дүгээр зүйлд<sup>212</sup> зааснаар тус улсын Ерөнхийлөгч нь сөрөг хүчний тэргүүнээр Төлөөлөгчдийн Танхим дахь тооны хувьд бусад сөрөг хүчний намуудаас хамгийн олон суудалтай намын дарга бүхий гишүүнийг томилно. Хэрэв сөрөг хүчин байхгүй, эсхүл хоёр ба түүнээс дээш тооны сөрөг хүчний намууд тэнцүү тооны суудал авсан бол засгийн газрын эсрэг байр суурьтай гишүүдийн бүлэг дотроос хамгийн олон дэмжлэг авсан гишүүнийг Ерөнхийлөгч сөрөг хүчний тэргүүнээр томилно.

Үүнээс үзэхэд, сөрөг хүчний тэргүүнийг томилоход сонголт багатай бөгөөд парламентад албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн хамгийн том сөрөг хүчний намтай тохиолдолд тус намын дарга бөгөөд парламентын гишүүнийг шууд томилдог.

Сөрөг хүчний тэргүүнээр томилогдсон гишүүн парламент (2 танхимтай бол доод танхим) дахь хамгийн том сөрөг хүчний намын даргын албан тушаалыг давхар хашдаг. Өөрөөр хэлбэл, намын даргын албан тушаалаасаа буусан, эсхүл парламентын гишүүний бүрэн эрх нь дуусгавар болсон бол сөрөг хүчний тэргүүний эрх, үүрэг мөн дуусгавар болно.

### *Ерөнхийлөгч (хагас ерөнхийлөгч)-ийн засаглалтай улсуудад*

Ерөнхийлөгч (хагас ерөнхийлөгч)-ийн засаглалтай улсуудад сөрөг хүчний тэргүүн (Ерөнхийлөгчийн эсрэг байр суурьтай) ба парламент дахь цөөнхийн бүлгийн дарга (парламент дахь олонхоос бусад) хоёрын ялгааг ойлгох нь чухал байдаг.

Ерөнхийлөгчийн засаглалд хууль тогтоох цөөнх болон сөрөг хүчин гэсэн ойлголтууд нь үргэлж ижилхэн байдаггүй. Учир нь ерөнхийлөгчийг дэвшүүлэн гаргасан нам нь парламент дахь цөөнх байх боломжтой. Тийм учраас сөрөг хүчний тэргүүнийг томилох, ажиллуулах тухай журмыг боловсруулахдаа энэ ялгааг анхаарах хэрэгтэй байдаг. Гүйцэтгэх засаглалын тэргүүнээр ерөнхийлөгч ажиллаж байгаа тохиолдолд сөрөг хүчний тэргүүнээр өөр намаас сонгох нь зохистой ба ингэснээр гүйцэтгэх засаглалд хяналт тавих боломжтой. Тухайлбал:

- Сейшлийн Үндсэн хуулийн 84 дүгээр зүйлд зааснаар сөрөг хүчний тэргүүнийг Үндэсний Ассамблейн гишүүдийн дундаас

<sup>212</sup> Constitution of Malta. <https://legislation.mt/eli/const/eng>

сонгох бөгөөд ингэхдээ зөвхөн Ерөнхийлөгчийн намаас бусад намын харьяалалтай гишүүд л сонгогдох болон санал өгөх эрхтэй.

- Мадагаскарын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар парламент дахь сөрөг хүчний бүлгүүд хоорондоо тохиролцоонд хүрээгүй тохиолдолд хамгийн олон санал авсан сөрөг хүчний бүлгийн даргыг албан ёсны сөрөг хүчний тэргүүнд тооцно. Энэхүү “сөрөг хүчин” гэсэн нэр томъёо нь Ерөнхийлөгчийн эсрэг байр сууриа илэрхийлдэг гишүүд (Өөрөөр хэлбэл, парламент дахь Ерөнхийлөгчийг дэвшүүлэн гаргасан намаас бусад намуудын төлөөллүүд) хамаардаг.

Дээрх зохицуулалтуудаас гадна тухайн цаг үе, нөхцөл байдлын улмаас бий болсон зарим “стандарт бус” зохицуулалтууд байдаг. Тухайлбал:

- **Урвахын эсрэг заалт (anti-defection clause):** Доминикийн Үндсэн хуулийн 66 дугаар зүйлд зааснаар Парламентын гишүүн нь гишүүнээр дахин сонгогдсон тохиолдолд сөрөг хүчний тэргүүнд нэр дэвших эрхтэй байдаг. Энэ нь засгийн эрх баригч намын гишүүн нь намаасаа гарч, улмаар сөрөг хүчний тэргүүн болохоос зайлсхийх арга болдог (Учир нь 2018 онд Барбадост ийм тохиолдол гарч байсан). Энэ нь Доминикийн улс төрийн тогтвортой байдал, намын сахилга бат, парламентын тогтолцооны бүрэн бүтэн байдлыг дэмжих зорилготой ажээ.
- **Парламентаас гадуурх сөрөг хүчин:** 2016 онд Гренадын Парламентад сөрөг хүчингүй, дан нэг намын төлөөлөл сонгогджээ. Үүнээс үүдэн парламентын гаднаас сөрөг хүчний тэргүүнийг томилох тухай өөрчлөлтийг Үндсэн хуульдаа оруулах санал гарсан боловч бүх нийтийн санал асуулгаар дэмжигдээгүй ажээ. Хэрэв энэ санал дэмжигдсэн бол хамгийн олон санал авсан сөрөг хүчний намын дарга нь сөрөг хүчний тэргүүнээр томилогдож, улмаар Парламентын гишүүн болох байв.
- **Сөрөг хүчний гишүүдийн тооны доод хэмжээ (Minimum size of the opposition):** Энэтхэгийн Парламент дахь сөрөг хүчний тэргүүний цалин, тэтгэмжийн тухай хуульд (1977 он) заасны дагуу сөрөг хүчний тэргүүнээр парламентын хоёр танхим дахь хамгийн том сөрөг хүчний намын дарга ажиллана. Гэхдээ парламентын доод танхим болох Лок Сабха (Ардын Танхим)-гийн даргын шийдвэрээр тухайн нам нь хамгийн багадаа танхимын гишүүдийн 10 хувийг бүрдүүлсэн байхыг шаардсан. Хэрэв сөрөг хүчний нам энэ шаардлагыг хангаагүй бол сөрөг



хүчний тэргүүний суудлыг сул үлдээдэг байв. Гэвч 1985 онд энэхүү шийдвэрийг хууль бус гэж үзээд Үндсэн хуулийн 52 дахь удаагийн нэмэлт, өөрчлөлтөөр хүчингүй болгожээ. Тухайн үед албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн сөрөг хүчний тэргүүн маш их хэрэгтэй байсан боловч сөрөг хүчний гишүүдийн тоо заасан хэмжээнд хүрэхгүй байсны улмаас ардчилсан зарчмаар яриа хэлэлцээ, мэтгэлцээн явуулах боломжгүй нөхцөл байдал үүсчээ. Өөрөөр хэлбэл, энэ нь Үндсэн хуулийн хоёрдмол утгатай, эсхүл учир дутагдалтай зохицуулалтууд сөрөг хүчнийг “байхгүй мэт болгоход” хүргэж болдгийн жишээ юм. Ийм нөхцөл байдал дахин үүсэхээс сэргийлэхийн тулд Үндсэн хуульд сөрөг хүчний тэргүүнийг дэмжих гишүүдийн доод хэмжээг зааж болохгүй гэсэн дүгнэлтэд хүрсэн байна.

### *Хоёр танхим бүхий парламенттай улсуудад*

Хоёр танхимтай парламентад сөрөг хүчний тэргүүн нь ихэвчлэн парламентын доод танхимын гишүүн байдаг (Өөрөөр хэлбэл, ард түмнээс сонгогдсон гишүүн). Түүхэн талаас нь авч үзвэл, сөрөг хүчний тэргүүн нь дээд танхимын гишүүн байж болох ч Вестминстерийн загварын ихэнх ардчилсан улсуудад ерөнхий сайдыг доод танхимаасаа сонгодог тул сөрөг хүчний тэргүүнийг мөн доод танхимаас сонгодог байна. Зарим хоёр танхимт парламентад сөрөг хүчний тэргүүн нь парламентын хоёр танхимд зэрэгцэн ажиллах тохиолдол байдаг. Жишээлбэл, Энэтхэгт Парламент дахь сөрөг хүчний тэргүүний цалин, тэтгэмжийн тухай хуулийн дагуу Лок Сабха (Ардын Танхим, доод танхим) болон Ража Сабха (Төрийн Зөвлөл, дээд танхим) нь тус тусдаа сөрөг хүчний тэргүүнтэй. Австралид мөн үүнтэй адил Төлөөлөгчдийн Танхим (доод танхим) болон Сенат (дээд танхим) дахь сөрөг хүчний тэргүүн нар тусдаа байдаг.

Парламентад хоёр танхимд тусдаа сөрөг хүчний тэргүүнтэй ч гагцхүү доод танхимын сөрөг хүчний тэргүүн л албан ёсны байх бөгөөд бүрэн хэмжээний эрх, үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэх давуу эрхтэй байдаг. Өөрөөр хэлбэл, доод танхим дахь сөрөг хүчний тэргүүн нь албан ёсоор парламентын дотор болон гадна талд сөрөг хүчнийг удирддаг бол дээд танхим дахь сөрөг хүчний тэргүүн нь тус танхим дахь сөрөг хүчний ерөнхий төлөөлөгч, эсхүл сөрөг хүчний үйл ажиллагааны менежер байна. Зарим тохиолдолд Зимбабвегийн Парламенттай адил парламентын хоёр танхим дахь сөрөг хүчний тэргүүн нарын эрх, үүрэг, хариуцлага адил байдаг.

*Гуравдагч болон жижиг намуудыг, бие даагчдыг хүлээн зөвшөөрөх асуудал*

Сөрөг хүчний тэргүүнийг хүлээн зөвшөөрдөг ихэнх ардчилсан улсуудын хувьд парламентад хамгийн их суудалтай хоёр намаас гадна гуравдагч болон бусад жижиг намуудын төлөөлөл байдаг. Тийм учир албан ёсны сөрөг хүчний тэргүүнээс гадна парламентад суудалтай бусад намуудын дарга нарыг хүлээн зөвшөөрөх асуудал үүсдэг.

Олон улсын туршлагаас үзэхэд, албан ёсны сөрөг хүчний эрх ашгийг дэмжих зарим арга хэлбэрийг бусад сөрөг хүчний намууд бас хэрэгжүүлэх боломжтой байна. Тухайлбал, парламентын хороодын албан тушаалын хуваарилалт, сөрөг хүчний өдрүүд, парламентын болон намын үйл ажиллагааг дэмжих хөрөнгийг сөрөг хүчний намуудад хуваарилах зэрэг зохицуулалтыг парламент дахь бусад сөрөг хүчний намууд мөн адил хэрэгжүүлдэг байна. Их Британид сөрөг хүчний хоёр дахь том намын дарга нь ихэвчлэн Privy council зөвлөлийн гишүүний хувьд тангараг өргөдөг. Соломоны арлуудын Үндсэн хуульд (66 дугаар хэсэг) Сөрөг хүчний тэргүүнийг хүлээн зөвшөөрөхөөс гадна бие даасан гишүүдийн тэргүүнийг албан ёсоор хүлээн зөвшөөрдөг. Иймээс бие даасан гишүүдийн тэргүүнийг хүлээн зөвшөөрч чадвал бусад сөрөг хүчний намын тэргүүн ч мөн адил хүлээн зөвшөөрөгдөх боломжтой гэж үздэг байна.

### *Сөрөг хүчний тэргүүнийг шинээр томилох*

Парламентын тухайн бүрэн эрхийн хугацаанд сөрөг хүчний намын дарга нас барсан, огцорсон, чөлөөлөгдсөн бол сөрөг хүчний тэргүүнээр ажиллах хугацаа мөн дуусгавар болох тул намын дараагийн дарга нь сөрөг хүчний тэргүүнээр ажилладаг. Ихэнх улсын, тухайлбал, Белиз, Доминик, Сент Люсия зэрэг улсуудын Үндсэн хуульд уг асуудлыг бас тусгасан байдаг.

### *Дэд түвшний засаглал (subnational governments)*

Олон улсын туршлагаас харахад сөрөг хүчин гэх ойлголт нь хүчирхэг орон нутгийн засаг захиргаа, бүс нутгийн эрх мэдэл, холбооны систем гэх мэт дэд түвшний буюу орон нутгийн засаглалд ч зэрэгцэн оршиж байдаг. Энэ тохиолдолд улс үндэсний түвшнээс гадна орон нутгийн түвшинд сөрөг хүчний тэргүүний эрх, үүргийг хүлээн зөвшөөрөх эсэх асуулт урган гарч ирдэг байна. Тиймээс улс орнууд уг асуудлыг Үндсэн хууль болон орон нутгийн түвшний хууль тогтоомжуудад зэрэг тусгасан байдаг. Жишээлбэл, Өмнөд Африкийн Үндсэн хуулийн 116.2-т мужийн түвшний хууль тогтоох байгууллагын хууль тогтоомжоор “хамгийн том сөрөг хүчний намын тэргүүн”-ийг сөрөг хүчний тэргүүний талаар зохицуулахыг хуульчилсан байна.



## **1.5.Сөрөг хүчний эрх, үүрэг**

Ардчилсан улсууд үндсэн хуульдаа сөрөг хүчин болон сөрөг хүчний тэргүүнийг албан ёсоор хүлээн зөвшөөрөх, томилох асуудлыг зохицуулахаас гадна түүний эрх, үүрэг болон хариуцлагын талаар мөн зохицуулсан байдаг.

### **1.5.1.Засгийн газарт хяналт тавих**

#### *Ерөнхий сайдын асуулгын цагаар мэтгэлцэх эрх*

Парламент дахь сөрөг хүчний тэргүүний хамгийн наад захын, олон нийтэд харагдахуйц үүрэг нь ерөнхий сайдын асуулгын цагаар асуулт асуух юм. Ерөнхий сайдын асуулга нь ихэвчлэн парламентын чуулганы хугацаанд долоо хоног бүр болдог бөгөөд парламентын гишүүд ерөнхий сайдаас цаг үеийн асуудлаар асуулт асууж, олон нийтийн анхаарлын төвд байгаа асуудлыг тодруулах, харин ерөнхий сайдын хувьд парламентад үйл ажиллагаагаа зөвтгөх, тайлбарлах боломжийг олгодог.

Ерөнхий сайдын асуулгын цагаар сөрөг хүчний тэргүүн нь эхэлж асуулт асуух давуу эрхтэй бөгөөд түүний дараа бусад сөрөг хүчний намын дарга нар асуулт асуудаг. Тэдний дараа л парламентын жирийн гишүүд (backbenchers – Засгийн газрын гишүүн бус, мөн сөрөг хүчний Сүүдрийн засгийн газрын гишүүн бус) асуулт асуух журамтай. Тиймээс сөрөг хүчний тэргүүн нь тухайн асуулгын өнгө аяс, чиглэлийг тогтоож, хэлэлцэх асуудалд нөлөөлөх боломжтой гэж үздэг. Мөн энэхүү мэтгэлцээний үйл явцыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулдаг тул мөн олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх боломжтой байдаг.

#### *Засгийн газарт итгэл үзүүлэх эсэх асуудлаар мэтгэлцэх эрх*

Мөн засгийн газарт итгэл үзүүлэх эсэх асуудлаарх мэтгэлцээний эхэнд ихэвчлэн сөрөг хүчний тэргүүн эхэлж үг хэлэх давуу эрхтэй байдаг. Тухайлбал, Вестминстерийн загвар бүхий улсуудад сөрөг хүчний тэргүүн нь ийм мэтгэлцээний үеэр эхэлж үгээ хэлдэг. Парламентаар хэлэлцэх засгийн газрын бодлогын тэргүүлэх чиглэл, хууль тогтоох хөтөлбөрийг тодорхойлсон энэхүү илтгэлийг парламентын чуулганы нээлтийн үеэр төрийн тэргүүн, эсхүл амбан захирагч тавьдаг уламжлалтай. Үүний дараа засгийн газрын бодлогын талаарх мэтгэлцээн өрнөж, улмаар засгийн газарт итгэл үзүүлэх эсэх асуудлаар санал хураалт явагддаг журамтай.

Тиймээс энэхүү мэтгэлцээн нь сөрөг хүчний тэргүүнд засгийн газрын хөтөлбөр болон гүйцэтгэлд бүхэлд нь эргэлзэх, итгэл хүлээлгэж болох эсэхийг засгийн газраас нотлохыг шаардах боломжийг тогтмол (жил бүр) олгодог.

*Парламентын хороон дахь сөрөг хүчний оролцоо*

Парламентын ихэнх ажлыг, ялангуяа хууль тогтоох, хяналт шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлэх зэрэг ажлыг парламентын хороод гүйцэтгэдэг. Парламентын хороодыг бүрдүүлэхдээ парламентад суудалтай намуудыг өргөн хүрээнд хамруулдаг байна. Өөрөөр хэлбэл, хороодын албан тушаалыг олонх болон сөрөг хүчний намуудад парламентад авсан суудлын дагуу хувь тэнцүүлэн хуваарилах нь түгээмэл жишиг юм. Хороодын бүрэлдэхүүнийг ихэвчлэн үндсэн хууль, бусад хууль тогтоомж, эсхүл парламентын шийдвэрээр тогтоодог. Зарим улсын үндсэн хуульд засгийн газар, сөрөг хүчин хоорондын тэнцвэрийг хангах ерөнхий дүрмийг заадаг. Тухайлбал, Мальтын Үндсэн хуулийн 67 дугаар зүйлд Парламентын хороод нь нийгмийн ач холбогдол бүхий асуудлыг хянаж шалгадаг тул хороодыг бүрдүүлэхдээ Парламентын гишүүдийн хуваарилалтыг шударгаар хийхийг заасан байдаг. Үүний нэгэн адил Тунисын Үндсэн хуулийн 59 дүгээр зүйлд Хороодыг пропорционал төлөөллийн аргаар бүрдүүлэхээр хуульчилсан бол Сьерра-Леоны Үндсэн хуулийн 93 дугаар зүйлд Хороодын бүрэлдэхүүнд парламент дахь улс төрийн намууд болон бие даагч гишүүдийг хамруулахаар заасан байна.

Парламентын хороодын даргын албан тушаалыг засгийн эрх баригч болон сөрөг хүчний намуудад пропорционал хуваарилах хандлагатай байдаг. Тухайлбал, Шинэ Зеландад Парламентын нийт хороодын тал орчим хувийг нь сөрөг хүчний гишүүд даргалдаг (албан ёсны сөрөг хүчин, эсхүл сөрөг хүчний намуудын аль нэг) бол Австралид ихэвчлэн хорооны даргаар засгийн эрх баригч намаас, дэд даргаар сөрөг хүчний намаас сонгогддог. Гадаад улсуудын туршлагаас үзэхэд, уг асуудлыг үндсэн хуулийн хүрээнд хүлээн зөвшөөрч зохицуулсан байна. Тухайлбал, Мадагаскарын Үндсэн хуулийн 78 дугаар зүйлд хороодын 1/3-ээс доошгүйг нь сөрөг хүчний гишүүд даргалахаар хуульчилсан байна.

Мөн зарим улсын үндсэн хуульд парламентын хорооны даргатай холбоотой тусгай зохицуулалтуудыг тусгасан байна. Энэ нь ихэвчлэн санхүү, төсөвт хяналт тавих хороодод үйлчилнэ. Вестминстерийн загвар бүхий парламентад санхүүгийн хороог сөрөг хүчний гишүүн даргалах нь түгээмэл байдаг. Тухайлбал, Тринидад Тобагогийн Үндсэн хуулийн 119 дүгээр зүйлд “Улсын төсвийн хорооны дарга нь Төлөөлөгчдийн Танхим дахь сөрөг хүчний гишүүн байна” гэж, Тунисын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлд Санхүүгийн хорооны дарга, Гадаад харилцааны хорооны илтгэгчээр сөрөг хүчний гишүүнийг томилохоор заасан байна.

*Мөрдөн шалгах хороон дахь сөрөг хүчний давуу эрх*

Зарим улсын үндсэн хуульд парламентын цөөнх, эсхүл тодорхой тооны гишүүдийн хүсэлт, шаардлагаар парламентын мөрдөн шалгах хороо

байгуулахыг зөвшөөрдөг. Энэ нь сөрөг хүчин, эсхүл хууль тогтоох цөөнхийн гарт байгаа хүчирхэг хэрэгсэл болж, бодлогын шийдвэрээ сайтар хянаж шалгах боломжийг олгодог. Тухайлбал:

- Португалд Парламентын гишүүн бүр чуулганы хугацаанд нэг удаа мөрдөн шалгах хороо байгуулах санал гаргаж болох ба хэрэв гишүүдийн 1/5 нь уг саналыг дэмжсэн бол мөрдөн шалгах хороо байгуулна. (Үндсэн хуулийн 178 дугаар зүйл);
- Мозамбикт Парламент дахь бүлэг болгон мөрдөн шалгах хороо байгуулах санал гаргаж болно (Үндсэн хуулийн 197 дугаар зүйл);
- Тунист Парламент дахь сөрөг хүчин нь жил бүр мөрдөн шалгах хороо байгуулж, түүнийг удирдах эрхтэй (Үндсэн хуулийн 61 дүгээр зүйл);
- Гүржид Парламентын гишүүдийн 1/5 нь хүсэлт гаргаж, 1/3 нь зөвшөөрснөөр мөрдөн шалгах хороо байгуулна. (Үндсэн хуулийн 42 дугаар зүйл). Үүний дагуу сөрөг хүч нь парламентын мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх мэдэлтэй болдог. Гүржийн Парламент дахь бүх бүлгүүдээс хамгийн багадаа нэг гишүүн нь мөрдөн шалгах хороонд ажиллах бөгөөд энэ нь сөрөг хүчний бүлгүүдэд олонх байх баталгаа болдог.

### *Сөрөг хүчний үйл ажиллагаанд зориулсан тусгай өдөр*

Зарим улсад парламентын хуралдааны тодорхой өдрүүдийг бусад үйл ажиллагаанд тусгайлан хуваарилдаг. Тухайлбал, сөрөг хүчинд мөрийн хөтөлбөрөө тодорхойлох боломж олгодог “Сөрөг хүчний өдөр” нь Вестминстерийн загвар бүхий зарим улсад олон жилийн турш хэрэгжиж байна. Их Британид жил бүр Парламентын чуулганы 20 орчим өдрийг “Сөрөг хүчний өдөр”-т зориулдаг. Үүнээс дийлэнх өдрүүд нь албан ёсны сөрөг хүчинд (хамгийн том сөрөг хүчин), бусад өдрүүд нь бусад сөрөг хүчинд хуваарилагддаг байна.

2009 оноос хойш Парламентын жирийн гишүүдэд (Засгийн газрын гишүүн бус, мөн сөрөг хүчний Сүүдрийн засгийн газрын гишүүн бус) зориулж нам дамнасан хорооноос<sup>213</sup> санал болгосон асуудалтай холбоотой нэмэлт өдрүүдийг (backbench business day) хуваарилдаг болжээ. Түүнээс гадна хувь гишүүнд зориулж тусад нь Парламентын цаг гаргаж болох бөгөөд энэ нь гишүүдэд хууль санаачлах ажлыг илүү үр дүнтэй хийх боломж олгох зорилготой.

Олон улсын туршлагаас үзэхэд, сөрөг хүчний намуудад парламентын хуралдааны цагийн тодорхой хэсгийг ийнхүү тусгайлан зориулдаг зарчмыг үндсэн хуулиар зохицуулж байна. Тухайлбал, Мароккогийн

<sup>213</sup> Нам дамнасан бүлэг нь хоёр ба түүнээс дээш улс төрийн намын гишүүдээс бүрдэнэ.

Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд сөрөг хүчний “хууль тогтоох үйл ажиллагаанд үр дүнтэй оролцох, ялангуяа парламентын хоёр танхимын хэлэлцэх асуудлын дараалалд хуулийн төслийг оруулах замаар”, өөрөөр хэлбэл, парламентын цагийн хуваарьт сөрөг хүчний өргөн мэдүүлсэн болон дэмжсэн хуулийн төслүүдээ оруулах эрхийг баталгаажуулжээ. Сейшлийн арлуудад Үндэсний Ассамблейн дарга нь хэлэлцэх асуудлын дарааллыг тогтоохын өмнө сөрөг хүчний тэргүүнтэй заавал зөвлөлдөх ёстой байдаг.

### **1.5.2. Төрийн байгууллагуудын томилгоотой холбоотой эрх**

Үндсэн хуулиар зохицуулж болох өөр нэг чухал асуудал бол төрийн байгууллагуудын томилгооны асуудал юм. Үүнд, шүүх, сонгуулийн хороо, хилийн комисс, төрийн албаны комисс зэрэг байгууллагын томилгоо орно.

*Шүүх засаглал болон дөрөв дэх засаглалын томилгоо (judicial and fourth-branch institutions)*

Энэ нь засгийн газар, төрийн болон нам бус байгууллагуудын хоорондын зааг хязгаарыг тодорхой байлгах, тэдгээрийг дан ганц засгийн газрын хяналтад байхаас сэргийлэх зарчим юм. Олон улсын практикт, парламентын олонхын засгийн газарт бодлогоо тодорхойлох, хөтөлбөрөө хэрэгжүүлэх эрх, боломж олгодог хэдий ч улс төрийн тогтолцоог бүхэлд нь хяналтдаа байлгаж, дангаар ноёрхохоос сэргийлж байх зарчмыг хэрэгжүүлдэг. Ялангуяа шүүхийн хараат бус байдал, засаг захиргааны төвийг сахисан байдал, сонгуулийн үйл явцын шударга байдлыг хангах ёстой ба эдгээртэй холбоотой томилгооны асуудалд сөрөг хүчин үүргээ хэрэгжүүлэх хэд хэдэн жишиг аргууд байдаг.

- **Зөвлөлдөх (consultative procedure):** Ихэнх тохиолдолд сөрөг хүчний тэргүүн томилгоонд зөвхөн зөвлөлдөх үүрэгтэй байдаг. Тухайлбал, Ямайкад Ерөнхий сайд нь Ерөнхий шүүгч, Давж заалдах шатны шүүхийн дарга, Төрийн албаны болон Цагдаагийн албаны комиссын гишүүд, Шүүх, хууль зүйн албаны комисст нэр дэвшүүлсэн 3 гишүүнийг томилохын өмнө сөрөг хүчний тэргүүнтэй заавал зөвлөлдөнө. Ерөнхий сайд Үндсэн хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу томилгоо хийхээс өмнө сөрөг хүчний тэргүүнтэй зөвлөлдөх ба зөвшөөрсөн тохиолдолд Ерөнхий амбан захирагч (Хааны нэрийн өмнөөс) уг томилгоог хийдэг. Хэрэв Сөрөг хүчний тэргүүн зөвшөөрөөгүй бол Ерөнхий амбан захирагч Ерөнхий сайдаас эргэн харахыг хүсэх ёстой. Гэсэн ч эцсийн шийдвэрийг Ерөнхий сайд гаргах бөгөөд сөрөг хүчний тэргүүн хориг тавих эрхгүй. Зөвлөлдөх процедурын үр нөлөө нь олон хүчин зүйлээс, тухайлбал, Ерөнхий сайд, сөрөг

хүчний тэргүүн нарын хувийн болон улс төрийн харилцаа, хоёр намын хамтын ажиллагааны улс төрийн зөвшлийн бэхжилт зэргээс хамаарна гэж үздэг.

- **Харилцан тохиролцох (concurrent procedure):** Энэ тохиолдолд ерөнхий сайд болон сөрөг хүчний тэргүүн томилгоо хийхдээ харилцан тохиролцох ёстой бөгөөд энэ нь сөрөг хүчний тэргүүнд хориг тавих боломж олгодог. Өөрөөр хэлбэл, томилогдохоор нэр дэвшсэн хүн нь хоёр талд хүлээн зөвшөөрөгдөх ёстой гэсэн үг. Энэ нь зөвлөлдөх процедуртай харьцуулахад түгээмэл бус байдаг. Гэсэн ч зөвлөлдөх аргаар үр дүнд хүрээгүй, эсхүл үр дүнд хүрэх магадлал багатай нөхцөлд харилцан тохиролцох нь илүү үр дүнтэйд тооцогддог.
- **Төлөөлөх (representative procedure):** Энэ нь Ерөнхий сайд болон сөрөг хүчний тэргүүний аль алинд нь тодорхой тооны томилгоо хийх боломжийг олгодог. Тухайлбал, Антигуа ба Барбудагийн Үндсэн хуулийн 63 дугаар зүйлд Хилийн тойргийн комиссын нийт 4 гишүүнээс нэг гишүүнийг сөрөг хүчний тэргүүн, хоёр гишүүнийг Ерөнхий сайд нэр дэвшүүлэх бөгөөд үлдсэн нэг гишүүнийг тус комиссын даргын санал болгосноор томилдог.
- **Хувь тэнцүүлэх (proportional procedure):** Энэ нь олон намтай нөхцөлд болон олон гишүүнтэй томилгоонд тохирсон төлөөлөх процедурын нэг төрөл юм. Энэ аргын зарчим нь томилгоо хийх үед намууд парламент дахь суудлын хувь хэмжээгээр пропорционал хувилбараар сонгодог, эсхүл томилдог. Тухайлбал, Австрид Омбудсмэний чиг үүргийг парламентын доод танхим болох Үндэсний Зөвлөлөөс сонгогддог гурван гишүүн бүхий зөвлөл гүйцэтгэдэг. Тус улсын Үндсэн хуульд зааснаар Үндэсний Зөвлөлд хамгийн олон мандаттай гурван нам тус бүр нэг гишүүнийг нэр дэвшүүлэх эрхтэй.
- **Томилгооны комисс байгуулах (appointments commission procedure):** Фижи, Балба, Сейшелийн арлууд, Шри-Ланка зэрэг улсад төрийн байгууллагуудын томилгооны асуудлыг авч хэлэлцэх үүрэг бүхий Томилгооны комисс байгуулж, бүрэлдэхүүнд нь сөрөг хүчний тэргүүнийг оруулдаг. Тухайлбал, Фижид ийм комисс нь Хүний эрхийн хороо, Ялгаварлан гадуурхалтын эсрэг хороо, Сонгуулийн хороо, Төрийн албаны комисс зэрэг байгууллагын гишүүнд болон Цагдаагийн комиссар, Ерөнхий аудитор зэрэг албан тушаалд нэр дэвшүүлэх үүрэгтэй. Комисс нь 6 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд үүнд: Ерөнхий сайд, сөрөг хүчний тэргүүн, Ерөнхий прокурор, мөн Ерөнхий сайдын санал

болгосон хоёр хүн, сөрөг хүчний тэргүүний санал болгосон нэг хүн байна. Комиссын бүрэлдэхүүнд орж буй Ерөнхий прокурор нь Ерөнхий сайдын оролцоотой томилогддог албан тушаалтан тул энэ улсын хувьд комиссын 6 гишүүний 4-ийг нь засгийн эрх баригч талаас, 2-ийг нь сөрөг хүчнээс бүрдүүлж байна. Энэ тохиолдолд сөрөг хүчний зүгээс томилгоог хүлээн зөвшөөрөөгүй бол хориг тавих боломжгүй (дээр дурдсан зөвлөлдөх аргатай илүү төстэй). Харин Сейшлийн арлуудад Томилгооны комисст Ерөнхийлөгч болон сөрөг хүчний тэргүүн тус бүр хоёр гишүүнийг томилдог. Өөрөөр хэлбэл эрх баригч болон сөрөг хүчин тэнцүү төлөөлөлтэй байна. Сейшлийн арлуудын энэхүү зохицуулалт Фижигээс ялгаатай нь томилгоо хийхдээ сөрөг хүчнийг хяналт шалгалт хийх боломжоор хангадаг байна.

- **Сөрөг хүчинд олгох онцгой эрх (exclusive opposition appointments):** Зарим тохиолдолд, сөрөг хүчин томилгоо хийхэд зөвхөн оролцоод зогсохгүй томилох эрхтэй байна. Тухайлбал, Аргентинд Ерөнхий аудиторыг Үндэсний Конгресс дахь хамгийн том сөрөг хүчний намын саналаар томилдог.
- **Супер олонхын томилгоо (supermajority appointment procedure):** Сөрөг хүчин, эсхүл хууль тогтоох цөөнхөд нэг гишүүнтэй байгууллагын томилгоонд санал өгөх боломжийг олгодог. Тухайлбал, Болгарт Шүүхийн дээд зөвлөлийн гишүүдийн тэн хагасыг Үндэсний Ассамблейн гишүүдийн 2/3-ын олонхын саналаар сонгодог (Үндсэн хууль, 130 дугаар зүйл). Португалд Үндсэн хуулийн шүүхийн 10 гишүүн, Омбудсмэн, Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн ерөнхийлөгч, Шүүхийн дээд зөвлөлийн 7 гишүүн, хэвлэл мэдээллийн зохицуулах байгууллагын гишүүдийг сонгохдоо парламентын нийт гишүүдийн 2/3-ын олонхын саналаар шийдвэрлэнэ. (Үндсэн хууль, 163 дугаар зүйл).

*Гүйцэтгэх засаглалыг тэргүүлдэггүй ерөнхийлөгчийг томилох (Appointment of ceremonial presidents)*

Ерөнхийлөгч нь гүйцэтгэх засаглалыг тэргүүлдэггүй бөгөөд нам бус төрийн тэргүүн байдаг парламентын бүгд найрамдах улсуудад ерөнхийлөгчийг томилохдоо сөрөг хүчний оролцоог хангадаг. Тухайлбал, Доминикт Ерөнхийлөгчийг Ерөнхий сайд болон сөрөг хүчний тэргүүн хамтран томилж болдог (Үндсэн хууль, 19 дүгээр зүйл) ба тэд нэг нэр дэвшигчид санал нийлсэн бол тухайн нэр дэвшигч шууд томилогдоно. Харин санал нийлээгүй бол Ерөнхий сайд болон сөрөг хүчний тэргүүний дэвшүүлсэн нэр дэвшигчдийн аль нэгийг сонгохын тулд Парламентад санал хураалт явуулна. Гэхдээ санал хураалтын үр дүнд Ерөнхий сайдаас нэр дэвшүүлсэн хүнийг сонгох магадлал өндөр гэж үздэг.



### *Сөрөг хүчний сенаторуудыг томилох*

Карибын тэнгисийн хамтын нөхөрлөлийн ихэнх улсад сөрөг хүчний тэргүүний нэмэлт үүрэг нь тодорхой тооны сенаторуудыг томилох байдаг. Томилогдсон сенаторууд мэтгэлцээн явуулах, асуулт асуух, хорооны үйл ажиллагаанд оролцоходоо дээд танхимд сөрөг хүчний оролцоог баталгаажуулдаг. Сенаторын тооны хувьд улс орнууд харилцан адилгүй байна. Тухайлбал, Барбадосын Үндсэн хуулийн 36 дугаар зүйлд зааснаар нийт 21 сенаторын 2-ыг сөрөг хүчний тэргүүн, 12-ыг Ерөнхий сайд, 7 бие даагчийг Амбан захирагч томилдог. Тринидад ба Тобагод нийт 31 сенаторын 6-г нь сөрөг хүчний тэргүүн, 16-г нь Ерөнхий сайд, 9-ийг (намаас бус, нийгэм эдийн засгийн салбарт ажилладаг хүмүүсээс) нь Ерөнхийлөгч сонгодог. Энэ зарчимаар, нэг талаасаа засгийн эрх баригч талын сенаторууд хууль батлахад олонх байх, нөгөө талаасаа сөрөг хүчний сенаторууд нь бие даагч сенаторуудын хамт Үндсэн хуульд өөрчлөлт оруулахад хориг тавьж чадах боломж бүрддэг. Энэ нь Үндсэн хуулийн өөрчлөлтийг, наад зах нь хуулийн тодорхой заалтуудыг батлахын тулд заавал сөрөг хүчин болон бие даагчидтай зөвшилцөх ёстой гэсэн үг. Өөрөөр хэлбэл, засгийн газар бодлогоо тодорхойлж болох ч Үндсэн хуулийн өөрчлөлтийг дангаараа хийх боломжгүй байна.

#### **1.5.3. Сөрөг хүчний тэргүүний бусад эрх, үүрэг**

##### *“Privy Council” зөвлөлдөх эрх*

Их Британид сөрөг хүчний тэргүүн нь “Privy Council”-ийн гишүүний хувиар тангараг өргөдөг. Энэ зөвлөл бүрэн бүрэлдэхүүнээрээ хуралдах нь ховор бөгөөд зөвлөлийн чиг үүргийг зөвхөн сайд нар гүйцэтгэдэг. Гэсэн ч зөвлөлийн дүрмийн дагуу сөрөг хүчний тэргүүн нь хүлээн авсан мэдээллийн нууцыг задруулахгүй байх үүрэгтэй. Үүнтэй төстэй чиг үүргийг Канадын Хааны нууц зөвлөл хэрэгжүүлдэг. Зарим улсад үндсэн хуулиар байгуулагдаагүй, эсхүл Ямайкийн нэгэн адил тодорхой чиг үүргийг гүйцэтгэх, тухайлбал, өршөөл үзүүлэх талаар зөвлөгөө өгөх.

Сөрөг хүчний тэргүүн нь үндэсний аюулгүй байдал, цэргийн байршил, гадаад харилцааны асуудал зэрэг нам, улс төрийн бус мэдээллийг тогтмол авдаг. Энэ нь улс орны ач холбогдолтой асуудлаар зөвшилцөлд хүрэх, сонгуулийн мөчлөгөөр бодлогын тогтвортой байдлыг хангахад засгийн газар болон сөрөг хүчин хоорондын харилцааны ашигтай суваг болж чадна гэж үздэг.

##### *Санхүүжилт болон бусад хангамжаар хангагдах эрх*

Ихэнх улсад сөрөг хүчний тэргүүнд түүний үндсэн эрхээс гадна санхүүгийн болон бусад давуу эрхийг олгодог. Эдгээр нь сөрөг хүчний тэргүүний

байр суурь, нөхцөл байдал, олон нийтэд харагдах байдлыг дээшлүүлж, удирдагчийн үүргээ биелүүлэх чадварыг нэмэгдүүлнэ гэж үздэг.

Олон улсын практикт, сөрөг хүчний тэргүүний цалингийн хэмжээ нь Ерөнхий сайдынхаас бага байх боловч засгийн газрын сайдын цалинтай тэнцүү байдаг. Тухайлбал, Сейшелийн арлуудын Үндсэн хуулийн 84 дүгээр зүйлд энэ зарчмыг тусгасан байна: “Сөрөг хүчний тэргүүний цалин, хангамж, тэтгэмж, тэтгэврийн хэмжээ нь сайдад төлөх ёстой хэмжээнээс багагүй байх бөгөөд төсвийг нь Нэгдсэн санд тусгана.”

Үүнээс гадна сонгуулийн санхүүжилт, албан өрөө, ажлын алба, томилолт, автомашин, мэдээлэл технологи, харилцаа холбоо, тоног төхөөрөмж, номын сангийн үйлчилгээ болон судалгаа хийлгэх зэргээр хангагдаж болно. Их Британийн Парламент доод танхимынхаа сөрөг хүчний намуудад 1975 оноос хойш төрийн сангаас “Short money” гэж нэрлэгдэх санхүүжилт олгодог болсон. Зөвхөн сөрөг хүчний тэргүүнд албан үйл ажиллагаанд нь зориулж тогтмол санхүүжилт олгогддог. Түүнчлэн зөвхөн албан ёсны сөрөг хүчин гэлтгүй сөрөг хүчний бүх намд парламентын үйл ажиллагаа, томилолтын зардалд зориулж санхүүжилт олгодог. Санхүүжилтийн хэмжээг намуудын Парламентад авсан суудлыг харгалзан тооцдог. Марокко нь Үндсэн хуулиараа сөрөг хүчний намын статус, санхүүжилт болон хангамжийн асуудлыг хамгийн өргөн хүрээнд зохицуулсан улсуудын нэг юм. Тус улсын Үндсэн хуульд (10 дугаар зүйл) Сөрөг хүчний намуудын санхүүжилт төдийгүй олон нийтийн өргөн нэвтрүүлгийн эфирийн цагийн хуваарийг хүртэл тусгаж баталгаажуулсан байдаг. Гэхдээ сөрөг хүчний намуудын эдгээр болон бусад эрх, давуу эрх практикт хэрхэн хэрэгжих талаарх нарийвчилсан асуудлыг органик хуулиар зохицуулдаг байна.

*Парламентын дотоод удирдлага, зохион байгуулалтад оролцох эрх (Parliamentary leadership and administration)*

Сөрөг хүчин парламентын удирдлага, дотоод зохион байгуулалтын асуудалд оролцож болох ба зарим улсад үүнийг хуулийн хүрээнд зохицуулсан байдаг. Олон улсын туршлагаас үзэхэд, сөрөг хүчин зөвхөн парламентын үйл ажиллагааны зохион байгуулалт, дэг журамд хяналт тавихаас гадна түүний биет хөрөнгө болох барилга байгууламж, албан өрөө, номын сан, архив, түүгээр зогсохгүй автомашины зогсоол зэрэгт хяналт тавьдаг. Ийм асуудалд сөрөг хүчний дуу хоолой байх нь парламент бүхэлдээ гишүүдийнхээ эрх ашгийн төлөө ажиллаж, засгийн газар, сөрөг хүчин хоорондын институцийн зохистой тэнцвэрт байдлыг хангахад амин чухал гэж үздэг. Тухайлбал:

- 1985 оны Канадын Парламентын хуулийн 50 дугаар зүйлийн дагуу Нийтийн Танхимын байр, үйлчилгээ, ажилтнуудын



санхүүгийн асуудлыг удирдах зорилгоор Дотоод эдийн засгийн зөвлөл байгуулагджээ. Сөрөг хүчний тэргүүн өөрөө, эсхүл түүний нэр дэвшүүлсэн хүн энэ зөвлөлийн гишүүн байх эрхтэй (Засгийн эрх баригч талаас нэр дэвшүүлсэн хүмүүсийн хамт). Нийтийн Танхим хамгийн багадаа 12 гишүүнтэй хоёр ба түүнээс дээш сөрөг хүчний намтай тохиолдолд тус бүр нэг гишүүнийг тус зөвлөлийн гишүүнээр томилно.

- Армений Үндсэн хуулийн 104 дүгээр зүйлд зааснаар Парламентын дотоод удирдлагыг Парламентын дарга нь гурван гишүүний хамт удирддаг бөгөөд тэдний нэг нь сөрөг хүчнээс сонгогдоно.
- Зимбабвед “Парламентын удирдлагыг хянах” үүрэгтэй Парламентын байнгын хороо ажилладаг бөгөөд түүнд хоёр танхимын сөрөг хүчний тэргүүнийг оруулахаар Үндсэн хуулийн 151 дүгээр зүйлд заажээ.
- Германд Парламентад суудалтай бүх намын төлөөллийг багтаасан Ахмадын зөвлөл байгуулдаг ба хамгийн том намаас Зөвлөлийн даргыг (Бундестаг буюу доод танхимын дарга), бусад нам тус бүрээс дэд дарга нарыг сонгодог байна.
- Гүржийн Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлд “Парламентын ажлыг зохион байгуулах зорилгоор Парламентын товчоо байгуулж болох ба энэ нь Парламентын дарга, дэд дарга, хороодын болон Парламентын бүлгийн дарга нараас бүрдэнэ” гэж заасан байдаг.

## 1.6.Цөөнхийн хориг тавих болон зөвшилцөх эрх

### *Хэт олонх буюу цөөнхийн хоригийн зарчмууд*

Парламентын хэт олонх хүссэн хуулийн төслөө хүч түрэн батлахыг хязгаарлах боломж олгох үүднээс хэт олонхын шалгууртай (2/3-ын саналаар Үндсэн хуульд өөрчлөлт оруулах гэх мэт) хамт цөөнхийн хориг тавих эрхийн шалгуурыг бас тодорхойлох боломжтой. Хоригийн үр дүн нь тухай хоригийг хэрэгжүүлж буй цөөнхийн хэмжээ болон хоригийн үйлчлэх хүрээнээс (хоригийн далайц, үргэлжлэх хугацаа, цуцлах нөхцөл гэх мэт) хамаарна.

Цөөнхийн хоригийн зарчим нь олонхын шийдвэр гаргах эрхийг булаах бус, харин цөөнх нь олонхын шийдвэртэй холбоотой эсрэг байр сууриа илэрхийлэх, тухайн шийдвэрийг өргөн хүрээнд хэлэлцүүлэх, олон нийтийг дайчлах боломж олгоход чиглэгдэж байдаг.

Судалгаанд дараах хоёр төрлийн механизмыг авч үзнэ:

- хуулийн төсөл хэлэлцэн батлахыг хойшлуулах механизм (зөвхөн хуулийн хэрэгжилтийг хойшлуулна);

- санал асуулга явуулах эрх (цөөнх олон нийтийн дэмжлэгтэйгээр хуулийг хүчингүй болгох).

### *Хуулийн төсөл хэлэлцэн батлахыг хойшлуулах механизм*

Зарим улсын үндсэн хуулиар парламентын цөөнхөд хуулийн төсөл хэлэлцэн батлахыг хойшлуулах эрх олгодог. Тухайлбал, Шведийн Үндсэн хуулийн 22 дугаар зүйлд зааснаар үндсэн эрхийг хөндсөн хуулийн төслийг хэлэлцэн батлахыг парламентын хамгийн багадаа 10 гишүүний шаардлагаар нэг жилийн хугацаатай хойшлуулж болох ба гишүүдийн 5/6-ийн буюу 83 хувийн саналаар уг шаардлагыг хүлээн авахгүй байж болно. Хэрэв тухайн цөөнхийг бүрдүүлж буй намын бүлэг нь парламентын 1/6-ийг бүрдүүлж буй бол хойшлуулах эрхийг хэрэгжүүлэх боломжтой. Гэхдээ хойшлуулах механизм нь хуулийг цуцална гэсэн үг биш бөгөөд эцсийн дүндээ ердийн олонхоор хуулийн төслийг батална.

Парламент дахь цөөнх нь хуулийн төсөл хэлэлцэн батлахыг хойшлуулснаар нэг жилийн хугацаанд олон нийт, хэвлэл мэдээллээр хэлэлцүүлэх боломжтой. Эсрэгээрээ олонх нь олон нийтийн дэмжлэг авахын тулд хуулийн төслийн ач холбогдлыг ухуулан таниулах шаардлага үүсдэг.

Хойшлуулах эрхийг цөөнхөд олгосноор (цөөнх энэ эрхээ хэрэгжүүлээгүй байсан ч) олонх хууль батлахдаа илүү уян хатан ханддаг. Засгийн газар аливаа хуулийг парламентаар батлуулахдаа цөөнхийн эсэргүүцэлтэй тулгарч, хойшлуулах механизмыг хэрэгжүүлэхээс сэргийлэн эхлээд цөөнхтэй зөвшилцөн санал бодлыг нь тусгахыг эрмэлздэг.

Мөн яарсан буюу дутуу боловруулагдсан хуулийн төслийг олонхын зүгээс хүч түрэн батлахаас сэргийлдэг. Өөрөөр хэлбэл, хэрэв тухайн хуулийн төсөл нь жилийн хугацаагаар хойшлогдох магадлалтай бол засгийн газар, олонх нь яаран батлахын оронд илүү нухацтай хандан олон талын санал бодлыг тусгахыг эрмэлздэг.

Тухайлбал, Данийн Үндсэн хуулийн 41.3-т зааснаар Парламентын гишүүдийн 2/5-ийн шаардлагаар аливаа хуулийн төслийг 12 хоногийн хугацаатай хойшлуулж болох бол Шведэд хойшлуулах эрх нь зөвхөн үндсэн эрхийг хөндсөн хуулийн төсөлд хамаарна. Өөрөөр хэлбэл, Шведтэй харьцуулахад Данийн хойшлуулах эрх нь өндөр босготой ч илүү өргөн хүрээг хамаардаг. Гэхдээ Данийн хойшлуулах эрх нь төсөв мөнгө, иргэншил, онцгой үеийн хуулийн төсөлд хамаарахгүй.

Хэдийгээр 12 хоногийн хугацаагаар хойшлуулах нь чамлалттай боловч олонх хуулийн төслийг цөөнхөөр хэлэлцүүлэхгүйгээр яаран батлахаас

сэргийлж чаддаг төдийгүй богино хугацаанд ч тухайн хуулийн төслийг олон нийт, хэвлэл мэдээллээр хэлэлцүүлэх, тухайн хуульд олон нийтийн анхаарлыг хандуулах боломжийг олгодог.

### *Санал асуулга явуулах эрх*

Данийн Үндсэн хуульд дээр дурдсан хойшлуулах механизмаас гадна цөөнхийн хүсэлтээр санал асуулга явуулах боломжийг мөн тусгажээ. Энэ нь Парламентаар батлагдсан хуулийг Хаан батламжлахаас өмнө гишүүдийн 1/3-ийн саналаар, олон нийтийн санал асуулга явуулах хүртэл тухайн хуулийн хэрэгжилтийг түдгэлзүүлж болдог. Парламентын гишүүдийн 1/3 нь гарын үсэг зурсан шаардлагыг хууль батлагдсанаас хойш 3 хоногийн дотор Парламентын даргад хүргүүлэх бөгөөд санал асуулгыг тухайн хуулийг олон нийтэд танилцуулснаас хойш ажлын 12 хоногийн дараа, ажлын 18 хоногоос хэтрүүлэлгүйгээр (хэт богино хугацаатай) зохион байгуулна. Хэрэв засгийн газар болон олонх нь санал асуулгын дүнгээр олон нийтийн дэмжлэг авч чадахгүй бол хуулиа эргүүлэн татаж болно. Харин санал асуулга явагдаж санал өгсөн иргэдийн олонх нь, мөн нийт сонгогчдын 30 хувь нь хуулийн эсрэг санал өгсөн бол Хаан тухайн хуулийг батламжлахгүй. Зарим тохиолдолд яаралтай горимоор Хааны батламжилсан хуулийн эсрэг олон нийт санал өгсөн бол тухайн хуулийг хүчингүйд тооцно. Гэхдээ цөөнхийн хүсэлтээр санал явуулах эрх олгосон заалтыг төсөв мөнгө, иргэншилтэй холбоотой хууль, олон улсын гэрээ хэлэлцээрт нийцүүлсэн хууль, Хааны угсаа замгалжлалын хуульд хэрэглэдэггүй.

Цөөнхийн хүсэлтээр санал асуулга явуулах механизм нь засгийн газрын үйл ажиллагааг гацааж, хууль батлах явцыг хүндрэлтэй болгож байгаа (цөөнх хүссэн асуудлаар санал асуулга явуулахыг шаардаж болно) мэт боловч бодит байдалд энэ нь тийм биш юм. Энэ заалт 1953 онд батлагдсанаас хойш 2 удаа л санал асуулга явуулжээ. Энэ механизмын гол ач холбогдол нь олонхын хууль батлах үйл явцыг илүү уян хатан болгоно гэж үздэг. Үүнд, нэгдүгээрт, эрх баригч олонх нь цөөнхийг санал асуулга явуулах эрхээ хэрэгжүүлэхгүй байлгахын тулд цөөнхтэй зөвшилцөхийг оролддог. Хоёрдугаарт, энэ нь хориг тавих үнэмлэхүй эрх биш бөгөөд цөөнхийн хувьд асуудлыг хамтын шийдэлд хүргэж байгаа арга хэлбэр юм. Эцэст нь шийдвэрийг парламентын олонхоор баталдаг. Хэрэв цөөнх санал асуулга явуулах эрхээ хэт их ашиглавал улс төрийн хувьд төлөвшөөгүй улс төрийн хүчин болж харагддаг ажээ.

Латвийн Үндсэн хуулийн дагуу Ерөнхийлөгчийн хүсэлтээр, эсхүл Парламентын гишүүдийн 1/3-ийн шаардлагаар хууль батлагдсанаас хойш 10 хоногт багтаан хуулийн хэрэгжилтийг хоёр сарын хугацаагаар түдгэлзүүлж болно. Энэ хугацаанд нийт сонгогчдын 10 хувийн гарын үсгийг

цуглуулсан бол олон нийтийн санал асуулга явуулна. Энэхүү 10 хувийн босго нь өндөр босго бөгөөд ялангуяа том нутаг дэвсгэртэй, олон хүн амтай улсын хувьд хоёр сарын хугацаанд гарын үсэг цуглуулах нь өндөр зардалтай, нүсэр зохион байгуулалт шаарддаг тул бараг боломжгүй гэж үздэг. Харин Латви шиг жижиг улсын хувьд санал асуулга нь боломжтой бөгөөд санал асуулгыг 4 удаа (1998, 1999, 2007, 2010 онд) явуулсан.

### *Үндсэн хуулийн шүүхэд хандах эрх*

Зарим улсад парламент дахь цөөнхийн зүгээс тухайн хууль нь Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянуулахаар үндсэн хуулийн шүүхэд хандаж болдог. Тухайлбал, Францын Үндсэн хуулийн дагуу Үндэсний Ассамблей, эсхүл Сенатын 60 гишүүн (мөн Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, эсхүл Парламентын хоёр танхимын дарга нар) тухайн хуулийг хянуулахаар Үндсэн хуулийн шүүхэд хандах эрхтэй. Гэхдээ тухайн хууль батлагдсаны дараа, гэхдээ ёсчлон батлахаас өмнө Үндсэн хуулийн шүүхэд хандах шаардлагатай. Үүнтэй ижил заалтууд нь франц хэлтэй Африкийн улсуудад түгээмэл байдаг. Жишээ нь, Тунисын Үндсэн хуулиар Парламентын 30 гишүүний саналаар тухайн хуулийг баталснаас хойш 30 хоногийн дотор Үндсэн хуулийн шүүхэд хандах боломжтой байдаг.

Ийм зохицуулалт нь тухайн хуульд зөвхөн хориг тавих эрх төдий биш харин үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хянахад чиглэгдсэн эрх зүйн үйл явц юм. Энэ нь цөөнхийн хувьд тухайн хуулийг цуцлуулах нэг арга зам юм. Цөөнх тухайн асуудлаар үндсэн хуулийн шүүхэд хандаад амжилт олохгүй байсан ч энэ үйлдлээрээ олон нийтийн анхаарлыг мөнхүү хуулийн алдаатай, сул талд хандуулж, олон түмний хэлэлцүүлгийн төвд аваачсанаар эрх баригчид асуудлыг эргэн харахаас аргагүйд хүрч болзошгүй билээ.

## **ХОЁР. ПАРЛАМЕНТ ДАХЬ ЦӨӨНХИЙН БҮЛЭГ БУЮУ СӨРӨГ ХҮЧНИЙ ТАЛААРХ ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

### **2.1.Австрали Улс**

Австралийн Холбооны Улс (Австрали Улс) нь Вестминстерийн загварт суурилдаг хоёр танхимт парламенттай, доод танхим болох Төлөөлөгчдийн Танхимын 151 гишүүнийг бүх нийтийн шууд санал хураалтаар<sup>214</sup> 3 жилийн хугацаатай сонгодог, харин дээд танхим болох Сенатын 76 гишүүнийг 6 жилийн хугацаатай<sup>215</sup> сонгодог.

### ***Парламент дахь намын бүлэг***

<sup>214</sup> Australian Constitution. Art. 24. <https://www.apf.gov.au/constitution>

<sup>215</sup> Australian Constitution. Art. 6.

Парламентад суудалтай намууд нь хууль тогтоомжийн төсөл болон улс төрийн ач холбогдолтой асуудлыг хэлэлцэх бүлгүүдийг байгуулан ажилладаг. Тэдгээр бүлгүүд нь тухайн улс төрийн намаас сонгогдсон гишүүдээс бүрддэг ба төрийн бодлого, шийдвэрт нөлөөлөхийг оролддог. Парламент дахь бүх намын бүлэг долоо хоногт нэг удаа буюу танхимын хуралдаангүй өдөр хуралддаг бөгөөд хуралдаан хаалттай явагдах ба түүний явцыг олон нийтэд мэдээлдэггүй. Намын бүлгийн хуралдаан нь намын бодлого, парламентын үйл ажиллагаа, парламентын тактик, намын болон бүлгийн дотоод маргааныг шийдвэрлэх, албан тушаалтныг сонгох, томилох зэрэг асуудлыг дотроо хэлэлцэх, эрх баригчдад шахалт үзүүлэх, шаардлага хүргүүлэх арга хэрэгсэл болдог.

Парламентад олонхын суудал авсан намын бүлгээс дээд, доод танхимын даргыг, хоёр дахь том намын бүлэг буюу сөрөг хүчнээс тэдгээр танхимын дэд даргыг тус тус сонгодог байна.

### ***Цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийн эрх зүйн орчин***

Төлөөлөгчдийн Танхимд суудалтай хоёр дахь том нам, эвслийг сөрөг хүчин (opposition) гэнэ. Сөрөг хүчин нь Төлөөлөгчдийн Танхимын чухал бүрэлдэхүүн хэсэг юм.<sup>216</sup> Сөрөг хүчин нь засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавьж, үйл ажиллагааг нь шүүмжилж, засгийн газрыг огцруулах оролдлого хийдэг учир зарим тохиолдолд “хүлээж буй засгийн газар” (government in waiting) гэж үздэг. Австрали Улсын Парламентын түүхэнд Төлөөлөгчдийн Танхимд 2024 оныг хүртэлх хугацаанд сөрөг хүчний нийт 35 тэргүүн ажиллаж байсны 19 нь Ерөнхий сайдаар ажиллаж байжээ.<sup>217</sup>

Сөрөг хүчний үйл ажиллагааг Үндсэн хуулийн конвенц<sup>218</sup> (Их Британийн Үндсэн хуулиас эхтэй Хамтын Нөхөрлөлийн улсуудын дагаж мөрддөг бичмэл бус уламжлал, зөвлөмж), Төлөөлөгчдийн Танхимын практик<sup>219</sup>, Төлөөлөгчдийн Танхимын хуралдааны дэг<sup>220</sup> болон бусад эрх зүйн актуудаар зохицуулж байна.

Вестминстерийн загвартай улсуудад сөрөг хүчнийг “Сүүдрийн засгийн газар” гэж нэрлэх нь түгээмэл байдаг. Төлөөлөгчдийн Танхимын нэгдсэн хуралдааны танхимд сөрөг хүчний гишүүд засгийн газрын гишүүд (олонхын бүлэг)-ийн эсрэг талд суудаг бөгөөд эрх барьж буй засгийн газар огцорвол өөрсдийн засгийн газрыг байгуулдаг.<sup>221</sup> Төлөөлөгчдийн Танхим болон Сенатад аль алинд нь сөрөг хүчний гишүүд байдаг.

<sup>216</sup> Parliament of Australia. [www.aph.gov.au](http://www.aph.gov.au)

<sup>217</sup> The Politics of Australia. Jaensch, Dean.

<sup>218</sup> Introduction to the Study of the Law of the Constitution. AV Dicey. p 23-24.

<sup>219</sup> House of Representatives Practice (7th edition). [www.aph.gov.au/About\\_Parliament/House\\_of\\_Representatives/Powers\\_practice\\_and\\_procedure/Practice7](http://www.aph.gov.au/About_Parliament/House_of_Representatives/Powers_practice_and_procedure/Practice7)

<sup>220</sup> House of Representatives Standing and Sessional Orders. [www.aph.gov.au/About\\_Parliament/House\\_of\\_Representatives/Powers\\_practice\\_and\\_procedure/House\\_of\\_Representatives\\_Standing\\_and\\_Sessional\\_Orders](http://www.aph.gov.au/About_Parliament/House_of_Representatives/Powers_practice_and_procedure/House_of_Representatives_Standing_and_Sessional_Orders)

<sup>221</sup> <https://peo.gov.au/understand-our-parliament/parliament-and-its-people/opposition>

### Зураг 1. Төлөөлөгчдийн Танхимын суудал хуваарилалт



Эх сурвалж: [peo.gov.au](http://peo.gov.au).

### Сөрөг хүчний тэргүүн ба түүний чиг үүрэг

Төлөөлөгчдийн Танхим дахь сөрөг хүчний тэргүүн (leader of the opposition) нь тус танхимын сөрөг хүчний гишүүдээс сонгогдоно.<sup>222</sup> Сөрөг хүчний тэргүүн бол улс төрийн томоохон лидер бөгөөд хэрэв Засгийн газар огцорвол дараагийн Ерөнхий сайд болох өндөр магадлалтай байдаг. Тэрээр Хамтын Нөхөрлөлийн улсуудын төрийн өндөр албан тушаалтнуудын жагсаалтын 10 дугаарт бичигддэг<sup>223</sup> бөгөөд жирийн гишүүдээс өндөр цалин хөлс авдаг байна.

Сөрөг хүчний тэргүүн нь Төлөөлөгчдийн Танхимын хуралдааны үеэр Ерөнхий, сайд нараас асуулт асуух, үг хэлэх зэргээр парламент дахь сөрөг хүчний үйл ажиллагааг удирдан чиглүүлдэг. Ерөнхий сайд танхимд үг хэлсэл бол сөрөг хүчний тэргүүн нь түүнтэй адил хугацаатай хариу үг хэлдэг.<sup>224</sup>

Сөрөг хүчний тэргүүн нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- парламент дахь сөрөг хүчний гол төлөөлөгчөөр ажиллах;
- Төлөөлөгчдийн Танхимын гишүүдээс сүүдрийн сайд нарыг томилох;
- Сүүдрийн засгийн газрын болон намын бүлгийн хуралдааныг хуралдуулж, төрийн бодлого, хуулийн төслүүдийг санаачлан хэлэлцэх;

<sup>222</sup> <https://peo.gov.au/understand-our-parliament/parliament-and-its-people/people-in-parliament/leader-of-the-opposition>

<sup>223</sup> Commonwealth Table of Precedence. Special Gazette No. S206 of 5 October 1982.

<sup>224</sup> [https://aph.gov.au/About\\_Parliament/House\\_of\\_Representatives/Powers\\_practice\\_and\\_procedure/00\\_-\\_Infosheets/Infosheet\\_19\\_-\\_The\\_House\\_government\\_and\\_opposition](https://aph.gov.au/About_Parliament/House_of_Representatives/Powers_practice_and_procedure/00_-_Infosheets/Infosheet_19_-_The_House_government_and_opposition)



- холбооны сонгуулийн компанит ажлыг удирдан зохион байгуулах;
- урьдчилан мэдэгдэхгүйгээр асуулт асуух;
- Сүүдрийн засгийн газрыг тэргүүлэх зэрэг өргөн хүрээтэй эрх, үүрэгтэй. Сүүдрийн засгийн газар бол сөрөг хүчний бодлого, шийдвэр боловсруулдаг, гаргадаг гол механизм юм.

### **Сөрөг хүчний чиг үүрэг**

Парламент дахь сөрөг хүчний үндсэн үүрэг бол засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих юм. Үүнээс гадна сөрөг хүчин дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

- Засгийн газрыг огцруулах – сөрөг хүчин нь засгийг газрыг огцруулж, өөрсдийн засгийн газрыг байгуулахыг эрмэлздэг;
- хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, сайжруулах санал гаргах;
- улсын төсөв, түүний зарцуулалтад хяналт шалгалт хийх;
- засгийн газрын бодлогын талаар мэдээлэл, тодруулга авах, асуулт, асуулга тавих;
- төрийн захиргааны үйл ажиллагаанд хяналт тавих, шүүмжлэх, үнэлгээ, дүгнэлт өгөх;
- өргөдөл, гомдол шалгах;
- эрх шилжүүлсэн хууль тогтоомжид хяналт шалгалт хийх.

Хэдийгээр Парламентын гишүүн бүр өргөдөл, гомдол барагдуулах, асуулт, асуулга тавих, аль нэг хороонд харьяалагдан ажиллах боловч дээр дурдсан чиг үүргийг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх нь сөрөг хүчнээс ихээхэн хамаардаг. Парламент дахь олонхын бүлгийн гишүүд Парламентын эдгээр үйл ажиллагаанд үр дүнтэй оролцох боломжтой боловч практик дээр гагцхүү сөрөг хүчин энэ үүргийг илүү сайн гүйцэтгэдэг байна.

Төлөөлөгчдийн Танхимаар хэлэлцэх асуудлуудад засгийн газрын буюу Парламент дахь олонхын бүлгийн санаачлан өргөн барьсан хууль тогтоомжийн төслүүд давамгайлж байдаг тул сөрөг хүчин хэлэлцэж буй бүх асуудлаар саналаа илэрхийлэх боломжтой. Төлөөлөгчдийн Танхимын хуралдаанд засгийн газрын болон сөрөг хүчний гишүүдийн мэтгэлцээнд үг хэлэх хугацаа тэнцүү байх бөгөөд дарааллын хувьд ээлжилж үг хэлэх боломжийг олгодог.

Мөн сөрөг хүчин өөрсдийн дэвшүүлсэн асуудлаар болон олон нийтийн анхаарлыг татаж буй сэдвээр Төлөөлөгчдийн танхимын хуралдааны үеэр хэлэлцүүлэг явуулах бүрэн боломжтой байдаг. Сөрөг хүчний гишүүд Төлөөлөгчдийн Танхимын бүх хороонд орж ажиллах бөгөөд саналуудыг нь хорооны тайланд тусгадаг.<sup>225</sup>

<sup>225</sup>[www.aph.gov.au/About\\_Parliament/House\\_of\\_Representatives/Powers\\_practice\\_and\\_procedure/Practice7/HTML/Chapter2/The\\_\(official\)\\_Opposition](http://www.aph.gov.au/About_Parliament/House_of_Representatives/Powers_practice_and_procedure/Practice7/HTML/Chapter2/The_(official)_Opposition)



## Цөөнхийн бүлэг Парламентын хороодод ажиллах

Парламентын хороо нь Парламентын нэрийн өмнөөс тодорхой чиг үүргийг хэрэгжүүлэхээр Парламентын нэг буюу хоёр танхимаас томилогдсон гишүүдийн зохион байгуулалтын бүтэц (хамтарсан хороодын хувьд хоёулаа) бөгөөд Төлөөлөгчдийн Танхимаас Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих нэг механизм болдог.<sup>226</sup>

Хороодын гишүүдийн тоо харилцан адилгүй бөгөөд гол төлөв 8-32 гишүүнтэй байна. Хороод эрх баригч болон сөрөг хүчний гишүүдээс бүрддэг бөгөөд энэ нь Төлөөлөгчдийн Танхим дахь бүх намын бүлгийн гишүүдийн тоотой хамааралтай байдаг ч ерөнхийдөө эрх барих хүчний гишүүд хороо бүрд олонх болдог.

Ихэнх хороодыг эрх баригч хүчний гишүүн даргалж, дэд даргаар нь сөрөг хүчний гишүүн ажилладаг. Хороодод орох гишүүдийг намын бүлэг дотроос сонгож, дараа нь тухайн намын удирдагч нэр дэвшүүлдэг. Үүний дараа хороонд орохоор нэр дэвшсэн гишүүдийг танхимын тогтоолоор албан ёсоор томилдог.<sup>227</sup>

2024 оны байдлаар 45 дахь Төлөөлөгчдийн Танхим 15 хороотой ажиллаж байна.<sup>228</sup> (Хүснэгт 2.)

### Хүснэгт 2. Төлөөлөгчдийн Танхимын хороодын гишүүнчлэл

	Хорооны нэр	Олонхын бүлгийн гишүүн	Цөөнхийн бүлгийн гишүүн	Эвсэлд үл нэгдсэн гишүүн	Нийт гишүүд
1	Эдийн засгийн байнгын хороо	6	3	1	10
2	Хөдөлмөр эрхлэлт, боловсрол, сургалтын байнгын хороо	6	3	1	10
3	Бүс нутгийн хөгжил, дэд бүтэц, тээвэрлэлтийн байнгын хороо	6	3	1	10
4	Гишүүний халдашгүй эрх ба ашиг сонирхлын хороо	6	5	-	11
5	Өргөдлийн байнгын хороо	5	3	-	8
6	Дэг журмын байнгын хороо	4	3	-	7
7	Сонгон шалгаруулах хороо	6	4	1	11
8	Төсөв болон захиргааны асуудал хариуцсан хороо	5	4		9
9	Бусад хороод	5	3	1	9

<sup>226</sup> [www.aph.gov.au/Parliamentary\\_Business/Committees/House](http://www.aph.gov.au/Parliamentary_Business/Committees/House)

<sup>227</sup> [www.aph.gov.au/About\\_Parliament/House\\_of\\_Representatives/Powers\\_practice\\_and\\_procedure/00\\_-\\_Infosheets/Infosheet\\_4\\_-\\_Committees](http://www.aph.gov.au/About_Parliament/House_of_Representatives/Powers_practice_and_procedure/00_-_Infosheets/Infosheet_4_-_Committees)

<sup>228</sup> [www.aph.gov.au/parliamentary\\_business/committees](http://www.aph.gov.au/parliamentary_business/committees)

## 2.2.Герман Улс

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (Герман Улс)-ын Үндсэн хуулийн 20 дугаар зүйлд тус улс нь ардчилсан, холбооны улс бөгөөд төрийн бүх эрх мэдлийг ард түмэн сонгуулийн болон бусад арга замаар бүрдүүлсэн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагуудаар дамжуулан хэрэгжүүлнэ хэмээн заасан байдаг.

Герман Улсын Бундестаг нь холимог тогтолцоог ашиглан гишүүд нь шууд сонгуулиар сонгогддог. Сонгогч бүр тойрогт нэр дэвшигчид өгөх нэг санал болон намд өгөх нэг санал гэсэн 2 санал өгөх эрхтэй. Сонгуулийн мажоритар системийн дагуу сонгуулийн тойрог бүрд анхны санал хураалтаас хамгийн их санал авсан нэр дэвшигчийг сонгогдсон гэж үзнэ. Парламентын үлдсэн суудлыг пропорционал төлөөллөөр хуваарилна. Пропорционал санал хураалтаар 5 хувиас доошгүй санал авсан, эсхүл мажоритар тогтолцооны дагуу гурваас доошгүй парламентын суудал авсан нам пропорционал төлөөллийн тогтолцооны дагуу парламентад суудал авах эрхтэй. Пропорционал төлөөллийн тогтолцооны үр дүнгээр санал авах эрхтэй байвал үүнийг нэмэлт суудал (overhang seats) гэж хадгална. Улс төрийн нөхцөл байдлаас шалтгаалан парламентад сул суудал гарвал дараа нь эрэмбэлэгдсэн тухайн намын нэр дэвшигчээс нөхөн гүйцээнэ.

Герман Улс шиг парламентын засаглалтай ардчилсан улсад засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих, бодлогын талаар мэтгэлцээн өрнүүлэх, Бундестагийн гишүүдийн өргөн барьсан хуулийн төслүүдэд санал өгөх зэрэг нь сөрөг хүчний үндсэн үүрэг болдог уламжлалтай.

Бундестаг дахь намын бүлэгтэй холбоотой харилцааг дараах хуулиудаар зохицуулдаг:

- Үндсэн хууль;
- Улс төрийн намын тухай хууль;
- Бундестагийн хуралдааны дэгийн тухай хууль;
- Бундестагийн хянан шалгах түр хорооны эрх зүйн байдлын тухай хууль.

### ***Бундестаг дахь намын бүлгийн эрх зүйн байдал***

Бундестагийн хуралдааны дэгийн тухай хуулийн 4 дүгээр бүлэгт зааснаар намын бүлэг нь Бундестагийн гишүүдийн хамгийн багадаа 5 хувиас бүрдсэн нэг намын харьяалалтай гишүүдийн холбоо гэж заасан байдаг. Мөн улс төрийн ижил зорилгоороо нэгдмэл, аль ч мужид хоорондоо өрсөлддөггүй намуудын харьяалалтай гишүүд нийлж Бундестагт

хамтарсан нэг намын бүлэг байгуулж болно. Эдгээр нөхцөл болзлыг хангаагүй ч намын бүлэг байгуулах тухай хүсэлтийг гишүүдээс гаргасан бол тус намын бүлгийг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлыг Бундестагийн нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэдэг байна.

Герман Улсын сонгуулийн систем нь аль нэг нам дангаараа засгийн газар байгуулахад хүндрэлтэй байх бөгөөд олон жижиг намууд нийлж олонхыг бүрдүүлэхээс урьдчилан сэргийлсэн “таван хувийн хориг” (five percent hurdle) гэж нэрлэгддэг босготой. Энэ нь Бундестагт 5-аас доош хувийн төлөөлөлтэй нам нь намын бүлэг байгуулах боломжгүй гэсэн үг юм.<sup>229</sup>

Парламентад намын бүлэг байгуулахад:

- намын бүлэг байгуулсан тухай, түүний албан ёсны нэр, намын бүлгийн даргын нэр, намын бүлгийн гишүүдийн нэрс зэргийг Бундестагийн ерөнхийлөгчид бичгээр мэдэгдэнэ;
- намын бүлэгт гишүүдийн зэрэгцээ зочид байж болно. Зочдын тоог намын бүлгийн хэмжээг тодорхойлоход оруулж тооцохгүй боловч харин намын бүлгүүдэд хуваарилагдсан албан тушаалд томилж, сонгоход зочдыг харгалзан үзэж болно;
- намын бүлэг байгуулах эрмэлзэлтэй хэдий ч гишүүдийн тоо хүрэлцэхгүй бол үзэл бодлоороо нэгдэхийг хүссэн Бундестагийн гишүүд хамтран бүлгэм байгуулахыг зөвшөөрч болно;
- намын бүлгүүд дундаа болон нийлж хамтран байгуулсан ажлын хэсгүүд нь уг намын бүлгүүдийн гишүүдийн тоо хэмжээнд болон хуваарилагдах албан тушаалын квотод ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй.<sup>230</sup>

Намын бүлгүүдийн эрэмбэлсэн дарааллыг гишүүдийнх нь тоонд үндэслэн тогтооно. Гишүүдийн тоо нь тэнцүү намын бүлгүүдийн хувьд тэдний дарааллыг Бундестагийн ерөнхийлөгч нэгдсэн чуулганы нэг хуралдаан дээр шодож шийднэ. Гишүүнийх нь суудал эзгүйрсэн ч шинэ гишүүн нөхөн сонгогдох хүртэл хугацаанд тухайн намын бүлгийн гишүүдийн тоог өөрчлөгдөөгүйд тооцно.

Намын бүлгүүдэд хуваарилах албан тушаалын квотын хувьд, Ахмадын зөвлөлийг болон байнгын хороог тус тус бүрдүүлэх, Байнгын хорооны даргыг томилох зэрэг асуудлыг шийдвэрлэхэд намын бүлгийн гишүүдийн тоог харгалзсан квотын харьцааг баримтлан намын бүлгүүдэд эрх хуваарилна. Бундестагийн хүрээнд хийгдэх бусад томилгоо буюу сонгуульд дээрх зарчмыг баримтлан хэрэгжүүлнэ.

<sup>229</sup> <https://www.deutschland.de/en/topic/politics/the-german-parliament-and-the-parties>

<sup>230</sup> Бундестагийн хуралдааны дэгийн тухай хууль. Гадаад орнуудын парламентын хуралдааны дэгийн эмхэтгэл. УИХ-ын Тамгын газар. 2023 он.

***Бундестагийн хуралдааны дэгийн тухай хуульд намын бүлгийн талаар зохицуулсан байдал***

- Бундестагийн ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч нарыг сонгохдоо намын бүлэг тус бүрээс доод тал нь нэг Бундестагийн дэд ерөнхийлөгчийг нэр дэвшүүлж сонгоно;
- хуралдааны тэмдэглэл хөтлөгчдийг сонгохдоо намын бүлэг тус бүрээс ирүүлсэн саналыг үндэслэн сонгоно;
- чуулганаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний хүрээнд хуралдаан даргалагч нь ирц бүрдээгүйн улмаас амжилтгүй болсон санал хураалтыг дахин явуулах товыг зарлах, эсхүл уг асуудлыг хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнөөс хасах эрхтэй. Гэхдээ түүний энэ шийдвэрийг аль нэг намын бүлэг, эсхүл нэгдсэн хуралдаанд оролцож буй гишүүдийн 5 хувиас доошгүй нь эсэргүүцсэн бол хуралдаан даргалагчийн шийдвэр хүчингүй болно;
- Бундестаг нь хуралдааныг хойшлуулах бол зөвхөн хуралдаан даргалагчийн санал болгосны дагуу, эсхүл аль нэг намын бүлгийн хүсэлтийн дагуу, эсхүл хуралдаанд оролцож буй гишүүдийн 5 хувийн хүсэлтийг үндэслэн шийдвэр гаргана;
- Бундестагийн гишүүний өргөн барьсан асуудлаар хэлэлцүүлэг эхэлсэн бол үг хэлэх эхний гишүүн нь төсөл санаачлагчийн намын бүлэгт харьяалагддаггүй гишүүн байна;
- хуралдааны дэгтэй холбоотой горимын санал гаргаж буй гишүүнд хамгийн эхэнд үг хэлэх эрхийг хуралдаан даргалагч олгоно. Горимын саналыг хүлээн зөвшөөрөх шаардлагатай бол зөвхөн санал гаргагч гишүүнд үг хэлэх эрх олгоно. Дэгтэй холбоотой өөр горимын санал гарсан бол намын бүлгүүд тус бүрээс нэг төлөөлөгчид үг хэлэх зөвшөөрөл олгож хязгаарлалт хийнэ;
- хэлэлцүүлэгт үг хэлэх хугацааг Ахмадын зөвлөлийн саналыг үндэслэн Бундестаг тогтоох бөгөөд гишүүд 15 минутаас илүүгүй хугацаанд үг хэлнэ. Харин намын бүлгийн шаардсанаар тус намын бүлгийг төлөөлсөн илтгэгч 45 минут хүртэл хугацаагаар үг хэлж болно;
- Засгийн газрын гишүүн, Холбооны Зөвлөлийн гишүүн, эсхүл эдгээр байгууллагын төлөөлөгч 20 минутаас илүү хугацаагаар үг хэлж байвал өөр байр суурьтай байгаа намын бүлэг өөрийнхөө илтгэгчид ижил хугацааны үг хэлэх эрхийг шаардаж болно;
- хэлэлцүүлгийн явцад Засгийн газрын гишүүн, эсхүл Холбооны Зөвлөлийн гишүүн, эсхүл тэдгээрийн төлөөлөгч уг асуудал дээр үг хэлэх зөвшөөрөл авч дахин үг хэлсэн бол байр сууриа илэрхийлж дууссан намын бүлгүүдэд үг хэлэх нэмэлт цаг олгоно;
- Засгийн газрын гишүүн, эсхүл Холбооны Зөвлөлийн гишүүн, тэдний төлөөлөгч хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнөөс гадуур

- үг хэлбэл аль нэг намыг бүлэг болон хуралдаанд оролцож буй гишүүдийн 5 хувь нь шаардсанаар хэлэлцүүлэг явуулна. Энэ хэлэлцүүлгийн үед шийдвэрийн төсөл хэлэлцэхгүй;
- санал хураахаас өмнө аль нэг намын бүлэг, эсхүл хуралдаанд оролцож буй гишүүдийн 5 хувь нь нэрсийн жагсаалтаар санал хураахыг шаардаж болно;
  - Бундестагийн хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулсан баримт бичгийг Бундестагийн гишүүн өргөн барьсан тохиолдолд түүний энэ санаачилгыг нэг намын бүлэг дэмжсэн, эсхүл Бундестагийн гишүүдийн 5 хувь нь гарын үсэг зурж дэмжсэн байх ёстой;
  - өргөдөл саналыг нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхгүйгээр Байнгын хороонд шилжүүлж болно. Нэг намын бүлэг, эсхүл хуралдаанд ирсэн Бундестагийн гишүүдийн 5 хувь нь эсэргүүцээгүй тохиолдолд өргөдөл, саналыг урьдчилан тараахгүйгээр шууд санал хурааж шийдвэрлэж болно;
  - Ахмадын зөвлөл урьдчилан тохирсон бол зарим асуудлын хэлэлцүүлгийн оронд хэлэх үгийг бичгээр авч хуралдааны протоколд тэмдэглүүлж хавсаргана. Ийм горимыг тохирсон бол хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд тухайн асуудлыг бусдаас ялгагдахаар бичнэ. Өмнөх өдрийн 18:00 цагаас өмнө намын бүлэг, эсхүл нийт гишүүдийн 5 хувь нь хэлэлцүүлэг хийхийг шаардвал хэлэлцүүлгийг заавал хийнэ. Хэлэлцүүлгийн хүрээнд намын бүлэг бүрд нэг удаа үг хэлэх боломж олгох бөгөөд хэлэлцүүлгийг 30 минут үргэлжлэхээр тооцож энэ хугацаанд намын бүлгийн гишүүдийн тоог харгалзан хуваарилна;
  - Европын Холбооны тодорхой баримт бичгийг Бундестагт ирүүлэх үүргээс Засгийн газрыг чөлөөлж болно. Аль нэг намын бүлэг, эсхүл Бундестагийн гишүүдийн 5 хувь нь үүнийг дэмжээгүй бол тодорхой баримт бичгийг Бундестагт ирүүлэх Засгийн газрын үүрэг хүчинтэй хэвээр үлдэнэ;
  - Европын Холбооны баримт бичиг болон Европын Холбооны Парламентын тогтоол шийдвэрийг зарчмын хувьд Байнгын хороонд шилжүүлнэ. Шилжүүлэх шийдвэрийг боловсруулахдаа намын бүлгүүдтэй зөвшилцөж, ач холбогдлыг нь үнэлнэ. Байнгын хороонд шилжүүлэх шаардлагагүй, Европын Холбооны бусад баримт бичгийн хувьд Бундестагийн гишүүдэд танилцах боломжийг бүрдүүлнэ. Аль нэг намын бүлэг, эсхүл Бундестагийн гишүүдийн 5 хувийн хүсэлтээр Европын Холбооны бусад баримт бичгийг Байнгын хороонд шилжүүлж болно;
  - Европын Холбооны баримт бичгүүдийг шилжүүлэх саналыг Бундестагийн ерөнхийлөгчид хүргүүлнэ. Бундестагийн ерөнхийлөгч намын бүлгүүдтэй зөвшилцөн Асуудлыг голлон хариуцах Байнгын хороонд болон хамтрагч Байнгын хороонд даруй шилжүүлнэ. Шилжүүлсэн, эсхүл шилжүүлэхээр

- төлөвлөснийг аль нэг Байнгын хороо, эсхүл намын бүлэг эсэргүүцсэн бол Ахмадын зөвлөл үүнийг шийдвэрлэнэ;
- Холбооны канцлерт итгэл үзүүлэхээс татгалзах тухай тогтоол батлахдаа Бундестагийн гишүүдийн дөрөвний нэг, эсхүл хамгийн багадаа Бундестагийн гишүүдийн дөрөвний нэгтэй тэнцэх тооны гишүүнтэй намын бүлэг санал гаргана;
  - Бундестагийн ерөнхийлөгч Засгийн газарт тавьсан асуулгыг Засгийн газарт мэдэгдэж, хариу өгөх эсэх хариуны товыг тодорхойлохыг шаардана. Хариу ирүүлсний дараа асуулгыг хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулна. Аль нэг намын бүлэг, эсхүл Бундестагийн гишүүдийн 5 хувь шаардсан бол хэлэлцүүлэг явуулна;
  - Засгийн газар асуулгад хариу өгөхөөс бүрмөсөн, эсхүл ойрын 3 долоо хоногийн хугацаанд татгалзсан бол Бундестаг асуулгыг хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулж болно. Нэг намын бүлэг, эсхүл Бундестагийн гишүүдийн 5 хувь шаардсан бол хэлэлцүүлгийг заавал явуулна;
  - аль нэг намын бүлэг, эсхүл Бундестагийн гишүүдийн 5 хувь нь чуулганы хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулахыг шаардаагүй тохиолдолд Бундестагийн Зэвсэгт хүчний асуудал эрхэлсэн илтгэгчийн тайлан мэдээллийг Бундестагийн ерөнхийлөгч Батлан хамгаалахын байнгын хороонд шилжүүлнэ;
  - аль нэг намын бүлэг, эсхүл хуралдаанд оролцож буй гишүүдийн 5 хувь шаардсан бол Бундестагийн Зэвсэгт хүчний асуудал эрхэлсэн илтгэгчид түүний тайлан илтгэлийг хэлэлцэх үед Бундестагийн ерөнхийлөгч түүнд үг хэлэх эрх олгоно;
  - мөн аль нэг намын бүлэг, эсхүл хуралдаанд оролцож буй гишүүдийн 5 хувь шаардсан бол Бундестагийн хуралдаанд Бундестагийн Зэвсэгт хүчний асуудал эрхэлсэн илтгэгчийг дуудаж оролцуулна.

### ***Намын бүлэг байнгын болон бусад хороодод ажиллах***

- ажлаа бэлтгэхийн тулд аливаа Байнгын хороо өөрсдийн гишүүдийн дундаас нэг дэд хороог тодорхой үүрэг даалгавартайгаар байгуулж болно. Чингэхдээ Байнгын хорооны гишүүдийн 1/3 нь татгалзвал дэд хороог байгуулахгүй. Онцгой тохиолдолд намын бүлгүүд нь тухайн Байнгын хорооны гишүүн бус хүнийг дэд хорооны гишүүнээр томилж болно;
- байнгын хороонд төлөөлөлтэй намын бүлэг бүр нь дэд хороонд доод тал нь 1 гишүүнээ оруулах эрхтэй;
- намын бүлгүүд байнгын хороодод орох өөрийн гишүүдийг болон тэдний орлогч нарыг томилно. Бундестагийн ерөнхийлөгч намын бүлгийн харьяалалгүй гишүүдийг Байнгын хороодод зөвлөх эрхтэй гишүүнээр томилно;



- байнгын хорооны гишүүдийн ажлыг дэмжих зорилгоор намын бүлэг бүрээс намын бүлгийн 1 ажилтан байнгын хорооны хуралдаанд байлцах эрхтэй;
- бусад хууль тогтоомжоор хязгаарлалт тогтоогоогүй бол намын бүлгийн дарга нар бүх байнгын хороодын болон бусад хороодын хуралдаанд зөвлөх эрхтэйгээр оролцож болно. Бүлгийн дарга өөрийн намын бүлгийн гишүүнийг өөрийн өмнөөс хуралдаанд оролцуулж болно;
- байнгын хорооны хуралдааны хэлэлцүүлгийг дуусгах талаар горимын санал гаргасан бол намын бүлгийн төлөөлөл бүр байр сууриа илэрхийлсний дараа, намын бүлгүүдийн байр сууринаас зөрүүтэй саналууд яригдсаны дараа л санал хураалт явуулахыг зөвшөөрнө;
- нэг намын бүлэг, эсхүл Бундестагийн гишүүдийн 5 хувь нь санал гаргаж чуулганы хуралдаанд оролцож буй гишүүдийн 2/3 нь энэ саналыг дэмжсэн бол хуулийн төслийг Байнгын хороонд шилжүүлэхгүйгээр шууд 2 дахь хэлэлцүүлэгт оруулж болно;
- төсөл санаачлагч нь эсэргүүцээгүй тохиолдолд л Бундестагийн шийдвэрийн төслийн талаар гаргасан саналыг нь Байнгын хороо руу шилжүүлж болно. Намын бүлэг, эсхүл хуралдаанд оролцож буй Бундестагийн гишүүдийн 5 хувь нь хүсэлт гаргасан бол санал хураалтыг хуралдааны дараагийн өдөр хүртэл хойшлуулна;
- намын бүлэг, эсхүл Бундестагийн гишүүдийн 5 хувь нь санал гаргасан бол Холбооны Зөвлөлийн зөвшөөрөл шаардах хуулиудын хувьд Зуучлах хороо байгуулах тухай тогтоолыг Бундестаг гаргаж болно;
- Европын Холбооны асуудал хариуцсан байнгын хорооноос Засгийн газарт Европын Холбооны баримт бичгийн талаар илэрхийлсэн байр суурийн агуулга, үндэслэлийн талаар Байнгын хороо санал, дүгнэлт бэлтгэж, түүнийг Бундестагийн хэвлэмэл материал хэлбэрээр тараасны дараа гурван долоо хоногийн дотор хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулна. Гэхдээ энэ асуудлын хэлэлцүүлгийг зөвхөн аль нэг намын бүлэг, эсхүл хуралдаанд оролцож буй гишүүдийн 5 хувь нь хүсэлт гаргасан тохиолдолд л явуулна;
- Европын Холбооны асуудал хариуцсан байнгын хорооны хуралдаанд Европын парламентын тодорхой герман гишүүд оролцох эрхтэй; Европын парламентын бусад герман гишүүд орлогчийн хувьд Байнгын хорооны хуралдаанд оролцох эрхтэй. Хамтран ажиллах эрхтэй Европын парламентын гишүүдийг Бундестаг дахь намын бүлгүүдийн саналаар Бундестагийн ерөнхийлөгч томилно;
- байнгын хорооны дарга аль нэг намын бүлгийн шаардлага, эсхүл байнгын хорооны гишүүдийн 1/3-ийн хүсэлтийн дагуу болон



Бундестагийн ерөнхийлөгчийн зөвшөөрлөөр байнгын хорооны ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулна;

- Өргөдлийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Бундестагт тараасны дараа чуулганы хуралдаанаар шийдвэрлүүлэхээр 3 долоо хоногийн дотор хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд оруулж, Байнгын хорооны илтгэгч нь амаар нэмэлт оруулах боломжтой. Аль нэг намын бүлэг, эсхүл хуралд оролцож буй гишүүдийн 5 хувь нь шаардсан тохиолдолд л өргөдлийн талаар чуулган дээр хэлэлцүүлэг явуулна.

### ***Бундестагийн хянан шалгах түр хорооны эрх зүйн байдлын тухай хуульд намын бүлгийн талаарх зохицуулалт***

Парламент хууль баталж, баталсан хуулиудыг Засгийн газар хэрэгжүүлж шүүх маргаантай асуудлуудыг шийдвэрлэнэ. Хэдийгээр эрх мэдлийг ардчилсан байдлаар хуваарилсан байсан ч хяналтгүй бол тухайн эрх мэдлийг хэтрүүлэн хэрэглэх, буруугаар ашиглах, дарангуйлал тогтох магадлалтай байдаг байна. Иймд хянан шалгах түр хороо нь эрх мэдлийн хуваарилалтыг хангаж байдаг парламентын хяналтын үр өгөөжтэй арга хэрэгсэл юм.

Хянан шалгах түр хорооны бүрэлдэхүүнийг парламентын олонх, цөөнхийн буюу хүчний харьцааны дагуу тогтооно. Парламентын хянан шалгах түр хороо байгуулах тухай хууль ба эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн заалтуудаар хянан шалгах түр хорооны ажиллах дэгийг тогтоодог байна.

Герман Улсын Үндсэн хуулийн 44 дүгээр зүйлд Бундестагийн гишүүдийн 1/4-ийн санаачилгаар хянан шалгах түр хороо байгуулж болно гэсэн заалт байдаг бөгөөд энэхүү заалтаар Бундестагийн гишүүдийн цөөнхийн санаачилгаар хянан шалгах түр хороог байгуулах баталгааг хангасан юм. Ингэснээр Парламентаас байгуулдаг хянан шалгах түр хороо нь Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих сөрөг хүчний эрх мэдлийг нэмэгдүүлж байдаг. Хянан шалгах түр хороо нь олон нийтэд нээлттэй болон хаалттай хуралдаануудаар нотлох баримтуудыг авч хэлэлцэж салбарын шинжээчид болон гэрчүүдийн үгийг сонсдог. Үүгээрээ хянан шалгах түр хорооны ажиллах дэг нь шүүхтэй төстэй байдаг.

Бундестагийн хянан шалгах түр хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар Бундестаг түр хороог байгуулахдаа түүний жинхэнэ болон ижил тооны орлогч гишүүдийн тоог тогтооно. Гишүүдийн тоо тогтоохдоо Бундестаг дахь олонх, цөөнхийн харьцааны зэрэгцээ тавигдсан үүрэг, даалгавар болон хянан шалгах хорооны ажлын чадамжийг харгалзан үзнэ. Түр хороонд намуудын бүлэг бүрийн

төлөөллийг оролцуулна. Намын бүлэг бүрд ногдох гишүүдийн тоог математик пропорцын зарчмаар (St. Lague/Schepers) тогтооно.

Мөн хуулийн 5 дугаар зүйлд түр хорооны жинхэнэ болон орлогч гишүүдийг намын бүлгүүд томилох ба эгүүлэн татна. Түр хорооны даргыг сонгохдоо намын бүлгүүдийн гишүүдийн тоог харгалзан үзнэ.

Хянан шалгах түр хороо нь Ахмадын зөвлөл дэх зөвшилцөөний дагуу түр хорооны нэг гишүүнийг орлогч даргаар томилох бөгөөд орлогч дарга нь тухайн түр хорооны даргаас өөр намын бүлгийн харьяалалтай байх ёстой.<sup>231</sup>

Хянан шалгах түр хороо намын бүлгүүдийн тодорхой ажилтнуудад хуралдаанд оролцох зөвшөөрөл олгож болно.<sup>232</sup>

### 2.3.Нидерланд Улс

Нидерландын Хаант Улс (Нидерланд Улс)-ын Парламент (Staten-Generaal) нь хоёр танхимтай: дээд танхим буюу Сенат (Eerste Kamer) 75 гишүүнтэй, доод танхим буюу Төлөөлөгчдийн Танхим (Tweede Kamer) 150 гишүүнтэй. Сенатын гишүүдийг мужийн зөвлөлийн гишүүдээс 4 жилийн хугацаагаар, сонгуулийн пропорционал тогтолцоогоор сонгодог бол Төлөөлөгчдийн Танхимын гишүүдийг бүх ард түмнээс сонгуулийн пропорционал тогтолцоогоор шууд сонгодог.

Нидерланд Улсад Засгийн газрын танхимд ороогүй намуудыг сөрөг хүчин гэж үздэг.<sup>233</sup> Одоогийн байдлаар Парламент дахь намын бүлэг, сөрөг хүчний эрх зүйн байдлыг тогтоосон, үйл ажиллагааг зохицуулсан тусгайлсан хууль байхгүй. Парламент дахь бүлгүүдийн үйл ажиллагааг Төлөөлөгчдийн Танхимын дэгээр зохицуулдаг.

#### ***Парламент дахь бүлгийн эрх зүйн байдал***

Пропорционал сонгуулийн намын нэг жагсаалтаас сонгогдсон гишүүдийг Парламент дахь нэг бүлэг гэж үзнэ. Жагсаалтаас нэг гишүүн сонгогдсон байсан ч тухайн гишүүнийг дангаараа Парламент дахь бүлэг гэж тооцдог. Парламент дахь бүлгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон тохиолдолд тухайн Парламент дахь бүлэг нь Парламентын Ерөнхийлөгчид мэдэгдэнэ. Парламент дахь бүлэг бүр гүйцэтгэх хорооныхоо бүрэлдэхүүний талаар Парламентын Ерөнхийлөгчид мэдэгдэнэ.

<sup>231</sup> Бундестагийн хянан шалгах түр хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйл.

<sup>232</sup> Бундестагийн хянан шалгах түр хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйл

<sup>233</sup> <https://www.houseofrepresentatives.nl/how-parliament-works/democracy-netherlands/coalition-vs-opposition>

Сөрөг хүчний намууд ихэвчлэн парламентын хороодод төлөөлөлтэй байдаг бөгөөд энэ нь хууль тогтоомж, Засгийн газрын бодлогын хэрэгжилтэд хяналт шалгалт хийхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Ингэснээрээ намын бүлгүүд хууль тогтоох үйл явцад хувь нэмрээ оруулж, Засгийн газарт хариуцлага тооцох, хяналт тавих боломжийг сөрөг хүчинд олгодог. Парламентын холбогдох хороодын сөрөг хүчний гишүүд Парламентын чуулганы хуралдааны үеэр Засгийн газрын сайд нарт асуулт, асуулга тавьж, тэдгээрийн хийсэн үйлдэл, шийдвэрийнх нь төлөө хариуцлага тооцохыг шаардах эрхтэй. Нидерланд Улсад Засгийн газарт итгэл үзүүлэх эсэх асуудлыг оруулах босго нь 150 гишүүний 30 нь байдаг.

Парламент дахь бүлгүүдийн зарим онцлог зохицуулалтын талаар Төлөөлөгчдийн Танхимын дэгээс тодруулбал:

- Парламент дахь бүлэгт санхүү хуваарилах, санхүүгийн хяналт тавих журмыг танхим батална.
- Парламент дахь бүлэг хуваагдаж, нэг буюу хэд хэдэн шинэ бүлэг байгуулсан тохиолдолд Парламент дахь анхны бүлгийн төсвийг хуваагдалд оролцсон бүх улс төрийн бүлэгт гишүүдийн тоотой хувь тэнцүүлэн хуваарилна.
- Хоёр ба түүнээс дээш улс төрийн бүлэг нэгдэж Парламент дахь шинэ бүлэг байгуулсан бол шинээр байгуулагдах Парламент дахь бүлгийн төсөв нь ижил тооны гишүүдтэй Парламент дахь бүлгийн төсвөөс хэтэрч болохгүй.
- Парламент дахь анхны бүлгийн ажилтнуудын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийн тулд Парламентын Ерөнхийлөгчийн ажлын алба нь энэ зүйлийн 1, 2 дахь хэсгийг үл харгалзан түр хугацааны зохицуулалт хийж болно.
- Парламент дахь бүлгийн дарга нар нь Тагнуул, Аюулгүй байдлын хорооны гишүүд болно.
- Төсвийн хорооны хэлэлцүүлгийн төгсгөлд Парламентын чуулганы нэгдсэн хуралдаанд улс төрийн бүлэг тус бүрээр үг хэлэх дээд хугацааг Парламент тогтооно.
- Парламент дахь бүлэг тус бүрийн үг хэлэх дээд хугацаа хоёр минут байх бөгөөд энэ хугацаанд санал гаргах ёстой.
- Чуулганы хуралдааны танхимд гишүүн бүрд суудал хуваарилна. Мөн Парламентын Ерөнхийлөгчийн ажлын алба нь Парламент дахь бүлэг тус бүрд тодорхой бүлэг суудал хуваарилна.
- Парламент нь Парламент дахь бүлгийн тодорхой сэдвийн талаар үг хэлэх дээд хугацааг болон сайд нарын үг хэлэх дээд хугацааг хязгаарлаж болно. Мөн хэлэлцүүлгийг зөвхөн нэг үе шаттайгаар явуулахаар шийдвэрлэж болно.
- Асуулт, асуулгын үеэр асуугч этгээдийн яриаг таслахыг хориглоно. Мөн Парламент дахь нэг бүлгийн гишүүд хоёроос илүүгүй асуулт асуух эрхтэй.

**Төлөөлөгчдийн Танхимын одоогийн бүрэлдэхүүн**

Нидерланд Улсын Төлөөлөгчдийн Танхим нь 100 суудалтай байсан бөгөөд 1956 онд энэ тоо 150 болж нэмэгдсэн нь өнөөг хүртэл хэвээр байна.

Өнөөгийн Хамтарсан Засгийн газар нь түр Засгийн газар бөгөөд Эрх чөлөө, ардчиллын төлөөх ардын нам [Volkspartij voor Vrijheid en Democratie] (24 суудал), Христийн ардчилсан холбоо [Christen-Democratisch Appil] (5 суудал), Ардчилсан 66 [Democraten 66] (9 суудал), Христийн нэгдэл [ChristenUnie] (3 суудал) намуудын хоорондын хэлэлцээрийн үр дүнд 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр үүсгэн байгуулагдсан.

Төлөөлөгчдийн Танхим дахь сөрөг хүчин нь: Эрх чөлөөний төлөө нам [Partij voor de Vrijheid] (37 суудал), Хороон зүүн-Хөдөлмөрийн нам [GroenLinks–PvdA] (25 суудал), Нийгмийн шинэ гэрээ [Nieuw Sociaal Contract] (20 суудал), Тариаланч иргэдийн хөдөлгөөн [BoerBurgerBeweging] (7 суудал), Социалист нам [Socialistische Partij] (5 суудал), ДЕНК [DENK] (3 суудал), Амьтдын төлөө нам [Partij voor de Dieren] (3 суудал), Ардчиллын төлөөх форум [Forum voor Democratie] (3 суудал), Калвинист улс төрийн нам [Staatkundig Gereformeerde Partij] (3 суудал), Вольт [Volt Nederland] (2 суудал), Зөв хариулт 2021 [Juiste Antwoord 2021] (1 суудал) байна.

2023 оны Нидерланд Улсын бүх нийтийн сонгуульд Эрх чөлөөний төлөө нам ялалт байгуулсан. Эрх чөлөөний төлөө нам нь бусад гурван намтай (либерал-консерватив Эрх чөлөө, ардчиллын төлөөх ардын нам, тариаланчдын эрхийн төлөө Тариаланч иргэдийн хөдөлгөөн, баруун-төвийн үзэл баримтлалтай Нийгмийн шинэ гэрээ) хамтарч олонхын Засгийн газар байгуулахаар хэлэлцээр хийж байна.

Гэсэн ч Эрх чөлөөний төлөө намаас Лалын сүм хийд, Исламын сургууль, Коран судрыг хориглох тухай хуулийн төслийг санал болгохоор төлөвлөж байсан тул хэлэлцээр тасалдсан. Үүнээс гадна Нийгмийн шинэ гэрээ намын дарга Питер Омцигт мэдэгдэл хийхдээ Засгийн газрын санхүүгийн байдалд цочирдсон бөгөөд одоогоор хэлэлцээрийг түр зогсоохоор төлөвлөж байна гэж мэдэгджээ. Тэрээр Эрх чөлөөний төлөө намын дарга болох Вилдерсийн хэлэлцээрийг хянахаар сонгосон Хөдөлмөрийн намын Засгийн газрын сайд асан Рональд Пластеркийг хоёр долоо хоногийн өмнө хүлээн авсан санхүүгийн мэдээллийг энэ долоо хоногт л нийтэлсэн гэж шүүмжилжээ.

2024 оны 03-р сарын байдлаар Эрх чөлөөний төлөө намын дарга Хиэрт Вилдерс өөрийгөө Ерөнхий сайд болох боломжгүй гэдгээ хүлээн зөвшөөрсний дараа эвслийн хэлэлцээр нь илүү тодорхой зорилготой болсон. Хэлэлцээрт оролцож буй дөрвөн нам нь голчлон технократ

Засгийн газар байгуулах зорилготой байна. Намуудын хооронд үүссэн санал зөрөлдөөнтэй холбоотойгоор Эрх чөлөөний төлөө нам тэргүүтэй Парламентад олонх болсон эвсэл, эсхүл Парламентын дэмжлэгтэйгээр үйл ажиллагаа явуулах цөөнхийн Засгийн газар байгуулах боломжгүй гэсэн дүгнэлтийг эвслийн хэлэлцээрт оролцож буй зуучлагчийн зүгээс гаргасан юм.

## 2.4.Өмнөд Солонгос Улс

Бүгд Найрамдах Солонгос Улс (Өмнөд Солонгос Улс) нь ерөнхийлөгчийн засаглалтай, төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс юм. Улс төрийн түүхийн үүднээс 1948 оноос өнөөг хүртэл нийт 6 удаа Бүгд найрамдах улс тунхагласан гэж үздэг. 1948 оны 07 дугаар сарын 17-ны өдөр анхдугаар Үндсэн хуулиа баталсан бөгөөд түүнээс хойш 5 удаа шинэчлэн найруулсан.

Үндсэн хуульд Үндэсний Ассамблейн “...гишүүдийн тоог хуулиар тогтоох бөгөөд 200-аас доошгүй байна.” гэж заасан<sup>234</sup> боловч Үндэсний Ассамблейн 2020 оны сонгуулиар байгуулагдсан өнөөгийн парламент 300 гишүүнтэй. Бүрэн эрхийн хугацаа нь 4 жил байдаг.<sup>235</sup> Үндэсний Ассамблейг холимог сонгуулийн тогтолцоогоор бүрдүүлдэг. 253 гишүүнийг нэг мандаттай тойргуудаас мажоритар аргаар, үлдэх 47 гишүүнийг пропорционал тогтолцоогоор тус тус сонгодог. Эдүгээ улс төрийн долоон нам Үндэсний Ассамблейд суудалтай байна.

### Хүснэгт 3. Үндэсний Ассамблейн түүхэн товчоон<sup>236</sup>

Бүгд найрамдах улс	Улс төрийн дэглэм	Засаглалийн хэлбэр	Үндэсний Ассамблей	Хугацаа
Нэгдүгээр	Авторитар	Ерөнхийлөгчийн	I-IV	1948-1960
Хоёрдугаар	Ардчилсан	Парламентын	V	1960-1961
Гуравдугаар	Авторитар	Ерөнхийлөгчийн	VI-VIII	1963-1972
Дөрөвдүгээр	Авторитар	Ерөнхийлөгчийн	IX-X	1973-1980
Тавдугаар	Авторитар	Ерөнхийлөгчийн	XI-XII	1981-1988
Зургадугаар	Ардчилсан	Ерөнхийлөгчийн	XIII-XVI	1988-

Үндэсний Ассамблей дахь намын бүлэгтэй холбоотой харилцааг дараах хуулиудаар зохицуулна:

- Үндсэн хууль (Constitution, 1987);
- Үндэсний Ассамблейн тухай хууль (National Assembly Act, 2012);
- Улс төрийн намын тухай хууль (Political Parties Act, 2022).

<sup>234</sup> Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг.

<sup>235</sup> Үндсэн хуулийн 42 дугаар зүйл

<sup>236</sup> [https://s-space.snu.ac.kr/bitstream/10371/70195/1/kjps\\_15\\_1\\_25-42.pdf](https://s-space.snu.ac.kr/bitstream/10371/70195/1/kjps_15_1_25-42.pdf)

### **Бүлгийн эрх зүйн байдал**

Үндэсний Ассамблейн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “Үндэсний Ассамблейд 20-оос дээш гишүүнтэй улс төрийн нам бүлэг (negotiating party) байгуулна.” Мөн аль нэг бүлэгт харьяалалгүй 20 болон түүнээс дээш тооны гишүүд нэгдэн нийлж тусдаа бүлэг байгуулж болдог. Тухайн бүлгийг төлөөлөх этгээд нь бүлгийн нийт гишүүдийн гарын үсэг зурж, тамга дарсан бүртгэлийн хуудсыг Үндэсний Ассамблейн даргад өргөн барьснаар бүлэг албан ёсоор байгуулагдсанд тооцогдоно. Бүлгийн харьяалах гишүүд, эсхүл намд өөрчлөлт орсон тохиолдолд тэр тухайгаа Үндэсний Ассамблейн даргад нэн даруй мэдэгдэх ёстой. Ямар нэгэн бүлэгт харьяалагддаггүй гишүүн намын харьяалалд орох, эсхүл намын харьяаллаа өөрчлөх бол мөн энэ тухайгаа нэн даруй Үндэсний Ассамблейн даргад мэдэгддэг.<sup>237</sup>

Нам, эвслийн бүлэг (бүлэг)-ийн зохион байгуулалтын үндсэн зорилго<sup>238</sup> нь улс төрийн нам, эвсэл, тэдгээрийн бүлгийн гишүүдийн дунд үр дүнтэй яриа хэлэлцээ хийх, мэдээлэл шуурхай түгээх, дамжуулах болон солилцох нээлттэй суваг бий болгох явдал юм. Ингэснээрээ улс төрийн нам, эвслийн бүлгийн гишүүдийн зүгээс хэлэлцэх асуудлын талаар урьдчилан мэдээлэл цуглуулах, тухайн асуудлыг шийдвэрлэх, боловсронгуй болгох санал, дүгнэлт боловсруулах, гаргах боломжийг хангаж парламентын хууль тогтоох үйл ажиллагааг улам хөнгөвчилж, илүү үр дүнтэй болгоход чиглэгддэг.

Бүлгийн нийт гишүүдийн тооны харьцаа нь чуулганы нэгдсэн хуралдаанд үг хэлэх хүний тоог тогтоох, байнгын хороо, тусгай хорооны гишүүдийн тоог тодорхойлох, тэдгээрийг томилоход гол чухал үндэслэл болдог.

Үндэсний Ассамблей дахь бүлэг бүр өөрийн төлөөлөх этгээд (Representative Member)-ээ сонгох бөгөөд тухайн сонгогдсон гишүүн нь улс төрийн намын дарга буюу, эсхүл улс төрийн намын төлөөлөгчөөс ялгаатай юм. Бүлэг төлөөлөх этгээд нь шууд Төрийн байгуулалт (House Steering Committee)-ын болон Тагнуул (Intelligence Committee)-ын хорооны гишүүн болдог.

Бүлгийн гишүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор бүлэг тус бүр өөрийн бодлого, судалгааны асуудал хариуцсан ажилтныг томилон ажиллуулдаг. Бодлого, судалгааны асуудал хариуцсан ажилтныг Бүлэг төлөөлөх этгээдийн санал болгосноор Үндэсний Ассамблейн дарга томилж, чөлөөлнө. Бодлого, судалгааны асуудал хариуцсан ажилтан нь төрийн албаны тусгай албан хаагч байх бөгөөд ажилтны тоо, түүнд тавигдах шаардлага, зэрэг дэв, томилох, чөлөөлөх зэрэг харилцааг Үндэсний Ассамблейн дүрмээр зохицуулдаг байна.

<sup>237</sup> Үндэсний Ассамблейн тухай хуулийн 33 дугаар зүйл

<sup>238</sup> <https://korea.assembly.go.kr:447/portalEn/main/contents.do?menuNo=1500025>



**Чуулганы хуралдаантай холбоотой бүлэгт хамаарах зохицуулалт**

- Үндэсний Ассамблейн гишүүдийн хуралдааны танхимд суух суудлын хуваарийг Үндэсний Ассамблейн дарга, бүлэг төлөөлөх этгээдүүдтэй зөвлөлдөж тогтооно. Нэгдсэн саналд хүрээгүй тохиолдолд суудлын хуваарийг Үндэсний Ассамблейн дарга тогтооно;
- Үндэсний Ассамблейн дарга Үндэсний Ассамблей дахь бүлгийн төлөөлөх этгээдүүдтэй зөвлөлдөж жилийн ажлын үндсэн төлөвлөгөөг (үүнд төрийн захиргааны хяналт шалгалтыг багтаана) жил бүрийн 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор батална;
- нэгдсэн хуралдааныг үдээс хойш 14 цагт нээдэг (Бямба гаригийн үдээс өмнө 10 цагт) боловч гагцхүү Үндэсний Ассамблейн дарга, бүлэг төлөөлөх этгээдүүдтэй зөвлөлдсөний үндсэн дээр хуралдааныг нээх цагийг өөрчилж болдог;
- нэгдсэн хуралдааныг олон нийтэд нээлттэй явуулдаг. Гагцхүү Үндэсний Ассамблейн даргын санал болгосноор, эсхүл 10 болон түүнээс дээш гишүүд гарын үсэг зурж, горимын санал гаргаснаар, эсхүл Үндэсний Ассамблейн дарга үндэсний аюулгүй байдлын үүднээс шаардлагатай гэж үзэн бүлэг төлөөлөх этгээдүүдтэй зөвлөлдсөнөөр нэгдсэн хуралдааныг хаалттай явуулж болдог;
- 20 ба түүнээс дээш тооны гишүүд гарын үсэг зурж горимын санал гаргаснаар, эсхүл Үндэсний Ассамблейн дарга шаардлагатай гэж үзэн бүлэг төлөөлөх этгээдүүдтэй зөвлөлдсөн тохиолдолд Үндэсний Ассамблейн дарга ээлжит чуулганы товыг хэсэгчилж өөрчлөх, эсхүл тухайн өдрийн нэгдсэн хуралдааны товд хэлэлцэх асуудлыг нэмж оруулах болон дараалал өөрчилж болно;
- нэн яаралтай горимоор асуудал шийдвэрлэх болсон үед Үндэсний Ассамблейн дарга бүлэг төлөөлөх этгээдүүдтэй зөвшилцсөн тохиолдолд хуульд заасан зарим зохицуулалтыг дагаж мөрдөхгүй байж болно;
- Төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэхэд жил бүрийн 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор төсвийн болон бусад дагалдах хуулийн төсөлд байнгын хороо бүр санал, дүгнэлтээ гаргасан байх ёстой бөгөөд энэ хугацаанд санал, дүгнэлтээ гаргаагүй бол гаргасанд тооцож тухайн хуулийн төслүүдийг дараах өдөр нэгдсэн хуралдаанд шилжүүлдэг зохицуулалттай боловч Үндэсний Ассамблейн дарга бүлэг төлөөлөх этгээдүүдтэй зөвшилцсөн тохиолдолд энэхүү заалтыг үйлчлэхгүй байхаар тогтож болдог байна;



**Бүлэг үг хэлэх, асуулт, асуулга тавихтай холбоотой зохицуулалт**

- Үндэсний Ассамблейн дарга бүлэг төлөөлөх этгээдүүдтэй зөвлөлдөж тухайн хэлэлцэх асуудлаар үг хэлэх нийт хугацааг бүлэг бүрийн гишүүний тоонд хуваан тогтоож хуваарилна. Энэ тохиолдолд бүлэг төлөөлөх этгээд нь ногдсон цагт үг хэлэх гишүүдийн тоо болон бүлгийн үг хэлэх гишүүдийн хугацааг тогтоож Үндэсний Ассамблейн дарга урьдчилж мэдэгдэнэ. Нэгдсэн хуралдаан нээгдмэгц Үндэсний Ассамблейн дарга 1 цагаас илүүгүй хугацаагаар гишүүдэд Үндэсний Ассамблейн хэлэлцэж буй хуулийн төсөл, санал хүсэлт зэрэг бусад Үндэсний Ассамблейд хамаарах асуудлаар 5 минут хүртэл хугацаанд үг хэлэх зөвшөөрөл олгож болно. 5 минут чөлөөтэй үг хэлэхийг хүссэн гишүүн хуралдаан эхлэхээс багадаа 4 цагийн өмнө үг хэлэх саналаа хэлэх үгийн товч агуулгын хамтаар Үндэсний Ассамблейн даргад танилцуулж бүртгүүлнэ. 5 минутын чөлөөтэй үг хэлэх гишүүний тоо, дарааллыг бүлэг бүрийн гишүүний тооны харьцааг харгалзан үзэж Үндэсний Ассамблейн дарга бүлэг төлөөлөх этгээдүүдтэй зөвлөлдөж тогтооно;
- хэлэлцэх асуудлын жагсаалтад орсон асуудлаар Үндэсний Ассамблейн гишүүн эсрэг, эсхүл дэмжиж буй байр сууриа илэрхийлж мэтгэлцэх хүсэлтээ Үндэсний Ассамблейн даргад урьдчилан мэдэгдэнэ. Үндэсний Ассамблейн дарга энэ мэдэгдлийг хүлээж авсан дараалал болон тухайн байр сууриа илэрхийлэх гишүүний харьяалагдаж буй бүлгийг харгалзан үзэж эсрэг байр суурьтай болон дэмжиж байгаа гишүүнийг ээлжлэн үг хэлүүлэх ба хамгийн багадаа нэг эсрэг байр суурьтай гишүүний үгийг сонсоно;
- санал хураалт явуулахдаа Үндэсний Ассамблейн дарга бүлэг төлөөлөх этгээдүүдтэй зөвшилцсөн тохиолдолд нээлттэй, эсхүл нууц санал хураалтыг цахим төхөөрөмжийг ашиглан явуулж болно;
- хуралдааны тэмдэглэлийг гишүүд болон олон нийтэд тараана. Үндэсний Ассамблейн дарга нууцад хамаарах, эсхүл үндэсний аюулгүй байдалд холбогдолтой гэж үзсэн хэсгийн тухайд үг хэлсэн гишүүн, эсхүл түүний харьяалах намын бүлгийг төлөөлөх этгээдтэй зөвлөлдөж тухайн хэсгийг нийтлэхгүй байж болно;
- нэгдсэн хуралдааны тогтоолоор Ерөнхий сайд, Засгийн газрын төлөөлөгч, эсхүл Засгийн газрын гишүүнийг хуралдаанд оролцуулах тухай хүсэлтийг гаргаж болно. Энэ тохиолдолд тухайн хүсэлтийг 20-оос доошгүй гишүүн бичгээр гаргана. Хүсэлтийг хүлээн авсан Ерөнхий сайд, эсхүл Засгийн газрын гишүүн Үндэсний Ассамблейн даргын, эсхүл хорооны даргын зөвшөөрлийг авсан тохиолдолд Ерөнхий сайдын өмнөөс Засгийн

газрын гишүүн, Засгийн газрын гишүүний өмнөөс Засгийн газрын төлөөлөгчийг оролцуулж асуултад хариулж болно. Энэ тохиолдолд Үндэсний Ассамблейн дарга бүлэг төлөөлөх этгээдүүдтэй, эсхүл хорооны дарга нь гүйцэтгэх нарийн бичигтэй тус тус зөвлөлдөнө;

- Засгийн газарт асуулга тавихад асуулгын сэдэв бүрд асуулт тавих гишүүдийн тоог Үндэсний Ассамблейн дарга бүлэг төлөөлөх этгээдүүдтэй зөвлөлдсөний дараа тогтооно. Үндэсний Ассамблейн дарга асуулт тавих гишүүдийн тоог бүлгийн гишүүдийн тоо, хувь хэмжээний дагуу хуваарилна. Бүлэгт харьяалагдаагүй гишүүдийн асуулт тавих гишүүний тоог Үндэсний Ассамблейн дарга бүлгийн төлөөлөгч гишүүдтэй зөвлөлдөж тогтооно.

### ***Бүлэг хороодод ажиллахтай холбоотой зохицуулалт***

- бүлэг төлөөлөх этгээдүүд нь Үндэсний Ассамблейн Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүн байна;
- Төсөв, данс тооцооны тусгай хороо нь 50 гишүүнтэй байна. Тус хорооны гишүүдийг бүлэг болон байнгын хорооны гишүүний тооны харьцааг харгалзан үзэж бүлэг тус бүрийг төлөөлөх этгээдийн хүсэлтийг үндэслэн Үндэсний Ассамблейн дарга томилно;
- Ёс зүйн хяналтын зөвлөх хороо нь хорооны даргыг оролцуулан 8 зөвлөхтэй байх ба зөвлөхүүдийг хорооны дарга бүлэг тус бүрийг төлөөлөх этгээдийн санал болгосноор томилно. Бүлэг тус бүрийг төлөөлөх гишүүдийн санал болгох зөвлөхийн тоо нь тухайн бүлгийн гишүүний тооны харьцаанаас хамаарна. Энэ тохиолдолд хамгийн олон гишүүнтэй бүлгийг төлөөлөх этгээдийн санал болгосон Зөвлөх хорооны гишүүний тоо нь бусад бүлгийг төлөөлөх гишүүний санал болгосон Зөвлөх хорооны гишүүний тоотой адил байх ёстой;
- Үндэсний Ассамблейн дарга бүлэг төлөөлөх этгээдүүдтэй зөвшилцсөнөөр өргөн мэдүүлсэн сонгуулийн тухай хууль тогтоомжийн төсөл зэргийг хянан үзэх зорилгоор Сонсголын тусгай хороо байгуулж болно. Ерөнхийлөгчөөр сонгогдсон этгээд Ерөнхий сайдад нэр дэвшигчийн талаар сонсгол явуулах хүсэлт гаргасан тохиолдолд Үндэсний Ассамблейн дарга Үндэсний Ассамблей дахь бүлэг тус бүрийг төлөөлөх этгээдүүдтэй зөвшилцөн Сонсголын тусгай хороогоор сонсгол явуулна;
- Тагнуулын байнгын хорооны гишүүнийг бүлэг төлөөлөх этгээдүүдээс санал болгосон нэр дэвшигч дундаас Үндэсний Ассамблейн дэд дарга болон бүлэг төлөөлөх этгээдүүдтэй зөвшилцсөнөөр Үндэсний Ассамблейн дарга томилж, чөлөөлнө;

- хороодын гишүүний томилгоог хийсний дараа бүлгийн гишүүний тоонд өөрчлөлт орсон тохиолдолд Үндэсний Ассамблейн дарга бүлэг бүрд ногдох тоог өөрчилж хорооны гишүүдийг дахин томилж болно;
- бүлэг бүр Хорооны гүйцэтгэх нарийн бичгийн даргыг томилно;
- нэгдсэн хуралдааны шийдвэр гарсан, эсхүл Үндэсний Ассамблейн дарга бүлэг төлөөлөх этгээдүүдтэй зөвшилцөж шаардлагатай гэж үзсэнээс бусад тохиолдолд хороог нэгдсэн хуралдааны үеэр хуралдуулдаггүй;
- хороод нь бүртгэлтэй гишүүдийн гуравны нэгээс дээш гишүүдийн хүсэлтээр хэлэлцэх асуудлын дараалалтай холбоотойгоор хэлэлцэх асуудлын дарааллыг зохицуулах зорилгоор хэлэлцэх асуудлын жагсаалтыг зохицуулах хороог байгуулж болно. Зохицуулах хороо нь зохицуулах хорооны даргыг оролцуулан нийт 6 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Зохицуулах хороог бүрдүүлэхдээ Үндэсний Ассамблей дахь бүлгийн тооны харьцааг үндэслэнэ.
- Үндэсний Ассамблейн дарга бүлэг төлөөлөх этгээдүүдтэй зөвшилцсөн хороонд хариуцуулсан асуудлаар хорооны санал, дүгнэлт гаргах хугацааг тогтоож болно.

*Хүснэгт 4. Үндэсний Ассамблейд суудалтай намууд,  
тэдгээрийн бүлэг<sup>239</sup>*

	<b>Нам, эвслийн бүлэг</b>		<b>Тойргоос сонгогдсон гишүүд</b>	<b>Намын жагсаалтаар сонгогдсон гишүүд</b>	<b>Тоо</b>	<b>Хувь</b>
1	Олонх	Солонгосын Ардчилсан нам (Democratic Party of Korea)	147	16	163	54.8
2	Цөөнх	Ард түмний хүч нам (People Power Party)	90	23	113	38.5
3	Бүлэггүй	Ногоон шударга ёс нам (Green Justice Party)	1	5	6	2.02
4		Шинэчлэлийн нам (Reform Party)	3	1	4	1.35
5		Жинбо нам (Jinbo Party)	1	0	1	0.34
6		Шинэ ирээдүй нам (New Future Party)	1	0	1	0.34
7		Шинэ дэвшилт холбоо (New Progressive Party)	0	1	1	0.34
8		Бие даагч	7	1	8	2.7

<sup>239</sup> <https://korea.assembly.go.kr:447/portalEn/main/contents.do?menuNo=1500025>

## 2.5.Финланд Улс

### Эрх зүйн орчин

Бүгд Найрамдах Финланд Улс (Финланд Улс) нь парламентын засаглалтай Бүгд найрамдах улс юм. Тус улсын Парламент (Eduskunta) нь нэг танхимтай, 4 жилээр сонгогддог 200 гишүүнтэй. Парламентын 199 гишүүнийг олон мандат бүхий 12 тойргоос сонгуулийн пропорционал тогтолцоогоор, үлдсэн нэг гишүүнийг Аланд автономит бүсийн нэг мандаттай тойргоос сонгодог.<sup>240</sup>

Гишүүд нь Парламентад суудалтай улс төрийн намынхаа харьяаллын дагуу бүлэгт хуваагддаг ба одоогийн Парламентад намын 9 бүлэг байна.<sup>241</sup>

Бүлгийн үйл ажиллагааг зохицуулдаг гол эрх зүйн баримт бичгүүдэд:

- Үндсэн хууль (Constitution<sup>242</sup>);
- Парламентын тухай хууль (Parliament Act of 1928<sup>243</sup>);
- Парламентын дэг (Parliament's rules of procedure<sup>244</sup>) хамаардаг.

Парламентын бүлгүүд нь Парламент шинээр байгуулагдсан үеэс эхлэн идэвхтэй ажиллаж ирсэн ч 2000 онд Үндсэн хуулиар тэдний үйл ажиллагааг хуульчилж хүлээн зөвшөөрчээ.<sup>245</sup>

Парламентын дэгийн 51 дүгээр зүйлд зааснаар тухайн Парламентын бүрэн эрхийн хугацаанд Парламент дахь бүлэг хамгийн багадаа 3 гишүүнтэй байгуулагдана.<sup>246</sup> Гишүүн бүр бүлэгт заавал орох үүрэг байхгүй ч ихэнх гишүүд өөрийн намын бүлэгт харьяалагддаг.

Парламентын бүлэг нь дарга, дэд даргатай байх бөгөөд бүлгийн дарга нь бүлгийнхээ байр суурийг илэрхийлэх, бусад бүлэгтэй харилцан зөвшилцөж, хамтран ажиллах явдал юм. Парламентын дарга, дэд дарга санал, санаачилга гаргасан бүлгийн байр суурийг Парламентын бусад бүлгүүдэд танилцуулах, тэдэнтэй зөвшилцөх үүрэгтэй.

Бүлэг нь практик дээр Парламентын үйл ажиллагаанд гол үүрэг гүйцэтгэдэг. Тухайлбал, Парламентаар хэлэлцэгдэж буй цаг үеийн аливаа асуудлыг гишүүд бүлгийн хуралдаанаараа хэлэлцэж, тухайн асуудалд бүлэг ямар байр суурь баримтлахаа шийддэг.

<sup>240</sup> Гадаад орнуудын парламентын хуралдааны дэгийн эмхэтгэл. УИХ-ын Тамгын газар. 2023 он.

<sup>241</sup> <https://www.eduskunta.fi/EN/kansanedustajat/eduskuntaryhm%c3%a4t/Pages/default.aspx>

<sup>242</sup> The Constitution of Finland. [https://www.finlex.fi/en/laki/kaannokset/1999/en19990731\\_20180817.pdf](https://www.finlex.fi/en/laki/kaannokset/1999/en19990731_20180817.pdf)

<sup>243</sup> Parliament Act of 1928. <https://www.refworld.org/legal/legislation/natlegbod/1928/en/95894>

<sup>244</sup> Parliament's rules of procedure [https://www.eduskunta.fi/EN/naineduskuntatoimii/Documents/RulesofProcedure\\_20150416.pdf](https://www.eduskunta.fi/EN/naineduskuntatoimii/Documents/RulesofProcedure_20150416.pdf)

<sup>245</sup> Stronger position for the parliamentary groups

<https://www.eduskunta.fi/EN/kansanedustajat/eduskuntaryhm%c3%a4t/Pages/default.aspx>

<sup>246</sup> БНФУ-ын Парламентын хуралдааны дэг (Гарын авлага). “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх”. УБ., 2019 он.

Бүлэг ихэвчлэн Пүрэв гарагт хуралдах бөгөөд хэлэлцэгдэж буй асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол санал хураалт явуулж болно. Гэсэн хэдий ч аливаа бүлэг зөвшилцөлд хүрэхийг хичээдэг.

### ***Үндсэн хууль дахь Парламентын бүлгийн талаарх зохицуулалт***

Финланд Улсын Үндсэн хуульд Парламентын бүлгүүдийн оролцоо, эрх, үүргийн талаар хэрхэн заасан тухай үзвэл:

- Парламентын ээлжит бус сонгууль (огцруулах)-ийн тухай. Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайдын үндэслэл бүхий саналын дагуу, *парламентын бүлгүүдийн саналыг сонссоны дараа* Чуулганы хуралдааны үеэр ээлжит бус сонгууль явуулах тухай зарлиг гаргаж болно. (Үндсэн хуулийн 26 дугаар зүйл);
- *хориос доошгүй гишүүнтэй бүлэг* Засгийн газар, сайдуудын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газар, сайдуудад асуулт, асуулга гаргаж болно. Санал асуулгын хариуг Засгийн газарт хүргүүлсэн өдрөөс хойш арван тав хоногийн дотор Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ. Санал асуулгыг хэлэлцсэний эцэст Засгийн газар, сайдад итгэл үзүүлэхгүй байх тухай санал гаргасан тохиолдолд парламентаас итгэл үзүүлэх эсэх асуудлыг авч хэлэлцэнэ. (Үндсэн хуулийн 43 дугаар зүйл);
- Ерөнхий сайдыг томилох тухай. Ерөнхий сайдыг Парламентаас сонгож, Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч томилно. Ерөнхий сайдын гаргасан саналын дагуу Ерөнхийлөгч бусад сайдуудыг томилно. Парламентаас Ерөнхий сайдыг сонгохоос өмнө *парламентын бүлгүүд* Засгийн газрын хөтөлбөр, бүтэц, бүрэлдэхүүний асуудлаар хэлэлцдэг. Ерөнхийлөгч эдгээр хэлэлцээрийн үр дүн, парламентын дарга болон *бүлгүүдийн саналыг сонссоны дараа* Ерөнхий сайдад нэр дэвшүүлж буй хүнийг Парламентад танилцуулна. Парламент нээлттэй санал хураалт явуулж, нийт гишүүдийн талаас илүү хувь нь дэмжсэн тохиолдолд нэр дэвшигч Ерөнхий сайдаар сонгогдоно. (Үндсэн хуулийн 61 дүгээр зүйл).

### ***Үг хэлэхтэй холбоотой парламентын бүлгийн зохицуулалт***

Парламентын дэгийн 51 дүгээр зүйлд Парламентын бүлгийн үг хэлэх асуудлыг дараах байдлаар зохицуулжээ<sup>247</sup>:

- 1) Парламентын даргын зөвлөл өөрөөр шийдээгүй бол улсын төсөв, Засгийн газрын мэдэгдэл, тайлан, асуулгыг хэлэлцэх үед үг хэлэх зөвшөөрөл бүлэгт өгнө. Хэлэлцэж буй бусад асуудлаар

<sup>247</sup> Гадаад орнуудын парламентын хуралдааны дэгийн эмхэтгэл. УИХ-ын Тамгын газар. 2023 он.

- бүлэгт үг хэлэх зөвшөөрөл өгөх шийдвэрийг Парламентын даргын зөвлөл гаргана. Бүлэгт үг хэлэх зөвшөөрөл өгөхөд энэ дэгийн 50(2,3) дугаар зүйл<sup>248</sup> үйлчилнэ;
- 2) бүлгийн үг хэлэх дараалал нь сонгуулийн дараа бүрдсэн парламентын бүлгийн хэмжээтэй уялдах бөгөөд хамгийн олон төлөөлөгчтэйгээс хамгийн цөөн төлөөлөгчтэй бүлэг гэсэн дарааллаар явагдана. Төлөөлөгчдийн тоо тэнцүү бүлгүүдийн үг хэлэх дарааллыг шодсоны үндсэн дээр Парламентын даргын зөвлөл тогтооно;
  - 3) Парламентын бүрэн эрхийн хугацаанд Парламентын бүлэг хамгийн багадаа гурван төлөөлөгчтэйгээр байгуулагдсан, эсхүл дарааллыг өөрчлөх бодитой шалтгаан байгаа тохиолдолд Парламентын даргын зөвлөл бүлгийн үг хэлэх дарааллыг өөрчилж болно;
  - 4) чуулган хуралдаж дуусахаас өмнө 2 дахь хэсэгт хамаарах бүлгүүд үг хэлсний дараа дахин үг хэлэх хүсэлт гаргавал Парламентын даргын зөвлөл шийдвэрлэнэ;
  - 5) Парламентын даргын зөвлөл дээр дурдсаныг хэрэгжүүлэхтэй холбоотой нарийвчилсан удирдамж гаргаж болно.

### ***Хороодтой холбоотой бүлгийн зохицуулалт***

Парламент нь 17 байнгын хороотой, тэдгээрийн нэг нь Европын Холбооны асуудал хариуцсан байнгын хороо юм. Парламентын гишүүн хоёр байнгын хороонд харьяалагдаж болно. Байнгын хороод 17 гишүүн, 9 орон тооны бус гишүүнтэй, Үндсэн хороо 25 гишүүн, 13 орон тооны бус гишүүнтэй байна.

Хорооны гишүүдийг 4 жилийн хугацаатай томилно. Хорооны бүрэлдэхүүнд Парламентын бүлгүүдийн тооны харьцааг тусгасан байх ёстой бөгөөд бүлгүүд нь гишүүдээ томилдог.

Хорооны хуралдаан нь гишүүдийн 2/3-оос доошгүй нь хүрэлцэн ирсэн тохиолдолд хуралдааны ирц бүрдсэн гэж үзнэ.<sup>249</sup>

### ***Хорооноос гаргасан баримт бичигтэй танилцах бүлгийн эрх***

Аливаа асуудлыг хэлэлцэх бэлтгэлтэй холбоотой баримт бичгийг тухайн асуудал Хороогоор шийдвэрлэгдсэний дараа нийтэд нээлттэй болгоно.

<sup>248</sup> 50.2.Төлөөлөгчдөд үг хэлэх зөвшөөрөл өгөхөөс өмнө Хороог төлөөлж үг хэлэх төлөөлөгчид, парламентын саналын талаар танилцуулах хэлэлцүүлэг явуулах үед саналын эхэнд гарын үсэг зурсан төлөөлөгчид, парламентаас томилогдсон байгууллагын тайланг тавих даргад, эсхүл тухайн байгууллагаас томилогдсон төлөөлөгчид үг хэлэх зөвшөөрөл өгнө. Спикер Хорооны дүгнэлтийг танилцуулах төлөөлөгчид зөвшөөрөл өгч болох бөгөөд шаардлагатай тохиолдолд бусад танилцуулга дууссаны дараа зарчмын зөрүүтэй саналын эхэнд гарын үсэг зурсан төлөөлөгчид үг хэлэх зөвшөөрөл өгч болно. Асуулгын хариуг өгсний дараа асуулгын эхэнд гарын үсэг зурсан төлөөлөгчид үг хэлэх зөвшөөрөл өгнө. (10/2016)

50.3.Спикер төлөөлөгчдөд хүсэлт гаргасан дарааллын дагуу үг хэлэх зөвшөөрөл өгөхөөс өмнө сайд, Засгийн газрын хууль зүйн канцлер, парламентын омбудсменд үг хэлэх зөвшөөрөл өгч болно.

<sup>249</sup> Eduskunta Riksdagen page. <https://www.eduskunta.fi/EN/valiokunnat/Pages/default.aspx>

Хэрэв нууцын зэрэглэлтэй биш бол Хороонд болон Хорооны ажлын хэсэгт төлөөлөлгүй парламентын бүлэг шийдвэрлэгдэж буй асуудалтай холбоотой баримт бичгийн хуулбарыг авах эрхтэй байна. (Парламентын дэгийн 43а.1 дүгээр зүйл).

Үндсэн хуулийн 50.3 дугаар зүйлд заасны дагуу Хороо баримт бичгийг нууцын зэрэглэлтэй гэж зарласан бол баримт бичгийг нууцална.

## 2.6.Франц Улс

Бүгд Найрамдах Франц Улс (Франц Улс) нь хагас ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглалтай, төрийн байгууламжийн хувьд нэгдмэл улс юм. Үндсэн хуулиа 1958 оны 10 дугаар сарын 04-ний өдөр бүх нийтийн санал асуулгаар баталсан бөгөөд Тав дахь Үндсэн хууль гэж нэрлэдэг. Түүнээс хойш Үндсэн хуульд 24 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Франц Улсын Парламент нь дээд танхим болох Сенат, доод танхим болох Үндэсний Ассамблей гэсэн хоёр танхимтай. Сенат нь 348 гишүүнтэй, тус улсын орон нутгийн зөвлөлийн гишүүд болон гадаадад амьдарч буй Франц иргэдийн төлөөллөөс бүрдэнэ. Бүрэн эрхийн хугацаа 6 жил байх бөгөөд гишүүдийн тал хувь нь 3 жил тутамд шинэчлэн сонгогддог. Сенатын хувьд хууль тогтоох эрх мэдэл нь хязгаарлагдмал байна.

Үндэсний Ассамблей нь 577 гишүүнтэй. Бүрэн эрхийн хугацаа 5 жил байх бөгөөд бүх нийтийн шууд, нууц санал хураалтаар сонгогддог. Нэг мандаттай тойргийн зарчмаар санал хураалтын хоёр шаттай мажоритар системээр сонгодог. Одоогийн Үндэсний Ассамблей 16 дахь хууль тогтоох байгууллага бөгөөд Парламентын 10 бүлэгтэй, аль ч бүлэгт хамаарахгүй, гишүүдийг нэгтгэсэн 1 бүлэгтэй бөгөөд 5 бүлэг нь сөрөг хүчин болдог.<sup>250</sup>

### Хүснэгт 5. Нам, эвслийн бүлгүүдийн гишүүнчлэл

	Нам, эвслийн бүлэг	Тойргоос сонгогдсон гишүүд	Холбогдох гишүүд	Нийт
1	Сэргэн мандалтын бүлэг (Renaissance)	159	10	169
2	Үндэсний цуглааны бүлэг (Rassemblement National)	88	0	88
3	Шинэ экологи, нийгмийн бүлэг (La France insoumise - Nouvelle Union Populaire écologique et sociale)	74	1	75
4	Бүгд Найрамдахчуудын бүлэг (Les Républicains)	58	4	62

<sup>250</sup> Les groupes politiques actuels. <https://www.assemblee-nationale.fr/dyn/les-groupes-politiques>



5	Ардчилсан хөдөлгөөний бүлэг (Démocrate (MoDem et Indépendants))	50	0	50
6	Социалист нам (Socialistes et apparentés)	27	4	31
7	Horizons бүлэг (Horizons et apparentés)	29	1	30
8	Экологичид бүлэг (Écologiste – NUPES)	22	0	22
9	Ардчилсан БН зүүн (Gauche démocrate et républicaine – NUPES)	22	0	22
10	Хилийн чанад дахь бие даасан иргэд, эрх чөлөө (Libertés, Indépendants, Outre-mer et Territoires)	22	0	22
	<b>Бүлгийн нийт гишүүд</b>	<b>551</b>	<b>20</b>	<b>571</b>
	Бүртгэлгүй гишүүд (Non inscrit)	6	0	6
	<b>Нийт суудал дүүрсэн</b>	<b>557</b>		<b>577</b>
	Дүүрээгүй суудал	0		0
	<b>Нийт суудал</b>			<b>577</b>

Эх сурвалж: Үндэсний Ассамблейн цахим хуудас  
[https://www2.assemblee-nationale.fr/instances/liste/groupes\\_politiques/effectif](https://www2.assemblee-nationale.fr/instances/liste/groupes_politiques/effectif)

### Хууль, эрх зүйн орчин

Үндэсний Ассамблей дахь намын бүлэгтэй холбоотой харилцааг Үндсэн хууль<sup>251</sup>, Үндэсний Ассамблейн хуралдааны дэгийн тухай хуулиар зохицуулж байна.

Үндсэн хуульд 2008 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр “Танхим бүрийн хуралдааны дэгээр тэдгээрийн дотор байгуулагдсан Парламентын бүлгүүдийн эрхийг тодорхойлно. Тухайн танхим дахь сөрөг хүчний болон цөөнхийн бүлгүүдийн онцгой эрхийг хүлээн зөвшөөрнө.”<sup>252</sup> хэмээн Парламент дахь сөрөг хүчний (opposition groups) болон цөөнхийн бүлгүүд (minority groups) албан ёсны статусыг баталгаажуулан хуульчилсан.

Үндэсний Ассамблейн сөрөг хүчин болон цөөнхийн бүлгүүд нь Үндсэн хуулиар эрх зүйн хувьд баталгаажсан институт юм. Үндсэн хуулийн 48 дугаар зүйлд “Сард нэг удаа Парламент дахь сөрөг хүчний болон цөөнхийн бүлгүүдийн санаачилсан хэлэлцэх асуудлаар чуулган хуралдана.” гэж заасан байна.

Түүнчлэн Үндсэн хуулийн 51.1 дэх зүйлд зааснаар Үндэсний Ассамблейн сөрөг хүчин болон цөөнхийн бүлгүүд нь Парламентын бүлгүүдийн эрхийг тодорхойлж, давуу байдал, тусгай эрх олгохыг зөвшөөрдөг байна.

<sup>251</sup> Constitution of October 4, 1958. <https://www2.assemblee-nationale.fr/langues/welcome-to-the-english-website-of-the-french-national-assembly#chap5>

<sup>252</sup> Constitution of October 4, 1958, Art.51-1.

### **Бүлгийн эрх зүйн байдал**

Үндэсний Ассамблей дахь сөрөг хүчний эрх зүйн байдал нь олон намын тогтолцоотой болон үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, сөрөг хүчний эрх чөлөөг хангахыг зохицуулсан байна.

Үндэсний Ассамблейн хуралдааны дэгийн тухай хуульд Парламентын олонхын бүлгээс бусад бүлгүүдийн албан ёсны статусыг Парламент дахь сөрөг хүчний (*opposition groups*) болон цөөнхийн бүлгүүд (*minority groups*) гэж ялгаж заагласан байна.

Үндэсний Ассамблейн хуралдааны дэгийн тухай хуулийн 5 дугаар бүлгийн 19.1-т Парламентын бүлэг байгуулах тухай тусгасан байна. Үүнд:

- гишүүд өөрсдийн улс төрийн адил төстэй байдлыг харгалзан бүлэг байгуулж болно. Бүлэг байгуулахад хамгийн багадаа 15 гишүүнтэй байна<sup>253</sup>;
- бүлэг нь харьяалагдах гишүүдийн гарын үсэгтэй мэдэгдэл, холбогдох гишүүдийн нэрсийн жагсаалт, бүлгийн даргын нэрийг хавсаргасан улс төрийн мэдэгдлийг Үндэсний Ассамблейн ерөнхийлөгчид уламжилснаар бүлэг байгуулсанд тооцно. Энэ мэдэгдэлд бүлгээ “сөрөг хүчин” гэж тодорхойлж, албан ёсны сэтгүүлд нийтэлнэ;
- хамгийн олон гишүүнтэй бүлгээс бусад нь өөрсдийгөө “сөрөг хүчин” гэж зарлаагүй бүлгийг **цөөнхийн бүлэг** гэж үзнэ. Цөөнхийн болон сөрөг хүчний бүлгүүдийн статус ижил боловч сөрөг хүчинд парламентын хяналтыг хэрэгжүүлэхэд оролцох эрх нь илүү олгогдсон байна;
- Үндэсний Ассамблейн хуралдааны дэгийн тухай хуулийн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн сөрөг хүчний болон цөөнхийн бүлгүүдэд хамаарах тодорхой бүрэн эрхийг Үндэсний Ассамблейн анхдугаар чуулганы эхэнд, дараа нь жил бүрийн ээлжит чуулганы эхэнд тодорхойлно;
- Үндэсний Ассамблейн гишүүн зөвхөн нэг бүлэгт харьяалагдана;
- аль нэг бүлэгт харьяалалгүй гишүүн өөрсдийн сонгосон бүлэгт тухайн бүлгийн зөвшөөрлөөр орж болно.

Бүлэг байгуулагдсаны дараа Үндэсний Ассамблейн ерөнхийлөгч нь бүлгүүдтэй тохиролцож, бүлгүүдийн гишүүдийн болон бүлэгт ороогүй гишүүдийн чуулганы нэгдсэн хуралдааны танхим дахь суух суудлыг хуваарилна.

<sup>253</sup> БНФУ-ын Үндэсний Ассамблейн хуралдааны дэг (Гарын авлага). “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх”. УБ. 2019 он.

Бүлгийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсон бол Үндэсний Ассамблейн ерөнхийлөгчид бичгээр мэдэгдэх бөгөөд мөн энэ талаар албан ёсны сэтгүүлд нийтэлнэ.

Бүлгийн **хориглох зүйлийг** Үндэсний Ассамблейн хуралдааны дэгийн тухай хуулийн 23 дугаар зүйлд тусгасан. Үүнд:

- Үндэсний Ассамблейд хуралдааны дэгийн 19 дүгээр зүйлд заасан, эсхүл бусад хэлбэрээр хувийн, орон нутгийн, эсхүл албан тушаалын ашиг сонирхлыг илэрхийлэх зорилгоор өөрсдийн гишүүдийг захирамжлах, эрхийг хааж боогдуулах ямар ч бүлгийг байгуулахгүй;
- дээрх ашиг сонирхлыг илэрхийлэх зорилготой ямар ч төрлийн байнгын бүлэг ордонд хуралдахыг хориглоно.

Үндэсний Ассамблейн хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлд заасны дагуу байгуулагдсан бүлэг нь өөрсдийн томилсон ажлын алба, хэрэг эрхлэх газартай байж болно.

### ***Чуулганы хуралдаантай холбоотой бүлгийн зохицуулалт***

Үндэсний Ассамблейн хуралдааны дэгийн тухай хуулийн 47 дугаар зүйлд Үндэсний Ассамблейн ерөнхийлөгчийн зөвлөл (цаашид “Ерөнхийлөгчийн зөвлөл”)-тэй холбоотой асуудалд **бүлэгтэй холбоотой зохицуулалтыг** тусгажээ:

- Ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүнд Үндэсний Ассамблейн ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, байнгын хорооны дарга, Санхүү эдийн засаг, төсвийн хяналтын хорооны ерөнхий дарга, Европын ажил хэрэг эрхэлсэн хорооны дарга, бүлгийн дарга нараас бүрдэнэ;
- Ерөнхийлөгчийн зөвлөл нь шаардлагатай бол 7 хоног тутам хуралдах бөгөөд товыг Үндэсний Ассамблейн ерөнхийлөгч тогтооно. Тэрээр мөн Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 45 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу бүлгийн даргын хүсэлтээр Ерөнхийлөгчийн зөвлөлийг зарлан хуралдуулж болно;
- Ерөнхийлөгчийн зөвлөлийн хуралд гишүүдээс гаргасан саналаар санал хураалт явуулах бөгөөд санал хураалтад тус зөвлөлийн бусад гишүүдийн саналыг хассаны дараа бүлгийн дарга нарт тухайн бүлгийн гишүүдийн тоотой тэнцэх хэмжээний саналын эрх олгоно;
- Түр хороодын дарга нарыг 80 дугаар зүйлд заасны дагуу хүсэлт гаргасан тохиолдолд Ерөнхийлөгчийн зөвлөлд урьж болно;

- Сөрөг хүчний болон цөөнхийн бүлгүүдийн дарга нар Үндсэн хуулийн 48 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу долоо хоногийн хэлэлцэх асуудлын жагсаалтыг гаргаж, Ерөнхийлөгчийн зөвлөл хуралдахын өмнөх өдөр танилцуулна. Хурлыг ээлжит чуулган бүрийн эхэнд сөрөг хүчний бүлэг, цөөнхийн бүлгүүдийн тооны харьцааг харгалзсан бүрэлдэхүүнтэй хуралдуулна. Бүлэг тус бүр ээлжит чуулганы хугацаанд 3-аас доошгүй удаа хуралдана;
- Батлагдсан хэлэлцэх асуудлын жагсаалтыг Засгийн газар, бүлгүүдийн болон хороодын дарга нарт хүргүүлнэ. Үндэсний Ассамблейн ерөнхийлөгч нь зөвлөлийн хурлын дараа Засгийн газраас Үндэсний Ассамблейд оруулсан асуудлаас бусад саналыг Үндэсний Ассамблейд өргөн мэдүүлнэ. Үндэсний Ассамблей саналыг бүхэлд нь шийдвэрлэнэ. Тус хуралдаанд зөвхөн Засгийн газрын төлөөлөл илтгэл тавьж болох бөгөөд хуралд оролцож буй хороодын дарга нар, эсхүл Ерөнхийлөгчийн зөвлөлд оролцсон төлөөлөгчид саналын талаар 2 минутаас илүүгүй хугацаанд үг хэлж болно. Нэг бүлгээс нэг илтгэгч үг хэлнэ;
- Ерөнхийлөгчийн зөвлөл хэлэлцэх асуудлын жагсаалтын дагуу хэлэлцүүлэг явуулах хугацааг тогтооно. Энэ хугацааг Үндэсний Ассамблейн ерөнхийлөгч хэлэлцүүлгийн хугацаанаас хамаарч бүлэг тус бүрд тэнцүү хугацааг олгоно. Аль ч бүлэгт харьяалалгүй гишүүдэд тэнцүү хугацааны үг хэлэх боломж олгоно. Үлдсэн хугацааг Үндэсний Ассамблейн ерөнхийлөгч бүлгүүдэд тэдний гишүүдийн тооны харьцаанд тохируулан хуваарилна;
- Сөрөг хүчний бүлгүүдэд бусад бүлгүүдэд олгосон хугацаанаас илүү хугацаа олгоно. Нэмэлт хугацааны 60 хувь нь сөрөг хүчний бүлгүүдэд хуваарилагдах бөгөөд үүнийг тэдгээрийн гишүүдийн тооны харьцаанд тохируулан хуваарилна. Үлдсэн нэмэлт хугацааг Үндэсний Ассамблейн ерөнхийлөгч бүлгийн гишүүдийн тооны харьцаанд тохируулан хуваарилна. Бүлэгт ороогүй гишүүдэд тэдний тоонд нь харьцуулан үг хэлэх нийт хугацааг хуваарилна;
- Гишүүд нэг бүлгээс нөгөөд чөлөөтэй шилжих, бүлгүүд статусаа чөлөөтэй өөрчлөх эрх<sup>254</sup> нь асуудалд байр сууриа илэрхийлэх боломжийг бүлгүүдэд тэгш олгодог. Эдгээр байр сууриуд давхцах магадлал багатай тул парламент үргэлж сөрөг хүчинтэй байх бөгөөд энэ нь хоёр намын тогтолцооноос илүүтэйгээр өөр өөр үзэл бодлын бодит тэнцвэрийг тусгадаг байна.

<sup>254</sup> Мөн тэнд. Art.19-3, 21.

### **Сөрөг хүчний эрх зүйн байдал**

Сөрөг хүчний бүлгүүд нь парламентын үйл ажиллагаанд оролцох давуу эрхээр хангагдаж байгаа эсэхээс ихээхэн хамаарах ба Үндэсний Ассамблейн хуралдааны дэгийн тухай хуулиар сөрөг хүчин болон цөөнхийн бүлгүүдэд хэд хэдэн эрхийг олгосон.

Засгийн газарт сөрөг хүчний бүлгүүдийн үзүүлэх нөлөө нь парламентын хяналтыг хэрэгжүүлэхэд оролцох оролцооноос ихээхэн хамаардаг бөгөөд энэ засаглал хоорондын хяналт, тэнцвэрийг хангах төдийгүй олонх, цөөнхийн хоорондын харилцааны арга хэрэгсэл юм.

Долоо хоног бүрийн Засгийн газрын цагаар чуулганы хуралдаанд товлосон асуултын талаас доошгүй хувийг нь сөрөг хүчний гишүүд асуух зохицуулалтыг Үндэсний Ассамблейн хуралдааны дэгийн тухай хуулийн 133 дугаар зүйлд тусгасан байна.<sup>255</sup>

Франц Улсад Парламентын хяналтын хүрээнд сөрөг хүчин нь олонхтой адил тэгш боломжоор хангагдаад зогсохгүй, зарим талаар давуу байдал, тусгай эрх эдлэх боломжийг мөн хуулиар зохицуулжээ.

Үндэсний Ассамблейд сөрөг хүчний гишүүдийг удирдах албан тушаалд томилох замаар давуу байдал, тусгай эрхийг баталгаажуулсан. Тухайлбал, Үндэсний Ассамблейн хуралдааны дэгийн тухай хуулиар Мөрдөн шалгах хорооны дарга нь сөрөг хүчний бүлгийн гишүүн байна<sup>256</sup>, Тус хорооны ажлын алба нь дарга, 4 дэд дарга, 4 нарийн бичгийн даргаас бүрдэх ба Үндэсний Ассамблейн улс төрийн төлөөлөл, бүтцийг бүрэн тусгасан байдлаар дээрх томилгоог хийдэг байна.<sup>257</sup>

Санхүү, эдийн засаг, төсвийн хяналтын хорооны даргаар сөрөг хүчний гишүүнийг сонгоно.<sup>258</sup> Мөн Төрийн бодлогын үнэлгээ, хяналтын хорооны дэд дарга нарын нэг нь<sup>259</sup>, хорооноос томилогдсон хоёр илтгэгчийн нэг нь сөрөг хүчний гишүүн байна.<sup>260</sup>

Дээрх зохицуулалтууд нь төсвийн бүрдүүлэлт, гүйцэтгэлийн гол асуудал болох Засгийн газрын үйл ажиллагаанд парламентын хяналтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий чухал хороодын удирдах албан тушаалд сөрөг хүчний төлөөллийг томилохоор заасан нь парламентын хяналтыг хэрэгжүүлэхэд сөрөг хүчний оролцоог нэмэгдүүлэх, хяналтын үр нөлөөг дээшлүүлэхэд ихээхэн анхаардгийг илэрхийлж байна.

<sup>255</sup> Règlement de l'Assemblée Nationale. Art.133. [https://www.assemblee-nationale.fr/dyn/16/divers/texte\\_reference/02\\_reglement\\_assemblee\\_nationale#](https://www.assemblee-nationale.fr/dyn/16/divers/texte_reference/02_reglement_assemblee_nationale#)

<sup>256</sup> Мөн тэнд. Art.143-2.

<sup>257</sup> Мөн тэнд. Art.143-1.

<sup>258</sup> Мөн тэнд. Art.39-3.

<sup>259</sup> Мөн тэнд. Art.146-2-4.

<sup>260</sup> Мөн тэнд. Art.146-3-3.

Үндэсний Ассамблейд олонхын бүлэг нь нэг, сөрөг хүчний бүлэг хэд хэд байх боломжтой учраас сөрөг хүчнүүд парламентын хяналтын хөшүүргийг илүү үр дүнтэй ашиглах боломж, бололцоогоор хангагддаг байна.

Үндэсний Ассамблей дахь нийт бүлгүүдэд парламентын бүхий л үйл ажиллагаанд тэгш оролцох эрх олгосон байдаг. Тухайлбал, Үндэсний Ассамблейн хуралдааны дэгийн тухай хуулийн 28, 47-1, 10-3 дугаар зүйлд гишүүдийг Үндэсний Ассамблейн аль нэг албан тушаалд томилох, 146 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт төсвийн илтгэгчдийг томилоход Үндэсний Ассамблей дахь бүлгүүдийн төлөөллийг бүрэн хамарсан байхаар зохицуулсан байна.

### **ГУРАВ. УИХ ДАХЬ ОЛОН НАМЫН ОРОЛЦОО БА УИХ ДАХЬ ЦӨӨНХИЙН БҮЛЭГ БУЮУ СӨРӨГ ХҮЧНИЙ ТАЛААРХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ**

#### **3.1. УИХ дахь олон намын оролцоо (1990-2020 он)**

Бүгд Найрамдах Монгол Ард Улс (БНМАУ)-ын анхдугаар Үндсэн хууль 1924 онд батлагдаж, улмаар 1940, 1960 онд шинэчлэгдэж байсан бөгөөд 1990 онд батлагдсан 1960 оны Үндсэн хуулийн нэмэлтийн хуулиудаар улс орны нийгэм, улс төр, эдийн засгийн бүхий л харилцааны эх үндсийг зохицуулах эрх зүйн хэм хэмжээг тогтоож байв.

1990 оноос өмнө БНМАУ-ын Ардын Их Хурал (АИХ) хууль тогтоох, төрийн эрх барих дээд байгууллага байв. Нэг намын авторитар тогтолцоотой байсан тухайн үед бүх нийтийн санал хураалтаар АИХ-ын депутатуудыг аймаг, нийслэл, сум, дүүргээс нэг мандаттай, зөвхөн санал болгосон хүнийг дугуйлах замаар сонгож байсан. Тиймээс БНМАУ-ын АИХ-ын үед парламент дахь намын бүлэг, цөөнхийн талаарх ойлголт байхгүй байсан. 1990 оны 07 дугаар сард Монгол Улсад анх удаа олон намын оролцоотой анхны чөлөөт, ардчилсан сонгууль болж АИХ-ыг шинэчлэн байгуулж байсан. Энэхүү АИХ нь “БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хуулийг батлан гаргаж, уг хуулийн дагуу хууль тогтоох, хянан шалгах, зохион байгуулах эрх бүхий төрийн эрх барих байнгын дээд байгууллага болох Улсын Бага Хурал (УБХ)-ыг байгуулсан. АИХ-ын 430 депутатаас сонгогдсон 50 гишүүнтэй УБХ нь 1990-1992 онд бүрэн эрхээ хэрэгжүүлсэн. УБХ бол Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгмийн байгууллыг шинэтгэх эрх зүйн үндсийг бүрдүүлсэн анхны байнгын үйл ажиллагаатай парламент юм. Тухайлбал, улс төрийн харилцааны хувьд олон намын тогтолцоог баталгаажуулсан ардчилсан дэглэмд шилжсэн, иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эрх тэгш байдлыг хүлээн зөвшөөрч, баталгааг хангах үндсэн үүргийг төр хариуцах болсон.

Өөрөөр хэлбэл, олон ургалч үзлийг нийгмийн оюун санааны эш үндэс болгосон. Энэ бол ардчиллын чухал үнэт зүйлсийн нэг юм. Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Үндсэн хуулийн Цэцийн тухай болон БНМАУ-ын шүүхийн байгууламжийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиудыг баталж, төрийн байгууллын шинэ тогтолцооны эрх зүйн үндсийг бүрдүүлсэн.

Эдийн засгийн харилцааны хувьд нийтийн өмчид суурилсан аж ахуйн социалист тогтолцоо дангаар ноёрхож байсныг халж, олон хэвшилт эдийн засагтай болох харилцааг хуульчлан баталгаажуулсан. Шударга өрсөлдөөнд үндэслэсэн зах зээлийн эдийн засгийн харилцааг тогтоож, түүнд төрийн оролцоог хязгаарлаж өгсөн. Хувийн ба нийтийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, төрийн өмчийг задлан хувьчлах, иргэд хувийн аж ахуй эрхлэх эрх зүйн үндсийг тогтоож, банк, гааль, албан татварын зэрэг хуулиудыг шинэчлэн баталжээ.

УБХ-аас боловсруулж АИХ-ын чуулганд хэлэлцүүлсэн Монгол Улсын ардчилсан, шинэ Үндсэн хууль 1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсанаар нийгмийн бүх хүрээнд ардчилсан зарчмыг тууштай хэрэгжүүлэх эрх зүйн харилцааны тулгуур эхлэл тавигдсан юм.

Ийнхүү 1992 оны 07 дугаар сарын 29-ний өдөр УБХ Монгол Улсын шинэ Үндсэн хуулийн дагуу сонгогдон Монгол Улсын Их Хурал (УИХ)-д эрхээ шилжүүлэн өгснөөр үйл ажиллагаа нь дуусгавар болсон.<sup>261</sup>

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.”<sup>262</sup> хэмээн баталгаажуулж, нэг танхимтай парламентын тогтолцоонд шилжсэнээс хойш эдүгээ 8 дахь парламентын бүрэн эрхийн хугацаа хэрэгжиж байна.

1992 онд анхны УИХ хууль тогтоох үйл ажиллагаагаа эхлүүлж, парламентын 76 гишүүн, 4 жилийн хугацаатай чөлөөт ардчилсан сонгуулиар сонгогдож ирсэн. 1992 оноос УИХ-ын гишүүдийг сонгох сонгуулийг томсгосон болон жижиг тойрог бүхий мажоритар тогтолцоогоор зохион байгуулж ирсэн бол 2012 оны УИХ-ын сонгуулийг анх удаа холимог тогтолцоогоор явуулж байв.

<sup>261</sup> УИХ-ын цахим хуудас. <https://www.parliament.mn/nn/2348/>

<sup>262</sup> Монгол Улсын Үндсэн хууль. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>



*Хүснэгт 6. УИХ-ын сонгуулийн товчоон (1992-2020 он)*

<b>Сонгуулийн он цагийн дараалал</b>	<b>Сонгуульд оролцсон нам, эвсэл, нэр дэвшигч</b>	<b>УИХ дахь нам, эвслийн харьцаа</b>
<b>1990-1992 (УБХ)</b>	УБХ-ын 50 гишүүнийг сонгогчдын 5, түүнээс дээш хувийн санал авсан намд УБХ-ын мандат буюу суудал хувь тэнцүүлэн хуваарилж (5 хувьд 1 мандат), намууд сонгуулиар авсан мандатынхаа тоогоор нэр дэвшүүлж АИХ-аас сонгосон.	МАХН 33, Монголын ардчилсан нам 13, Монголын Социал-демократ нам 4, Монголын Үндэсний дэвшлийн нам 3 суудал авсан.
<b>1992-1996</b>	<b>Нам, эвсэл:</b> 8 нам, 2 эвсэл <b>Нийт нэр дэвшигч:</b> 293 <b>Нам, эвслээс нэр дэвшигч:</b> 275 <b>Бие даан нэр дэвшигч:</b> 18	Нийт сонгогчдын 57.1 хувийн саналыг авсан МАХН УИХ-д 70 суудалтай, харин 31.1 хувийн санал авсан Ардчилсан нам 5 суудал авсан.
<b>1996-2000</b>	<b>Нам, эвсэл:</b> 5 нам, 2 эвсэл <b>Нийт нэр дэвшигч:</b> 302 <b>Нам, эвслээс нэр дэвшигч:</b> 267 <b>Бие даан нэр дэвшигч:</b> 35	Сонгогчдын 45.7 хувийн саналыг авсан Ардчилсан нам УИХ-д 50 суудалтай, харин 39.9 хувийн санал авсан МАХН 25 суудал авсан.
<b>2000-2004</b>	<b>Нам, эвсэл:</b> 13 нам, 3 эвсэл <b>Нийт нэр дэвшигч:</b> 602 <b>Нам, эвслээс нэр дэвшигч:</b> 575 <b>Бие даан нэр дэвшигч:</b> 27	Сонгогчдын 51.5 хувийн саналыг авсан МАХН УИХ-д 72 суудалтай, харин 24.1 хувийн санал авсан Ардчилсан нам 1 суудал авсан.
<b>2004-2008</b>	<b>Нам, эвсэл:</b> 7 нам, 1 эвсэл <b>Нийт нэр дэвшигч:</b> 244 <b>Нам, эвслээс нэр дэвшигч:</b> 229 <b>Бие даан нэр дэвшигч:</b> 15	Сонгогчдын 48.8 хувийн саналыг авсан МАХН УИХ-д 36 суудалтай, харин 44.8 хувийн санал авсан Ардчилсан нам 36 суудал авсан.
<b>2008-2012</b>	<b>Нам, эвсэл:</b> 12 нам, 1 эвсэл <b>Нийт нэр дэвшигч:</b> 356 <b>Нам, эвслээс нэр дэвшигч:</b> 311 <b>Бие даан нэр дэвшигч:</b> 45	Сонгогчдын 43 хувийн саналыг авсан МАХН УИХ-д 45 суудалтай, харин 39.2 хувийн санал авсан Ардчилсан нам 28 суудал авсан.
<b>2012-2016</b>	<b>Нам, эвсэл:</b> 11 нам, 2 эвсэл <b>Нийт нэр дэвшигч:</b> 544 <b>Нам, эвслээс нэр дэвшигч:</b> 518 <b>Бие даан нэр дэвшигч:</b> 26	Томсгосон мажоритар 26 тойргоос 48 нэр дэвшигч сонгох сонгуульд сонгогчдын 33.5 хувийн саналыг авсан МАН 17 суудал авсан бол 34.2 хувийн саналыг авсан АН 25 суудал, 17.9 хувийн санал авсан МАХН 3 суудал авсан. Харин намын жагсаалтаар сонгогдох 28 нэр дэвшигчийг намууд авсан саналын хэмжээтэй дүйцэхүйц хэмжээгээр хувааж авчээ.

<b>2016-2020</b>	<b>Нам, эвсэл:</b> 12 нам, 3 эвсэл <b>Нийт нэр дэвшигч:</b> 498 <b>Нам, эвслээс нэр дэвшигч:</b> 429 <b>Бие даан нэр дэвшигч:</b> 69	Сонгогчдын 46.5 хувийн саналыг авсан МАН УИХ-д 65 суудалтай, харин 34.2 хувийн санал авсан Ардчилсан нам 9 суудалтай болжээ.
<b>2020-2024</b>	<b>Нам, эвсэл:</b> 13 нам, 4 эвсэл <b>Нийт нэр дэвшигч:</b> 606 <b>Нам, эвслээс нэр дэвшигч:</b> 485 <b>Бие даан нэр дэвшигч:</b> 121	АН-11 Бие даагч-1 Зөв хүн электрот хөдөлгөөн-1 Та бидний эвсэл-1

Харин 2024 оны УИХ-ын ээлжит сонгуулиар Монгол Улсын Үндсэн хуульд 2023 онд орсон өөрчлөлтийн дагуу 126 гишүүнтэй парламент бүрдэнэ. Энэ удаагийн УИХ-ын сонгууль нь сонгуулийн холимог тогтолцоогоор явагдана. Ингэхдээ 78 гишүүнийг томсгосон мажоритар, 48 гишүүнийг нэг тойргийн хаалттай жагсаалт бүхий пропорциональ тогтолцоогоор сонгоно.

### 3.2. УИХ дахь цөөнхийн бүлэг (сөрөг хүчин)-ийн эрх зүйн орчны өөрчлөлт

Монгол Улсын байнгын ажиллагаатай парламент байгуулагдсан цагаасаа хойш УИХ-ын тухай болон УИХ-ын хуралдааны дэгээ хэд хэдэн удаа шинэчлэн баталсан.

#### Хүснэгт 7. УИХ-ын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомжийн жагсаалт

	<b>УИХ-ын бүрэн эрхийн хугацаа</b>	<b>УИХ-ын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж</b>
1	1990-1992 (УБХ)	- БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хууль (1990.05.10)
2	1992-1996 (УИХ)	- Монгол Улсын Их Хурлын тухай хууль (1992.01.06)
3	1996-2000	- Монгол Улсын Их Хурлын тухай хууль (1997.02.07) - Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэг (1997.02.06) - Монгол Улсын Их Хурлын тухай хууль (2001.06.21)
4	2000-2004	- Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэг (УИХ-ын тогтоол, 2001, №61)
5	2004-2008	- Монгол Улсын Их Хурлын тухай хууль (2006.01.26)
6	2008-2012	- Монгол Улсын Их Хурлын чуулганы дэг (УИХ-ын тогтоол, 2006, №14)
7	2012-2016	- Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль (2007.10.11)
8	2016-2020	- Монгол Улсын Их Хурлын тухай хууль (2020.05.07)
9	2020-2024	- Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль (2020.05.13)

**Эх сурвалж:**

- Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль 1990-2017 он (Эх сурвалж, харьцуулсан судалгаа). Ерөнхий редактор Ц.Цолмон. УБ., 2018.
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://www.legalinfo.mn/additional/?lawid=356>

1992 оны парламентаас хойш Монгол Улсын төрийн эрх барих дээд байгууллага, УИХ-д сөрөг хүчин буюу цөөнхийн бүлгийн асуудлыг хуулиар зохицуулах шаардлага үүссэн. УИХ дахь намын бүлэг, цөөнхтэй холбоотой гол ойлголт, нэр томъёонууд түүхэн хөгжлийн үүднээс агуулга, хүрээний хувьд өргөжиж, тухай тухайн үеийнхээ Монгол Улсын Их Хурлын тухай хууль (МУИХтХ) болон холбогдох хуулиуддаа тусгагдаж ирсэн.

**Хүснэгт 8. Улсын Их Хурлын тухай хуулиар УИХ дахь намын бүлэг, цөөнхтэй холбоотой асуудлыг зохицуулсан байдал**

	Асуудал	УИХ-ын үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж
1	<b>Намын бүлэг</b>	1992 оны МУИХтХ-ийн 17.1-т “Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудал бүхий нам бүлэг байгуулж болно.” гэж томъёолж байсан бол 2006 оны МУИХтХ-аас “Улсын Их Хурлын сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудал авсан нам, эвсэл бүлэг байгуулж болно.” гэж өөрчлөн найруулсан. Тооны хувьд 8 суудал байх гэсэн шалгуур тогтвортой мөрдөгдөж иржээ.
2	<b>Намын бүлгийн эрх, үүрэг</b>	1992 оны МУИХтХ-аас намын бүлгийн эрх, үүргийг 6 байхаар томъёолж байсан. Дараа дараагийн хуулиудад хүрээ, зохицуулалт өргөжсөөр 2020 оны УИХтХ-д 9 болсон байна. Дэлгэрэнгүйг хавсралт 2-оос харна уу.
3	<b>Цөөнх</b>	1992 оны хуулиас “Улсын Их Хурлын чуулганы хуралдааны ажиллагаа ... цөөнхийн санаа бодлыг хүндэтгэн олонхын саналаар шийдвэрлэх зарчимд үндэслэнэ.” гэж орсон. 1997 оны МУИХтХ-аар “Улсын Их Хурлын нийт гишүүний 39-өөс доош суудал авсан нам буюу эвслийн бүлэг, гишүүнийг Улсын Их Хурал дахь цөөнхөд тооцно.” гэж анх томъёолсон. Түүнээс хойших МУИХтХ-уудад нарийвчлан тусгагдаж ирсэн.
4	<b>УИХ-ын дэд дарга</b>	2000 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр “...Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс Улсын Их Хурлын дэд даргыг сонгоно. “ гэсэн зохицуулалт орсон. 2001 оны МУИХтХ-д энэ асуудлыг нарийвчлан тусгаж, улмаар 2006, 2020 оны хуулиудад дэд дарга нарын томилгоо, эрх, үүрэг, чөлөөлөх, огцруулах зэрэг нарийвчилсан зохицуулалтууд орсон байна.
5	<b>Бүлгийн ажлын алба</b>	1992 оны МУИХтХ-д “Улсын Их Хурал дахь намын бүлэг орон тооны ажилтантай байж болно.” гэсэн заалт байсан бол 2006 оны МУИХтХ-аас “Бүлэг нь бодлогоо боловсруулах, зохион байгуулалтын туслалцаа авах чиг үүрэг бүхий ажлын албатай байх” зохицуулалт орсон.

6	<b>УИХ-ын даргын дэргэдэх Зөвлөл</b>	2006 оны МУИХтХ-аас “Нам, эвслийн бүлэг, Байнгын хороодын үйл ажиллагаа, Улсын Их Хурлын хяналт шалгалтын ажлыг уялдуулан зохицуулах, нам, эвслийн бүлэг, Байнгын хороодын санал болон хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хугацааг харгалзан ээлжит болон ээлжит бус чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал тогтоох, тухайн долоо хоногт чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлын тов, дарааллыг батлах, Улсын Их Хурлын төсөв болон Улсын Их Хурлын дотоод үйл ажиллагаатай холбогдолтой бусад асуудлыг зөвшилцөх чиг үүрэг бүхий Зөвлөл Улсын Их Хурлын даргын дэргэд ажиллана.” гэсэн заалт орсон.
7	<b>Байнгын хороод, дэд хороод</b>	1992 оны МУИХтХ-аас “Улсын Их Хурлын дарга Байнгын хорооны бүрэлдэхүүний талаар намуудын бүлгийн ахлагч нартай зөвшилцсөнөөр Улсын Их Хурал өөрийн гишүүдээс сонгон Байнгын хороог байгуулна.” 1997 оны МУИХтХ-иас “Төсвийн зарлагын хяналтын болон Ёс зүйн дэд хороодын даргыг Улсын Их Хурал дахь цөөнхийн бүлэгт ордог Улсын Их Хурлын гишүүдээс сонгоно.” гэсэн зохицуулалт, 2019 онд Үндсэн хуульд “Хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал Улсын Их Хурал цөөнхийн төлөөллийг оролцуулан уг хороог байгуулна.” гэсэн нэмэлт орсон. Үүнтэй холбоотойгоор 2020 оны МУИХтХ-д “...хуулийн биелэлтийг хангахтай холбоотой нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний нэгээс доошгүй нь Хянан шалгах түр хороо байгуулах санал тавибал цөөнхийн төлөөллийг оролцуулан Улсын Их Хурлын тогтоолоор хойшлуулахгүйгээр байгуулна.”
8	<b>Дэгийн тухай хууль</b>	1997 онд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль анх батлагдсан, тус хуулийг 2007, 2020 онд тус тус шинэчлэн найруулсан. Энэхүү хуульд намын бүлэг, цөөнхийн үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтуудыг тусгасан.

*Дэлгэрэнгүйг хавсралт хүснэгтээс харна уу.*

## АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Opposition and Legislative Minorities: Constitutional Roles, Rights and Recognition. International IDEA. <https://www.idea.int/sites/default/files/publications/opposition-and-legislative-minorities-constitutional-roles-rights-recognition.pdf>
- Guidelines on the rights and duties of the opposition in parliament: <http://archive.ipu.org/dem-e/opposition.pdf>
- Гадаад орнуудын парламентын хуралдааны дэгийн эмхэтгэл. УИХ-ын Тамгын газар. 2023 он.

### Австрали Улс

- Australian Constitution. <https://www.aph.gov.au/constitution>
- House of Representatives Practice (7th edition). [www.aph.gov.au/About\\_Parliament/House\\_of\\_Representatives/Powers\\_practice\\_and\\_procedure/Practice7](http://www.aph.gov.au/About_Parliament/House_of_Representatives/Powers_practice_and_procedure/Practice7)
- House of Representatives Standing and Sessional Orders. [www.aph.gov.au/About\\_Parliament/House\\_of\\_Representatives/Powers\\_practice\\_and\\_procedure/House\\_of\\_Representatives\\_Standing\\_and\\_Sessional\\_Orders](http://www.aph.gov.au/About_Parliament/House_of_Representatives/Powers_practice_and_procedure/House_of_Representatives_Standing_and_Sessional_Orders)
- Parliament of Australia. <https://www.aph.gov.au/>
- Parliamentary Education Office. <https://peo.gov.au/>
- The Politics of Australia. Jaensch, Dean.
- Introduction to the Study of the Law of the Constitution. AV Dicey.
- Commonwealth Table of Precedence. Special Gazette No. S206 of 5 October 1982.

### Герман Улс

- <https://www.deutschland.de/en/topic/politics/the-german-parliament-and-the-parties>
- Бундестагийн хуралдааны дэгийн тухай хууль.
- Бундестагийн хянан шалгах түр хорооны эрх зүйн байдлын тухай хууль.

### Нидерланд Улс

- Хуулиар дамжуулан ардчиллыг бататгахын төлөө Европын комисс, Ардчилсан парламентад сөрөг хүчний үүрэг оролцооны тухай. [https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-AD\(2010\)025-e](https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-AD(2010)025-e)
- Хуулиар дамжуулан ардчиллыг бататгахын төлөө Европын комисс, Ардчилсан нийгэм дэх парламентын олонх ба сөрөг хүчний хоорондын харилцааны параметрууд: Хяналтын

хуудас. [https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-AD\(2019\)015-e](https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?pdffile=CDL-AD(2019)015-e)

- Хуулиар дамжуулан ардчиллыг бататгахын төлөөх Европын комисс, Ардчилсан парламент дахь сөрөг хүчний эрх, үүргийн талаарх процедурын удирдамж. <https://assembly.coe.int/nw/xml/XRef/Xref-XML2HTML-en.asp?fileid=11792&lang=en>

## БНСУ

- [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?lang=ENG&hseq=1](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?lang=ENG&hseq=1)
- [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=25732&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=25732&lang=ENG)
- [https://elaw.klri.re.kr/eng\\_service/lawView.do?hseq=60320&lang=ENG](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=60320&lang=ENG)
- <https://korea.assembly.go.kr:447/portalEn/main/main.do#section1>
- [https://s-space.snu.ac.kr/bitstream/10371/70195/1/kjps\\_15\\_1\\_25-42.pdf](https://s-space.snu.ac.kr/bitstream/10371/70195/1/kjps_15_1_25-42.pdf)
- <https://korea.assembly.go.kr:447/portalEn/main/contents.do?menuNo=1500025>
- [https://www.europarl.europa.eu/RegData/etudes/BRIE/2022/733582/EPRS\\_BRI\(2022\)733582\\_EN.pdf](https://www.europarl.europa.eu/RegData/etudes/BRIE/2022/733582/EPRS_BRI(2022)733582_EN.pdf)

## Финланд Улс

- The Constitution of Finland. [https://www.finlex.fi/en/laki/kaannokset/1999/en19990731\\_20180817.pdf](https://www.finlex.fi/en/laki/kaannokset/1999/en19990731_20180817.pdf)
- Parliament's rules of procedure [https://www.eduskunta.fi/EN/naineduskuntatoimii/Documents/RulesofProcedure\\_20150416.pdf](https://www.eduskunta.fi/EN/naineduskuntatoimii/Documents/RulesofProcedure_20150416.pdf)
- Eduskunta Riksdagen page. <https://www.eduskunta.fi/EN/valiokunnat/Pages/default.aspx>
- БНФУ-ын Парламентын хуралдааны дэг (Гарын авлага). “Монгол Улсын төлөөллийн байгууллагыг бэхжүүлэх”. УБ., 2019 он

## Франц Улс

- Constitution of October 4, 1958: <https://www2.assemblee-nationale.fr/langues/welcome-to-the-english-website-of-the-french-national-assembly#chap5>
- Règlement de l'assemblée nationale. [https://www.assemblee-nationale.fr/dyn/16/divers/texte\\_reference/02\\_reglement\\_assemblee\\_nationale#](https://www.assemblee-nationale.fr/dyn/16/divers/texte_reference/02_reglement_assemblee_nationale#)
- Rights and responsibilities of the opposition in the parliament. [http://www.assembly.coe.int/LifeRay/APCE/pdf/ConfPres/2010Limassol/Droitsetresponsabilitesparlement\\_E.pdf](http://www.assembly.coe.int/LifeRay/APCE/pdf/ConfPres/2010Limassol/Droitsetresponsabilitesparlement_E.pdf)



- Report on the role of the opposition in a democratic Parliament, adopted by the Venice Commission, at its 84th Plenary Session (Venice 15-16 October 2010).
- [https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?ref=cdl-ad\(2010\)025&lang=EN](https://www.venice.coe.int/webforms/documents/default.aspx?ref=cdl-ad(2010)025&lang=EN)
- Thomas Künig. Government dominance and the role of opposition in parliamentary democracies. <https://ejpr.onlinelibrary.wiley.com/doi/10.1111/1475-6765.12525>
- В.В.Маклаков. Парламент Франции. <https://cyberleninka.ru/article/n/parlament-frantsii-perevod-zakonodatelnyh-aktov/viewer>
- БНФУ-ын талаарх мэдвэл зохих баримтууд, Б.Туул, 2023 : <https://montsame.mn/en/read/319540>
- <https://www.assemblee-nationale.fr/dyn/les-groupes-politiques>
- [https://www2.assemblee-nationale.fr/instances/liste/groupes\\_politiques/effectif](https://www2.assemblee-nationale.fr/instances/liste/groupes_politiques/effectif)
- <https://www2.assemblee-nationale.fr/deputes/liste/groupe-politique>

**ХАВСРАЛТ. УИХ-ын тухай хууль дахь намын бүлэг, цөөнхтэй холбоотой эрх зүйн зохицуулалтын түүхчилсэн лавлагаа (1992-2020 он)**

Нэр томъёо	1992.01.06	1997.02.07	2007.06.21	2006.01.26	2020.05.07
Намын бүлэг	<p>5.3.Улсын Их Хурлын нийт гишүүний ердийн олонх буюу 39-өөс доошгүйн бүрэн эрх хууль ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн нам, эсхүл эвслийг Улсын Их Хурал дахь олонхын суудал авсан нам буюу эвсэлд тооцно.</p> <p>17.1.Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудал бүхий нам бүлэг /цаашид “намын бүлэг” гэх/ байгуулж болно. Улсын Их Хурлын гишүүн зөвхөн өөрийнх нь нэр дэвшүүлсэн намын бүлэгт харьяалагдана.</p>	<p>17.1.Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудалтай нам/эвсэл/бүлэг /цаашид “нам, эвслийн бүлэг” гэх/ байгуулж болно. Нам, эвслийн бүлэгт зөвхөн тухайн нам, эвслээс нэрийг нь дэвшүүлж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд орно.</p> <p>Улсын Их Хурлын сонгуульд эвсэл байгуулж оролцсон намууд Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудал эзэлбэл Монгол Улсын сонгуулийн хуулийн 19 дүгээр зүйлийн 2-т зааснаар эвслийн нэг бүлэг байгуулна.</p>	<p>21.1.Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудалтай нам/эвсэл/бүлэг /цаашид “нам, эвслийн бүлэг” гэх/ байгуулж болно. Нам, эвслийн бүлэгт зөвхөн тухайн нам, эвслээс нэрийг нь дэвшүүлж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд орно. Улсын Их Хурлын сонгуульд эвсэл байгуулж оролцсон намууд Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудал эзэлбэл Монгол Улсын сонгуулийн хуулийн 19 дүгээр зүйлийн 2-т зааснаар эвслийн нэг бүлэг байгуулна.</p>	<p>26.1.Улсын Их Хурлын сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудал авсан нам, эвсэл бүлэг /цаашид “бүлэг” гэх/ байгуулж болно.</p> <p>26.2.Бүлэгт зөвхөн тухайн нам, эвслээс нэр нь албан ёсоор нэр дэвшиж сонгогдсон гишүүд орно.</p> <p>26.3.Сонгуульд эвсэл байгуулж оролцсон намууд Улсын Их Хуралд 8-аас доошгүй суудал авсан бол эвслийн нэг бүлэг байгуулна.</p>	<p>33.1.Бүлэг дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>33.1.1.хэлэлцэж байгаа хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, төрийн дотоод, гадаад бодлогын асуудлаар бодлого, байр сууриа тодорхойлж санал, дүгнэлт гарган зохих Байнгын хорооны, эсхүл нэгдсэн хуралдаанаар шууд хэлэлцүүлэх;</p>

Улсын Их Хурлын сонгуульд эвсэл байгуулан оролцсон намууд 8-аас доошгүй суудал эзэлсэн нөхцөлд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 19 дүгээр зүйлийн 2-т зааснаар Улсын Их Хуралд нам (эвсэл)-ын нэг бүлэгтэй байна.	17.2. Улсын Их Хуралд 8-аас доош суудал эзэлсэн хэд хэдэн намыг төлөөлж буй гишүүд нийлж намын нэг бүлэгт байгуулж болохгүй. Харин тэдгээр нь аль нэг нам, эвслийн бүлэгт нэгдэж болох бөгөөд хэрэв нам, эвслийн бүлгээс гарах, шилжих бол тухай бүр Улсын Их Хурлын даргад мэдэгдэнэ.	21.2. Улсын Их Хуралд 8-аас доош суудал эзэлсэн хэд хэдэн намыг төлөөлж байгаа гишүүд нийлж намын нэг бүлэг байгуулж болохгүй. Харин тэдгээр нь аль нэг нам, эвслийн бүлэгт нэгдэх бол тухайн нам, эвслийн бүлэгт нэгдэн орох хүсэлтээ тавина. Хүсэлтийг хүлээн авсан бол энэ тухай шийдвэрээ нам, эвслийн бүлгийн ахлагч Улсын Их Хурлын даргад бичгээр мэдэгдэнэ. Улсын Их Хурлын дарга уг баримт бичгийг үндэслэн Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд албан ёсоор мэдээлнэ.	26.4. Улсын Их Хуралд 8-аас дээш суудал авсан нам татан буугдсан, эвсэл тарсан бол бүлгийг татан буугдсанд тооцох ба түүний бүрэлдэхүүнд байсан гишүүд дахин бүлэг байгуулахыг хориглоно.	33.1.2. ээлжит чуулганаар хэлэлцэх асуудал, түүний дарааллын талаар Улсын Их Хурал болон Улсын Их Хурлын даргад саналаа илэрхийлэх;  33.1.3. нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах санал гаргах;  33.1.4. нэгдсэн болон Байнгын, дэд, түр хорооны хуралдааны үед тухайн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан завсарлага авах;
Бие даан нэр дэвшүүлж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд аль нэг намын бүлэгт нэгдэн ажиллах боловч дангаараа бүлэг байгуулж болохгүй. Улсын Их Хуралд 8 хүрэхгүй суудал бүхий хэд хэдэн намын гишүүд нийлж намын нэг бүлэг байгуулахыг хориглоно. Харин тэдгээр нь аль нэг намын бүлэгт эвсэн нэгдэж болно.	17.3. Аль нэг нам, эвслийн бүлгийн гишүүн уг нам, эвслийн бүлгийн харьяаллаас татгалзсан тохиолдолд эвслийн бүлгээс албан ёсоор гарч өөр бүлэгт нэгдэн орж болно. Ийнхүү нам, эвслийн бүлгээс албан ёсоор гарах тухайгаа тухайн нам, эвслийн бүлгийн ахлагчид урьдчилан мэдэгдсэн байна.	21.3. Аль нэг нам, эвслийн бүлгийн гишүүн уг нам, эвслийн бүлгийн харьяаллаас татгалзсан тохиолдолд нам, эвслийн бүлгээс албан ёсоор гарч өөр бүлэгт нэгдэн орж болно. Ийнхүү нам, эвслийн бүлгээс албан ёсоор гарах тухайгаа тухайн нам, эвслийн бүлгийн ахлагчид урьдчилан мэдэгдсэн байна.	26.5. Нам, эвсэл бүлэг байгуулсан тухай шийдвэр, бүлгийн гишүүдийн нэрсийн жагсаалтыг Улсын Их Хурлын даргад бичгээр өргөн мэдүүлэх бөгөөд ийнхүү өргөн мэдүүлснээр бүлэг эрх, үүргээ хэрэгжүүлнэ.	33.1.5. Байнгын, дэд, түр хорооны бүрэлдэхүүний талаар Улсын Их Хурлын даргатай зөвшилцөх;

17.5.Намын бүлэгт Улсын Их Хурлын бүтцийн хэсгийн хувьд эрхлэх ажлаа намынхаа төв байгууллагын удирдлагад шууд хариуцахгүй.	17.4.Нэрээ бие даан дэвшүүлж сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн аль нэг нам, эвслийн бүлэгт нэгдэж болох боловч дангаараа бүлэг байгуулж болохгүй.	17.5.Нам, эвслийн бүлэг ахлагчаа гишүүдийнхээ дотроос сонгож энэ тухайгаа Улсын Их Хуралд албан ёсоор мэдэгдэнэ.	17.6.Нам, эвслийн бүлгийн ахлагч Улсын Их Хурлын анхдугаар чуулган дээр Улсын Их Хурлын даргыг сонгогдсоноос хойш 24 цагийн дотор нам, эвслийн бүлэг байгуулсан тухай шийдвэр, нэрсийн жагсаалтыг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлнэ.	21.5.Нам, эвслийн бүлэг ахлагчаа гишүүдийнхээ дотроос сонгож, энэ тухайгаа Улсын Их Хуралд албан ёсоор мэдэгдэнэ.	21.6.Нам, эвслийн бүлгийн ахлагч Улсын Их Хурлын анхдугаар чуулган дээр Улсын Их Хурлын даргыг сонгогдсоноос хойш 24 цагийн дотор нам, эвслийн бүлэг байгуулсан тухай шийдвэр, нэрсийн жагсаалтыг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлнэ.	21.7.Улсын Их Хурлын дарга нам, эвслийн бүлгээс өргөн мэдүүлсэн баримт бичгийг үндэслэн нам, эвслийн бүлгийг бүртгэж, энэ тухай Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан дээр албан ёсоор зарлана. Шинээр нөхөн сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн аль нэг нам, эвслийн бүлэгт эвсэн нэгдвэл түүнийг тухайн нам, эвслийн бүлгийн ахлагч бүлэгтээ бүртгэн авч, энэ тухай шийдвэрээ гаргаж Улсын Их Хурлын даргад бичгээр мэдэгдэнэ. Улсын Их Хурлын дарга уг шийдвэрийг нэгдсэн хуралдаанд албан ёсоор мэдээлнэ.	26.7.Бүлэг байгуулсан тухай шийдвэр, бүлгийн гишүүдийн нэрсийн жагсаалтыг Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаан дээр албан ёсоор мэдээлнэ.	26.8.Шинээр нөхөн сонгогдсон гишүүн аль нэг бүлэгт нэгдвэл тухайн бүлгийн дарга Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд тус тус албан ёсоор мэдээлнэ.	26.9.Бие даан нэр дэвшиж сонгогдсон болон ээлжит сонгуулиар наймаас доош суудал авсан өөр өөр нам, эвслийн төлөөлөл бүхий гишүүд нийлж нэг бүлэг байгуулахыг хориглоно.	26.10.Энэ хуулийн 26.9-т заасан гишүүд аль нэг бүлэгт нэгдэж болох бөгөөд энэ тухай шийдвэрийг энэ хуулийн 26.8-д заасны дагуу мэдээлнэ.	31.1.Улсын Их Хурлын сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд наймаас доошгүй суудал авсан нам, эвсэл бүлэг /цаашид “бүлэг” гэх/ байгуулж болно.	31.2.Бүлэгт зөвхөн тухайн нам, эвслээс албан ёсоор нэр дэвшиж сонгогдсон гишүүд орно.	31.3.Бүлэг даргаа гишүүдийнхээ дотроос сонгож, энэ тухайгаа Улсын Их Хурлын даргад бичгээр мэдээлнэ.	31.4.Нам, эвсэл бүлэг байгуулсан тухай шийдвэр, жагсаалтыг Улсын Их Хурлын гишүүдийн нэрсийн жагсаалтыг Улсын Их Хурлын даргад бичгээр ирүүлэх бөгөөд ийнхүү ирүүлснээр бүлгийн эрх, үүрэг хэрэгжиж эхэлнэ.	31.5.Бие даан нэр дэвшиж сонгогдсон болон ээлжит сонгуулиар наймаас доош суудал авсан өөр өөр нам, эвслийн төлөөлөл бүхий гишүүд нийлж нэг бүлэг байгуулахыг хориглоно.
---	---	--	--	---	--	---	--	--	---	--	--	---	--	---	---

		<p>17.7. Улсын Их Хурлын дарга нам, эвслийн бүлгээс өргөн мэдүүлсэн баримт бичгийг үндэслэн нам, эвслийн бүлгийг бүртгэж, энэ тухай Улсын Их Хурлын чуулганы хуралдаан дээр албан ёсоор зарлана. Шинээр нөхөн сонгогдсон Улсын Их Хурлын гишүүн аль нэг нам, эвслийн бүлэгт эвсэн нэгдвэл, түүнийг тухайн нам, эвслийн бүлгийн ахлагч бүлэгтээ бүртгэн авч, энэ тухай шийдвэр гаргана. Уг шийдвэрийг гишүүний өргөдлийн хамт гишүүний бүрэн эрх нь эхэлснээс хойш 24 цагийн дотор Улсын Их Хурлын дарга Улсын Их Хурлын чуулганы хуралдаан дээр албан ёсоор мэдээлнэ.</p>	<p>21.8. Улсын Их Хуралд суудал бүхий аль нэг нам тарах буюу намууд эвслээ цуцалбал тухайн нам, эвслийн бүлгийн үйл ажиллагаа дуусгавар болсонд тооцно. Нам тарсан буюу намууд эвслээ цуцалсан тухай шийдвэрийг, ийнхүү шийдвэр гарснаас хойш хуралдах эхний нэгдсэн хуралдаанд, чуулганы завсарлагааны үед уг шийдвэр гарвал ээлжит чуулганы эхний нэгдсэн хуралдаанд тус тус мэдээлнэ.</p> <p>21.9. Нам, эвслийн бүлгийн хуралдааныг чуулганы хугацаанд долоо хоног бүрийн даваа гаримт зохион байгуулж байна.</p>	<p>26.11. Гишүүд нэг бүлгээс гарч нөгөө бүлэгт нэгдэн орж болох боловч ийнхүү бүлгээс гарсан гишүүд нэгдэж бие даан бүлэг байгуулахыг хориглоно.</p> <p>26.12. Энэ хуулийн 26.11-т заасны дагуу гишүүн аль нэг бүлгээс гарсан, нөгөө бүлэгт нэгдэн орсон бол тухайн бүлгийн дарга, Улсын Их Хурлын дарга, Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд тус тус албан ёсоор мэдээлнэ.</p> <p>/Энэ хэсгийг 2012.12.21-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/</p>	<p>31.6. Гишүүн бүлгээс гарсан бол өөр бүлэгт нэгдэн орохыг хориглоно.</p> <p>31.7. Бүлгээс гарсан гишүүд нэгдэж бие даан бүлэг байгуулахыг хориглоно.</p> <p>31.8. Нөхөн сонгогдсон гишүүн аль нэг бүлэгт нэгдсэн бол тухайн бүлгийн дарга нь, гишүүн аль нэг бүлгээс гарсан бол энэ тухайгаа Улсын Их Хурлын даргад бичгээр тус тус ирүүлснийг Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд уншиж сонсоно.</p> <p>31.9. Улсын Их Хуралд бүлэг байгуулсан нам татан буугдсан, эвсэл тарсан бол бүлгийг татан буугдсанд тооцох ба түүний бүрэлдэхүүнд байсан гишүүд нэгдэн дахин бүлэг байгуулахыг хориглоно.</p> <p>31.10. Энэ хуулийн 31.9-д заасан гишүүн аль нэг бүлэгт нэгдэн орсон бол энэ хуулийн 31.8-д заасны дагуу мэдээлнэ.</p>
--	--	---	--	--	--

УИХ.МН  
СУДАЛГААНЫ САН

	17.8.Улсын Их Хуралд суудал бүхий аль нэг нам тарах буюу намууд эвслээ цуцалбал тухайн нам, эвслийн бүлгийн үйл ажиллагаа дуусгавар болсонд тооцно. Нам тарсан буюу намууд эвслээ цуцалсан тухай шийдвэрийг; энэхүү шийдвэр гарснаас хойш 72 цагийн дотор Улсын Их Хурлын чуулганы хуралдаан дээр, чуулган хуралдаагүй үед энэхүү шийдвэр гарвал ээлжит чуулган эхэлсэн өдрөөс хойш 72 цагийн дотор чуулганы хуралдаан дээр тус тус мэдэгдэнэ.		17.8.Улсын Их Хурлын гишүүд хамтран Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгээс өөр зохион байгуулалтын аливаа хэлбэр үүсгэхийг хориглоно.  31.12.Бүлгийн даргыг чөлөөлөх, огцруулах, шинээр томилох асуудлыг бүлгийн нийт гишүүдийн олонхын саналаар шийдэж, шийдвэрээ Улсын Их Хурлын даргад бичгээр ирүүлнэ. Улсын Их Хурлын дарга уг шийдвэрийг нэгдсэн хуралдаанд уншиж сонсоно.	
Намын бүлгийн эрх, үүрэг	18.1.Улсын Их Хурал дахь бүлэг дараах эрх, үүрэгтэй:  1/Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцэж байгаа хуулийн болон Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн үндэслэл, бодлогын талаар тус тусын санал, дүгнэлт гаргах;  2/чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах санал гаргах;  3/Улсын Их Хурлын чуулганы хуралдааны үед завсарлага авах;	22.1.Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг дараах эрх, үүрэгтэй:  22.1.1.Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж байгаа хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн талаар тус тусын санал, дүгнэлт гаргах, тухайн асуудал хариуцсан Байнгын хорооны хуралдаан болон нэгдсэн хуралдаанд оруулах;  22.1.2.чуулган, Байнгын хорооны үйл ажиллагаанд өөрийн бүлгийн гишүүдийг татан оролцуулж, хуралдааны дэгийг чанд захиулах;	27.1.Бүлгийн дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:  27.1.1.хэлэлцэж байгаа хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, төрийн гадаад, дотоод бодлогын асуудлаар бодлого, байр сууриа тодорхойлж санал, дүгнэлт гарган зохих Байнгын хорооны, эсхүл нэгдсэн хуралдаанаар шууд хэлэлцүүлэх;  27.1.2.ээлжит чуулганаар хэлэлцэх асуудал, түүний дарааллын талаар Улсын Их Хурал болон Улсын Их Хурлын даргад саналаа илэрхийлэх;	33.1.6.бүлгийн төсвийг захиран зарцуулах, гүйцэтгэлийг үнэн зөв мэдээлэх;  33.1.7.нэгдсэн болон Байнгын хорооны үйл ажиллагаанд өөрийн бүлгийн гишүүдийг оролцуулах, хуралдааны ирцийг хангах, хуралдааны дэгийг чанд захиулах;  33.1.8.хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан ажлын хэсэг байгуулж ажиллуулах;  33.1.9.бүлгийн ажлын албаны ажилтныг ажилд томилох, чөлөөлөх.



		<p>4/Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийг чанд сахиу;</p> <p>5/чуулган, Байнгын хорооны үйл ажиллагаанд өөрийн бүлгийн гишүүдийг татан оролцуулах;</p> <p>6/бүлгийн төсвийн гүйцэтгэлийг үнэн зөв мэдээлэх;</p> <p>7/Байнгын хорооны бүрэлдэхүүний талаар Улсын Их Хурлын даргатай зөвшилцөх;</p> <p>8/Улсын Их Хурлын зохион байгуулалтын үйл ажиллагаатай холбогдсон саналаа Улсын Их Хурал, Байнгын хороонд оруулах.</p> <p>18.2.Улсын Их Хурал дахь намын бүлгийн бусад эрх, үүргийг Улсын Их Хурал тогтоож болно.</p>	<p>4/Улсын Их Хурлын чуулган, Байнгын хорооны хуралдааны үед завсарлага авах;</p> <p>5/бүлгийн төсвийн гүйцэтгэлийг үнэн зөв мэдээлэх;</p> <p>6/Байнгын хорооны бүрэлдэхүүний талаар Улсын Их Хурлын даргатай зөвшилцөх;</p> <p>7/Улсын Их Хурлын үйл ажиллагаатай холбогдсон саналаа Улсын Их Хурал, Байнгын хороонд оруулах;</p> <p>8/чуулганаар хэлэлцэж буй асуудлаар нам, эвслийн бүлгийн байр суурийг боловсруулах ажлын хэсэг байгуулж ажиллуулах.</p> <p>18.2.Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн бусад эрх, үүргийг Улсын Их Хурал хуулиар тогтоож болно.</p> <p>18.3.Улсын Их Хуралд 8-аас доош суудал эзэлсэн нам, эвслийг төлөөлж байгаа Улсын Их Хурлын гишүүн дараах эрх, үүрэгтэй:</p> <p>1/Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааны дэгийг сахиу;</p>	<p>22.1.3. Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах санал гаргах;</p> <p>22.1.4. Улсын Их Хурлын нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааны үед завсарлага авах;</p> <p>27.1.5. Байнгын, дэд, түр хорооны бүрэлдэхүүний талаар Улсын Их Хурлын даргатай зөвшилцөх;</p> <p>27.1.6./Энэ заалтыг 2010.12.30-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/</p> <p>27.1.7. бүлгийн төсвийг захиран зарцуулах, гүйцэтгэлийг үнэн зөв мэдээлэх;</p> <p>27.1.8. нэгдсэн болон Байнгын хорооны үйл ажиллагаанд өөрийн бүлгийн гишүүдийг оролцуулах, хуралдааны ирцийг хангах, хуралдааны дэгийг чанд сахиулах;</p> <p>27.1.9. хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан ажлын хэсэг байгуулж ажиллуулах;</p> <p>27.1.10. бүлгийн ажлын албаны ажилтныг ажилд томилох, чөлөөлөх.</p>	<p>27.1.3. нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах санал гаргах;</p> <p>27.1.4. нэгдсэн болон Байнгын, дэд, түр хорооны хуралдааны үед тухайн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан завсарлага авах;</p> <p>27.1.5. Байнгын, дэд, түр хорооны бүрэлдэхүүний талаар Улсын Их Хурлын даргатай зөвшилцөх;</p> <p>27.1.6./Энэ заалтыг 2010.12.30-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/</p> <p>27.1.7. бүлгийн төсвийг захиран зарцуулах, гүйцэтгэлийг үнэн зөв мэдээлэх;</p> <p>27.1.8. нэгдсэн болон Байнгын хорооны үйл ажиллагаанд өөрийн бүлгийн гишүүдийг оролцуулах, хуралдааны ирцийг хангах, хуралдааны дэгийг чанд сахиулах;</p> <p>27.1.9. хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан ажлын хэсэг байгуулж ажиллуулах;</p> <p>27.1.10. бүлгийн ажлын албаны ажилтныг ажилд томилох, чөлөөлөх.</p>
--	--	--	---	--	---

	2/Байнгын хорооны бүрэлдэхүүнд орох тухай асуудлаа Улсын Их Хурлын даргатай зөвшилцөх;  3/Улсын Их Хурлын зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон саналаа Улсын Их Хурал, харьяалагдах Байнгын хороонд оруулах.				
Цөөнх	28.1.Улсын Их Хурлын чуулганы хуралдааны /цаашид “хуралдаан” гэх/ ажиллагаа хууль дээдлэх, дэгээ чанд сахиx, асуудлыг чөлөөтэй хэлэлцэж, цөөнхийн санаа бодлыг хүндэтгэн олонхийн саналаар шийдвэрлэх зарчимд үндэслэнэ.	19.1.Улсын Их Хурлын нийт гишүүний олонхи буюу 38-аас дээш суудал авсан нам буюу эвслийг Улсын Их Хурал дахь олонхи /цаашид “олонхи”/-д тооцно.  19.2.Улсын Их Хурлын нийт гишүүний 39-өөс доош суудал авсан нам буюу эвслийн бүлэг, гишүүнийг Улсын Их Хурал дахь цөөнх /цаашид “цөөнх”/-д тооцно.	23.1.Улсын Их Хурлын нийт гишүүний олонхи буюу 39 ба түүнээс дээш суудал авсан нам буюу эвслийг Улсын Их Хурал дахь олонхи /цаашид “олонхи”/-д тооцно.  23.2.Улсын Их Хурлын нийт гишүүний 38-аас доош суудал авсан нам буюу эвслийн бүлэг, гишүүнийг Улсын Их Хурал дахь цөөнх /цаашид “цөөнх”/-д тооцно.	3.2.Улсын Их Хурлын үйл ажиллагаа нь хараат бус, нээлттэй, ил тод, хариуцлагатай, иргэдэд хүртээмжтэй байх бөгөөд асуудлыг тал бүрээс нь хэлэлцэж цөөнхийн саналыг хүндэтгэн үзэж олонхийн саналаар шийдвэрлэх зарчимд тулгуурлана.  /Энэ хэсгийг 2010.12.30-ны өдрийн хуулиар нэмсэн/	3.4.Улсын Их Хурлын үйл ажиллагаа нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан зарчимд нийцсэн, бие даасан, нээлттэй, ил тод байх, цөөнхийн саналыг хүндэтгэн асуудлыг олон талт үзэл бодлын үүднээс чөлөөтэй хэлэлцэж, олонхын саналаар шийдвэрлэх зарчимд үндэслэнэ.
				8.1. Сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд 39 ба түүнээс дээш суудал авсан нам, эвслийг Улсын Их Хурал дахь олонхи (цаашид “олонхи” гэх) гэнэ.  /Энэ хэсэгт 2010.12.30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/  8.2. Сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд 38 ба түүнээс доош суудал авсан нам, эвсэл, гишүүнийг цөөнх (цаашид “цөөнх” гэх) гэнэ.	11.1. Сонгуулийн дүнгээр Улсын Их Хуралд 39 ба түүнээс дээш суудал авсан нам, эвслийг Улсын Их Хурал дахь олонх /цаашид “олонх” гэх/ гэнэ.  11.2. Аль ч нам, эвсэл олонх болоогүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн, ийнхүү зөвшилцөж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн Үндсэн хуулийн 2 Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу олонхыг бүрдүүлнэ.

УИХ-ын дэд дарга		<p>27.1.Улсын Их Хурлын тухайн сонгуулийн үр дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс Улсын Их Хурлын дэд даргыг сонгоно.</p> <p>27.3.Улсын Их Хурлын дэд дарга нар дараахь нийтлэг чиг үүрэгтэй:</p> <p>27.3.1.Улсын Их Хурлын Байнгын болон бусад хороод, нам, эвслийн бүлэг, ажлын хэсгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;</p>	<p>/Энэ хэсэгт 2010.12.30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</p> <p>8.3.Улсын Их Хурал дахь олонхи, цөөнхийн авсан суудлыг зөвхөн тухайн нам, эвслээс нэр дэвшин сонгогдсон гишүүдийн тоогоор тодорхойлох бөгөөд үнд бие даан нэр дэвшиж сонгогдсон гишүүнийг оруулж тооцохгүй.</p> <p>12.1.Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс Улсын Их Хурлын дэд даргыг сонгоно.</p> <p>12.3.Энэ хуулийн 26.4-т зааснаар нам, эвслийн бүлэг тарсан бол тухайн бүлгээс сонгогдсон дэд даргыг чөлөөлөгдсөнд тооцож, энэ тухай тогтоол батлагдсанд тооцно.</p> <p>/Энэ хэсэгт 2010.12.30, 2012.12.21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</p> <p>12.4.Улсын Их Хурлын дэд дарга дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>12.4.1.Байнгын, дэд, түр хороо, нам, эвслийн бүлгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;</p>	<p>11.3.Энэ хуулийн 11.1, 11.2-т зааснаас бусад Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг, гишүүнийг Улсын Их Хурал дахь цөөнх цаашид “цөөнх” гэх/ гэнэ.</p> <p>15.1.Улсын Их Хурлын дэд даргыг Улсын Их Хурлын тухайн сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс нэр дэвшүүлэн, илээр санал хурааж сонгоно. Хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай тогтоол баталсанд тооцно.</p> <p>15.2.Энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу гишүүний бүрэн эрхийг нь түдгэлзүүлсэн, 10 дугаар зүйлд заасны дагуу гишүүний бүрэн эрх нь дуусгавар болсноос гадна өөрийнх нь хүсэлтээр, эсхүл нэр дэвшүүлсэн нам, эвслийн бүлгийн хүсэлтээр Улсын Их Хурлын дэд даргыг үүрэгт ажлаас нь чөлөөлж, огцруулна.</p> <p>15.3.Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг тарсан бол тухайн бүлгээс нэр дэвшүүлж сонгосон дэд даргыг чөлөөлсөн тухай Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцно.</p>
------------------	--	---	--	---

				<p>12.4.2.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдааны ирц бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>12.4.3.Улсын Их Хурлын үйл ажиллагааны дэг, гишүүний ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>12.4.4.Улсын Их Хурлын даргаас даалгасан бусад чиг үүрэг;</p> <p>12.4.5.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.</p> <p>12.5.Улсын Их Хурлын даргын түр эзгүйд түүний даалгаснаар дэд дарга үүргийг нь хэрэгжүүлнэ.</p>	<p>15.4.Улсын Их Хурлын дэд дарга дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:</p> <p>15.4.1.Байнгын, дэд, түр хороо, нам, эвслийн бүлгийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;</p> <p>15.4.2.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдааны ирц бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;</p> <p>15.4.3.Улсын Их Хурлын үйл ажиллагааны дэг, гишүүний ёс зүйн хэм хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих;</p> <p>15.4.4.Улсын Их Хурлын даргаас хуваарилсан болон даалгасан чиг үүрэг;</p> <p>15.4.5.хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.</p> <p>15.5.Улсын Их Хурлын даргын түр эзгүйд түүний даалгаснаар дэд дарга үүргийг нь хэрэгжүүлнэ.</p>
--	--	--	--	---	--

UIH.MN  
СУДАЛГААНЫ САН

<p><b>УИХ-ын даргын дэргэдэх Зөвлөл</b></p>		<p>14<sup>1</sup>.1. Улсын Их Хурлын даргын дэргэд дор дурдсан бүрэлдэхүүнтэй Зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ ажиллана:</p> <p>14<sup>1</sup>.1.1. Улсын Их Хурлын дэд дарга;</p> <p>14<sup>1</sup>.1.2. Байнгын хорооны дарга;</p> <p>14<sup>1</sup>.1.3. нам, эвслийн бүлгийн ахлагч.</p> <p>14<sup>1</sup>.2. Зөвлөл дараах чиг үүрэгтэй:</p> <p>14<sup>1</sup>.2.1. Улсын Их Хурлын чуулганаар долоо хоногийн хэлэлцэх асуудлыг зөвшилцөх;</p> <p>14<sup>1</sup>.2.2. шаардлагатай тохиолдолд нам, эвслийн бүлгийн хуралдах хуваарьт өдрөөс бусад ажлын өдөр хуралдах Улсын Их Хурлын нэгдсэн хуралдааны хуваарийг тогтоох;</p> <p>14<sup>1</sup>.2.3. Байнгын болон дэд хороо, нам, эвслийн бүлгийн хуралдааны хуваарь тогтоох;</p> <p>14<sup>1</sup>.2.4. Улсын Их Хурлын дотоод үйл ажиллагаатай холбогдолтой бусад асуудал.</p> <p>14<sup>1</sup>.3. Зөвлөлийн ажиллах журмыг Улсын Их Хурлын дарга тогтооно.</p>	<p>11.3. Нам, эвслийн бүлэг, Байнгын хороодын үйл ажиллагаа, Улсын Их Хурлын хяналт шалгалтын ажлыг уялдуулан зохицуулах, нам, эвслийн бүлэг, Байнгын хороодын санал болон хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хугацааг харгалзан ээлжит болон ээлжит бус чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал тогтоох, тухайн долоо хоногт чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлын тов, дарааллыг батлах, Улсын Их Хурлын төсөв болон Улсын Их Хурлын дотоод үйл ажиллагаатай холбогдолтой бусад асуудлыг зөвшилцөх чиг үүрэг бүхий Зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ Улсын Их Хурлын даргын дэргэд ажиллана.</p> <p>/Энэ хэсэгт 2010.12.30-ны өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан/</p> <p>11.4. Энэ хуулийн 11.3-т заасан Зөвлөлийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын дэд дарга, нам, эвслийн бүлгийн дарга, Улсын Их Хуралд суудал бүхий намын дарга - Улсын Их Хурлын гишүүн, Байнгын, түр хороодын дарга орно.</p>	<p>14.3. Нам, эвслийн бүлэг, Байнгын хороодын үйл ажиллагаа, Улсын Их Хурлын хяналт шалгалтын ажлыг уялдуулан зохицуулах, нам, эвслийн бүлэг, Байнгын хороодын саналыг харгалзан ээлжит болон ээлжит бус чуулганаар хэлэлцэх асуудлын дараалал тогтоох, тухайн долоо хоногт чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлын тов, дараалал, Улсын Их Хурлын төсөв болон Улсын Их Хурлын дотоод үйл ажиллагаатай холбогдолтой бусад асуудлыг зөвшилцөх чиг үүрэг бүхий Зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ Улсын Их Хурлын даргын дэргэд ажиллана.</p> <p>14.4. Зөвлөлийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын дарга, дэд дарга, нам, эвслийн бүлгийн дарга, Байнгын хороодын дарга, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга /цаашид “Ерөнхий нарийн бичгийн дарга” гэх/ орно. Шаардлагатай бол Зөвлөлийн хурлыг өргөтгөсөн бүрэлдэхүүнтэй хийж болно.</p> <p>14.5. Зөвлөлийн ажиллах журмыг Улсын Их Хурлын дарга батална.</p>
---	--	--	---	---

				<p>/Энэ хэсэгт 2012.12.21-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</p> <p>11.5.Зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Улсын Их Хурлын дарга батална.</p> <p>11.6.Зөвлөлөөс баталсан чуулганы хуралдааны тов, хэлэлцэх асуудлын чиглэл, дарааллыг нам, эвслийн бүлэг, Байнгын, дэд, түр хороод, ажлын хэсэг дагаж мөрдөх үүрэгтэй.</p> <p>/Энэ хэсэгт 2010.12.30-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/</p>	<p>14.6.Зөвлөлийн хуралдаанаар зөвшилцсөн чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлын тов, дарааллыг нам, эвслийн бүлэг, Байнгын, дэд, түр хороод, ажлын хэсэг дагаж мөрдөх үүрэгтэй.</p>
--	--	--	--	--	---





<p><b>Бүлгийн ажлын алба</b></p>	<p>17.4.Улсын Их Хурал дахь намын бүлэг орон тооны ажилтантай байж болно. Намын бүлэг тухайн бүлгийн 2 гишүүнд нэг ажилтан байхаар тооцсон орон тооны ажилтантай байж болно. Намын бүлгийн гишүүдийн тоог харгалзан унаа, албан томилолт, бичиг хэргийн зардал, ажилтны цалингийн санг Улсын Их Хурлын төсөвт тусгана. Намын бүлэг батлагдсан төсвөө Улсын Их Хурлаас баталсан журмын дагуу зарцуулна.</p>	<p>17.9.Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг 2 гишүүнд орон тооны нэг ажилтан байхаар тооцож тогтоосон ажлын албатай байж болно. Ажилтнууд нь тухайн нам, эвслийн бүлгийн ажлын албанд харьяалагдана.</p>	<p>21.10.Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлэг 2 гишүүнд орон тооны нэг ажилтан байхаар тооцож тогтоосон ажлын албатай байж болно. Ажлын албаны дотоод зохион байгуулалтын асуудлыг дүрмээр зохицуулна.</p>	<p>27.2.Бүлэг нь бодлогоо боловсруулах, зохион байгуулалтын тусалцаа авах чиг үүрэг бүхий <b>ажлын албатай байх</b> бөгөөд түүний гүйцэтгэх үүргийг нь бүлгийн дүрмээр зохицуулна. Бүлгийн ажлын албаны ажилтны тоо тухайн бүлгийн гишүүдийн тооны хоёрны нэгтэй тэнцүү байх бөгөөд хэрэв бүлгийн гишүүдийн тоо нь сондгой байгаа тохиолдолд дараагийн бүхэл тэгш тооноос тооцно.</p>	<p>33.2.Бүлэг нь бодлогоо боловсруулахад нь зохион байгуулалтын тусалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын албатай байх бөгөөд түүний гүйцэтгэх үүргийг бүлгийн дүрмээр зохицуулна. Бүлгийн ажлын албаны ажилтны тоо тухайн бүлгийн гишүүдийн тооны хоёрны нэгтэй тэнцүү байх бөгөөд хэрэв бүлгийн гишүүдийн тоо 23 ба түүнээс доош бол тухайн бүлгийн ажлын албаны ажилтны тоо 12 хүртэл байна.</p>
	<p>Төсвийн зарцуулалтад Дотоод асуудлын байнгын хороо хяналт тавина.</p>	<p>17.10. Нам, эвслийн бүлэг батлагдсан төсвөө зохих журмын дагуу зарцуулах бөгөөд түүнд Төсвийн зарлагын хяналтын дэд хороо хяналт тавина.</p>	<p>21.12. Нам, эвслийн бүлгийг ажиллах нөхцөлөөр хангах асуудлыг Улсын Их Хурлын Тамгын газар хариуцна.</p>	<p>27.3.Бүлгийг ажиллах нөхцөл бололцоогоор хангах асуудлыг Улсын Их Хурлын Тамгын газар хариуцах ба ажлын албаны цалин, унаа, албан томилолт, холбоо, бичиг хэргийн зардлыг Улсын Их Хурлын төсөвт тусгаж санхүүжүүлнэ.</p>	<p>33.3.Бүлгийг ажиллах нөхцөл бололцоогоор хангах асуудлыг Тамгын газар хариуцах ба ажлын албаны цалин, унаа, албан томилолт, холбоо, бичиг хэргийн зардлыг Улсын Их Хурлын төсөвт тусгаж санхүүжүүлнэ.</p>
	<p>Аль ч намын бүлэгт харьяалагдаагүй Улсын Их Хурлын гишүүнд Тамгын газрын холбогдох ажилтан тусалцаа үзүүлнэ.</p>	<p>17.11. Нам, эвслийн бүлгийг ажиллах нөхцөлөөр хангах асуудлыг Улсын Их Хурлын Тамгын газар хариуцна.</p>	<p>21.13. Нам, эвслийн бүлэг Улсын Их Хурлын бүтцийн хэсгийн хувьд эрхлэх ажлаа намынхаа төв байгууллагын удирдлагын өмнө шууд хариуцахгүй.</p>	<p>27.4.Бүлэг Улсын Их Хурлын бүтцийн хувьд эрхлэх ажлаа намын дээд, төв, гүйцэтгэх байгууллагын өмнө шууд хариуцахгүй.</p>	<p>33.4.Бүлэг Улсын Их Хурлын бүтцийн хувьд эрхлэх ажлаа намын дээд, төв, гүйцэтгэх байгууллагын өмнө шууд хариуцахгүй.</p>
	<p>17.13. Нам, эвслийн бүлэг Улсын Их Хурлын бүтцийн хэсгийн хувьд эрхлэх ажлаа намынхаа төв байгууллагын удирдлагын өмнө шууд хариуцахгүй.</p>				<p>33.5.Бүлгийн төсвийн зарцуулалтад Төсвийн зарлагын хяналтын дэд хороо хяналт тавина.</p>